



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**НЭГДСЭН ХУРАЛДААН**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

---

## НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Даваа гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	<b>1</b>
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-12
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	46-76
<hr/>	
1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	13-48
2.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	48-60
3.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг	60-62
4.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	62-68
5.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	68-76

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
07 дугаар сарын 03-ны өдөр /Даваа гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 22 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Ё.Баатарбилэг, Э.Бат-Амгалан, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Г.Ганболд, Ц.Даваасүрэн, Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: С.Амарсайхан, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярсайхан, Ц.Мөнхцэцэг;

Тасалсан: Б.Чойжилсүрэн.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатараас албан бичиг ирүүлснийг танилцуулав.

**Нэг.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Г.Энхтайван, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга

С.Заяадэлгэр, Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга С.Янжинхорлоо, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Д.Ганбат, Д.Өнөрболор, Г.Дамдинням, С.Ганбаатар, О.Цогтгэрэл, Б.Баттөмөр, А.Адъяасүрэн, Т.Энхтүвшин, М.Оюунчимэг, Ж.Батжаргал, Ч.Ундрам, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, судлаач, доктор Э.Гэрэлт-Од, судлаач Д.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

*Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав./Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал/*

### **Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг нэмэх:

“19.4.Нам Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороотой байж болно. Хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ.

19.5.Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгохдоо энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.3-т заасныг баримталж, тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж, холбогдох журмаар тогтоосон бусад шаардлагад үндэслэнэ.

19.6.Энэ хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг намын төлөөллийн төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	18
Бүгд:	47

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг” гэснийг “сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /С1 х Т1/ хэсгийг дараагийн жилд” гэж, 34.5.3 дахь заалтын “өгсөн бол хандивыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн” гэснийг “хүлээн авснаа мэдсэнээс хойш ажлын арван өдрийн” гэж, 34.6.5 дахь заалтын “төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, бусад удирдах албан тушаалтан” гэснийг “төлөөлөн удирдах зөвлөлийн дарга” гэж тус тус өөрчилж, 34.6.8 дахь заалтын “нь илэрхий” гэснийг болон 34.5.4 дэх заалтыг хасаж, доор дурдсан агуулгатай 34.5.5, 34.12, 34.13 дахь хэсэг нэмэх:

“34.5.5.мөнгөн бус хандив авч байгаа тохиолдолд хандивлагчтай хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

34.12.Хуулийн этгээд намд хандив өгсөн бол хандивын хэмжээ, зориулалтыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайландаа тусгана.

34.13.Намын санхүүгийн тайланд аудит хийхээр гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хандивын талаарх баримт, мэдээллийг хандивлагчаас гаргуулан авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 18

Бүгд: 48

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “, эсхүл ил болгоогүй” гэснийг болон 42.4 дэх хэсгийг хасаж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Нам энэ хуулийн 34.5.3-т заасны дагуу хандивыг шилжүүлээгүй бол тухайн нам хууль бусаар авсан хандивыг хоёр дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө. Ийнхүү төлөх шийдвэрийг сонгуулийн төв байгууллага гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 17

Бүгд: 48

64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал:*

**Г.Занданшатар:** 1.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд” гэсний дараа “зөрчлийг арилгах хүртэл” гэж, 21.4 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний дараа “хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүх” гэж, 21.5 дахь хэсгийн “дуусах хүртэл намыг” гэсний дараа “идэвхтэй, эсхүл” гэж тус тус нэмж, 21.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж өөрчилж, 21.6 дахь хэсгийг хасаж, 21.1, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Улсын дээд шүүх сонгуулийн төв байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэрийг гаргана.

21.3.Энэ хуулийн 21.1.1-д заасан зөрчил гаргасан намын эрх бүхий байгууллага сонгуульд оролцох шийдвэр гаргаж, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлсэн, эсхүл энэ хуулийн 21.1.2, 21.1.3-т заасан зөрчлөө арилгасан талаар холбогдох нотлох баримтыг сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 17  
Бүгд: 48  
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“31 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт**

31.1.Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.

31.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

31.4.Намд төрийн санхүүжилт олгох, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг хянах, дүгнэлт гаргах, тайлагнах, нийгэд мэдээлэх, намын баримт бичиг, мэдээллийг цахим хуудаст байршуулах, шинэчлэх, хариуцлага тооцохтой холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн төрийн аудитын байгууллагын саналыг харгалзан сонгуулийн төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 17  
Бүгд: 48  
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дэх хэсгийн “4 дүгээр сард” гэснийг “05 дугаар сард” гэж, “зохих тоогоор” гэснийг “тухай бүр эмхэтгэж” гэж, 43.8 дахь хэсгийн “иргэний, овог, нэр, оршин суугаа” гэснийг “иргэний овог, нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр, оршин байгаа” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 18  
Бүгд: 48  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулав.*

**1.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:**

**Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:*

**Г.Занданшатар:** Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын санхүүгийн тайлан гаргах, тайланг нийтэд мэдээлэх, намыг идэвхгүйд тооцохтой холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн өдрөөс дагаж мөрдөнө” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32  
Татгалзсан: 16  
Бүгд: 48  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:*

**Г.Занданшатар:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн хөрөнгө авсан бол тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ авсан бол хууль бусаар авсан хөрөнгө, орлогыг хурааж хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 17  
Бүгд: 48  
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналыг найруулгын засвартайгаар дэмжлээ.

**3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:*

**Г.Занданшатар:** Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:



**“1 дүгээр зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмсүгэй:

“3.2.Улс төрийн намыг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг намын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, намын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг Улс төрийн намын тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 17  
Бүгд: 48  
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**4.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:*

**Г.Занданшатар:** Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

**“1 дүгээр зүйл.**Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 85.6 дахь хэсэг нэмсүгэй:

“85.6.Улсын дээд шүүхийн Тамгын газрын бүтэц, орон тоог ажлын ачаалал, онцлогийг харгалзан тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн батална. Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 25.8.8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 16  
Бүгд: 47  
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

*“Улс төрийн намын тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал:*

**Г.Занданшатар:** Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс хойш энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах, төсвийг шийдвэрлэх, холбогдох журмыг батлахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо /П.Дэлгэрнаран/-нд тус тус даалгасугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 16  
Бүгд: 47  
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналыг найруулгын засвартайгаар дэмжив.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, судлаач, доктор Э.Гэрэлт-Од, судлаач Д.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооноос гаргасан, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 21  
Бүгд: 45  
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Байнгын хорооноос гаргасан, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 18  
Бүгд: 44  
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, Монголын үндэсний бөхийн холбооны тэргүүн Ц.Магалжав, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Д.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяа нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монголын үндэсний бөхийн холбооны тэргүүн Ц.Магалжав, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Д.Мөнхболд нар хариулж, тайлбар хийв.

*Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ж.Сүхбаатар нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “даян аварга;” гэсний дараа “даян аварга цолтой бөх ес даван түрүүлбэл дархан аварга;” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 17  
Бүгд: 43  
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ж.Сүхбаатар нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхийн” гэснийг “Бөхийн цолны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 19  
Бүгд: 42  
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ж.Сүхбаатар нарын гаргасан, Төслийн гарчгийн “өөрчлөлт” гэснийг “нэмэлт” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн ““11,” гэснийг “10,11,” гэж өөрчилсүгэй.” гэснийг ““11” гэсний өмнө “10,” гэж нэмсүгэй.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 16  
Бүгд: 43  
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

*Уг асуудлыг 18 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

**Тав.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх итгэлийг хууль санаачлагч, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Д.Батлут нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 16  
Бүгд: 37

56.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 4 цаг 06 минут үргэлжилж, 73 гишүүнээс 59 гишүүн хүрэлцэн ирж, 80.8 хувийн ирцтэйгээр 18 цаг 08 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр,  
Даваа гараг Төрийн ордон “Их  
хуралдай” танхим 14 цаг 22 минут.

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 7 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал танилцуулъя.

Нэгдүгээрт Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2022 он төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлэг.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг,

Жендерийн эрх тэгш байдлыг байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг,

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна,

тавдугаарт, төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудалтай оръё.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу хэлэлцэх асуудлыг хойшлуулах, асуудал нэмэх горимын санал гаргах бол 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатараас албан бичиг ирүүлсэн байна.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн алга байна.

Ийм учраас хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Индэрт урьж байна.

**Б.Жавхлан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн та бүхэнд танилцуулж байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллага төсөл

төрийн сангийн 58, Засгийн газрын тусгай сангийн 22, төрийн өмчийн ААН-ийн 140, орон нутгийн өмчийн ААН-ийн 428 байгууллагын тайланг хамрууллаа. Дэлхий нийтийг хамарсан цар тахал геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт урд хөршид тогтоосон хөл хорио улс орнуудын төв банкуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлого зэрэг нь 2022 онд инфляц төлбөрийн тэнцлээр дамжин манай улсын эдийн засагт томоохон сорилт болсон билээ тухайлбал инфляц 16.9 хувьд хүр хүрч 2009 оноос хойших хамгийн өндөр түвшинд, гадаад валютын албан нөөц 2.6 тэрбум ам.долларт хүрч 2016 оноос хойших хамгийн бага түвшинд улмаар эдийн засаг 2022 оны 1 дүгээр улиралд 3.9 хувиар агшаад байсан. Гэсэн хэдий ч Засгийн газраас шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд 22 оны эцэст эдийн засаг 4.8 хувиар өсөж гадаад валютын албан нөөц 3.4 тэрбум долларт хүргэж инфляцыг 13.2 хувьд хүргэн тогтворжууллаа. Монгол Улсын цэцэрлэгийн насны 303 мянган хүүхдийн 141 мянга гаруй нь нийслэлд амьдарч байгаагаас 34 мянга орчим хүүхэд сугалааны улмаас цэцэрлэгт хамрагдаж чадаагүй байлаа. Цэцэрлэгийн сугалааг халж И Монголиа цахим системээр бүртгэж байгууллагын түрээсийн цомцог гэр зэргээр цэцэрлэгийн олон хэлбэрийг бий болгож хувьсах болон хоолны зардлыг нэмэгдүүлэн 28793 хүүхдийг нэмж хамрууллаа.

Хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгалын сангаас олгож байгаа 469.2 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлж тэтгэврийн доод хэмжээ 350 мянга байсныг 500 мянган төгрөг болгосон. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус

өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоог улс орон даяар 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зохион байгуулж 852.8 мянган иргэнийг хамрууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2022 онд дэд бүтэц, бүтээн байгуулалт, нийгмийн чиглэлийн 1062 төслийг хэрэгжүүлж нийтдээ 1.5 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдсэнээр эдийн засгийг дэмжиж хувийн хэвшлийн 1580 гаруй ААН-ийн 37 мянга гаруй ажлын байрыг хадгалж, үүний үндсэн дээр нийгмийн салбарт 17 сургууль, 32 цэцэрлэг, 9 дотуур байр, 4 сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 2 музей, 11 соёлын төв, 7 спорт заал, 4 спорт цогцолбор, 20 хөдөлмөр нийгэм хамгааллын төсөл эдийн засгийн салбарт 34 авто зам, 6 гүүр байгууламж, 58 инженерийн шугам сүлжээ 16 цахилгаан хангамжийн төсөл 7 дулаан хангамжийн төсөл гэх мэт нийтдээ улсын хэмжээнд 428 төсөл ашиглалтад орлоо. Түүнчлэн нийт 1.8 их наяд төгрөгийн амлалтын дүн бүхий гадаадын зээл тусламжийн 26 төсөл арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж дуусгалаа.

Үүнээс томоохон төслүүдийг дурдвал Улсын 2 дугаар төв эмнэлгийн өргөтгөл шинэчлэл, Эрдэнэтийн ДЦС-ын шинэчлэл, ЗЦГ-ын ойролцоох гүүрэн гарц, эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 5 төсөл цар тахлын үед хариу арга хэмжээ авах Нийгмийн хамгааллын төсөл 2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, Ухаалаг засаг-1 төсөл зэргийг хэрэгжүүлж дуусгасан. Мөн 2022 онд БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлээр Газрын тос боловсруулах үйлдвэр БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр 10 аймгийн төвийн дулааны станц барих, БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл, Европын сэргээн босголт банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Улаанбаатар Дархан чиглэлийн 2 эгнээ зам барих төсөл зэрэг

томоохон төслүүдийг амжилттай санхүүжүүллээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 онд 17.1 их наяд төгрөг, нийт зарлагын ба цэвэр зээлийн дүн 18.1 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөгдсөн дүнгээс 1.8 их наяд төгрөгөөр буурч сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар хуулийн хүрээнд буурууллаа.

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 10.2 их наяд төгрөг, зарлага 11.3 их наяд төгрөг, нийт тэнцэл 10.1 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөгдсөн алдагдлаас 1.2 их наяд төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2 их наяд төгрөгөөр тус тус сайжирсан үзүүлэлт боллоо.

Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

та бүхэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулгатай танилцаж төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбал танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Занданбат:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн тухай хуулийн 8.10.2-т заасан цаглаварт хугацаанд аудит хийж тайланг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүллээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөсөн зорилт хуульд заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэх санхүүгийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль тогтоомжийн холбогдох хууль стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байдалд аудит хийж дүгнэлт гаргахад аудитын зорилт чиглэгдсэн та бүхэнд Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар товч танилцуулъя.

1. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт Монгол Улсын Засгийн газар тайлант онд нэгдсэн төсвийн бодлогоо 9 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорилт дэвшүүлэн ажиллажээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1-д заасан тусгай шаардлагуудыг хангасан байна. Аудитаар Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүнг 17 их наяд 126.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 18 их наяд 159.6 тэрбум төгрөгөөр баталгаажууллаа.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 2 их наяд 891.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1 их наяд 32.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ий 2 хувийг эзэлж байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль түүнд өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад хамаарах 6 их наяд 152.3 тэрбум



төгрөгийн төсөвт өртөгтэй, 1 их наяд 393.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1369 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийж гүйцэтгэлийг хянав.

Улсын Их Хурлаас төрийн хэмнэлтийн тухай хуулийг батлан хэрэгжүүлснээр эрх зүйн орчин бүрдүүлснээр төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, төсвийн алдагдал буурах, төрийн өмчит байгууллагуудын ашигт ажиллагаа нэмэгдэх боломжийг бий болгосон байна.

Гэвч уг хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд хэрэгжилтийг хэрхэн хангасан талаар ил тод тайлагнах, үр дүнг мэдээлэх, зохицуулалтгүй зарим зүйл заалтыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх шаардлага байна.

2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны нэгдсэн төсвийн тайланд хийсэн аудитын дүгнэлт.

Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6618 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд төсвийн 57 ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 40, хязгаарлалттай 17 дүгнэлт өглөө.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт өгсөн болно.

1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлсэн зээлээс олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 1 их наяд 147.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй.

2. Засгийн газрын шийдвэрээр Эрдэнэс Тавантолгой ХК-аас 3 компанид

олгосон 44.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн.

3. Монгол Улсын Хөгжлийн хөгжлийн банкны үнэ цэнэ буурсан буюу чанаргүй зээлийн үлдэгдэл 1 их наяд 496.3 тэрбум төгрөг. Үүнээс 241.8 тэрбум төгрөг муу зээлийн ангилалд шилжсэн.

4. Засгийн газрын тусгай сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 497.1 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй зэрэг нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитын дүгнэлтээс нэн тэргүүнд анхаарах асуудлыг тоймлон танилцуулъя.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-оос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2021-ээс 2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнг бодитой үнэ үнэлэх боломжгүй байна.

төсөл арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгааны нэг болж байна.

Орхигдсон болон олон жил үргэлжилж байгаа төсөл арга хэмжээг богино хугацаанд ашиглалтад оруулах шийдлийг гаргахгүй байгаа нь төсвөөс санхүүжигдсэн 287.6 тэрбум төгрөг нь үр

дүнгүй зарцуулагдах үр дагавар үүсэхээр байна.

ЭМД-ын сан болон нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг эрсдэлгүй байлгах зорилгоор төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулсан боловч сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжийг ашиглаагүй байна. Гадаад дотоодын зээлийн эх үүсвэр болон Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөс иргэн хуулийн этгээдэд олгосон зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд байршуулаагүйгээс хэд хэдэн эх үүсвэрээс давхардуулан зээл аван зээлийн баталгаа чанаргүй болж гэрээний үүргээ хэрэгжүүлэхгүй зээлийн эх үүсвэр бүрдэхгүй байх эрсдэл нь нэмэгдэж байна.

Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд төсвөөс санхүүжих нийгмийн шинж чанартай төсөл арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлуудыг санхүүжүүлж байгаа нь төсвийн нэгдсэн бодлогын зарчмыг алдагдуулж байна. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах мөн төсөвт ачаалал үүсэж буй талаар жил бүр хийгдэж буй аудитын өгсөн дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй зөрчсөн хэвээр байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна.

төрийн аудитын байгууллагаас өмнөх жилүүдэд толилуулсан Монголбанкны санхүүгийн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэн төрийн нийтийн хөрөнгийн дүн мэдээг бүрэн илэрхийлэх боломжийг бүрдүүлэх.

Монгол Улсын Их Хурлаас тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлаагүй хөрөнгө оруулалтын болон нийгмийн шинж чанартай төсөл арга хэмжээг төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа асуудлыг анхаарч хуулиар тодорхой зохицуулах.

Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлээд төсөл, арга хэмжээний явц үр дүнд Засгийн газраас хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг Байнгын хороод хэлэлцэж байх.

Дотоод хяналт хангалтгүйгээс жил бүрийн аудитаар илэрч буй алдаа, зөрчил буурахгүй, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа тул дотоод аудитын эрх зүйн орчныг хуульчилж үйл ажиллагааг төлөвшүүлэх боломжийг бүрдүүлэх.

Аудитын зөвлөмжийн мөрөөр төсвийн ерөнхийлөн захирагчдын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнг харьяалах Байнгын хороод хэлэлцэн дүгнэх эрх зүйн зохицуулалтыг буй болгох.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Улсын Их Хуралд 5 асуудлыг толилуулж, Монгол Улсын ерөнхий сайдад 16, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 5, Сангийн сайдад 14, Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргад 2, Барилга, хот байгуулалтын сайдад 1, төсвийн ерөнхийлөн захирагч нарт 5, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт 3 зөвлөмж өгсөн болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын Шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Монгол Улсын Сангийн сайд Болдын Жавхлан, БОАЖ-ын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Соёлын сайд Чинбатын Номин, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Монгол Улсын сайд нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Ренчиндоржийн Онончимэг, Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат, СЗХ-ны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан, СЕХ-ны дарга Пүрэвээгийн Дэлгэрнаран, Сангийн дэд дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Баярсайханы Солонго, Монгол Улсын ҮХЦ-ийн тамгын газрын дарга Данихүүгийн Баянбилиг, Монгол Улсын Дээд шүүхийн тамгын газрын дарга Содномцэрэнгийн Заяадэлгэр, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг, Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга Нямдоржийн Анхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Төмөрүяагийн Жамбалцэрэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дэд дарга Гэлэгжамцын Энхтайван, УЕП-ын Хэрэг эрхлэх газрын дарга Сүрэнжавын Гансэлэм, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Дашиживаагийн Ариунболд, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Доржсүрэнгийн Мөнхзориг, АТГ-ын тамгын хэлтсийн дарга Заграагийн Баасанням. Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага

зохицуулалтын газрын дарга тэргүүлэх аудитор Ядамын Самбууням, Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Нийслэл дэх төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх тэргүүлэх аудитор Мижиддоржийн Эрдэнэжаргал, татварын ерөнхий газрын дарга Батжаргалын Заяабал, Үндэсний статистикийн хорооны тамгын газрын дарга Бямбасүрэнгийн Лхагва, Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Сангийн яамны Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Нарангийн Мөнхсүх.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй, түүнчлэн төсвийн ерөнхийлөн захирагч нар Засгийн газрын гишүүд нар болон Монгол Улсын Ерөнхий аудитороос асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд.

Тогмидын Доржханд гишүүнээр тасаллаа. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Би Ерөнхий аудитороос ганцхан л зүйл асуух гээд байгаа юм. Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилт шилжсэнтэй холбоотойгоор анхан шатын ялангуяа сумдын Эрүүл мэндийн төв дээр ажилчдадаа цалин нэмсэн гүйцэтгэлээр орсон орлогоо хуваарилсан байдал дээр акт торгууль тавиад байгаа юм. Энэ дээр Аудитын газартай би бас энэ шалгалт шүүлэг явахаас өмнө бас Аудитын газартай бас уулзаж энэ асуудлаар гүйцэтгэлийн санхүүжилтийн бас утга санаа, агуулга, хуулийн зорилго энэ тэр нэлээдгүй зүйлээр бид уулзалт хийж байсан. Тэгсэн хэр нь ээ одоо энэ

2022 оны гүйцэтгэл дээр 2023 онд шалгалт хийхдээ олон ийм улаан канттай бичиг сумын ЭМТ-үүд дээр төвийн дарга нарт нь өгч энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн үндсэн амин сүнс болж байгаа санхүүгээ зарцуулах эрхийг нь ийм боломжгүй болгосон ийм нөхцөл байдал үүссэн юм. Энэ дээр надад яагаад ингэсэн юм. Энэ байдал ер нь ямар байдлаар шийдэгдэх юм бэ гэдэг тал дээр хариулт өгөхгүй юу?

**Г.Занданшатар:** Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат. 83 Наранчимэг. Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч.

**Ц.Наранчимэг:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоотой шилжиж байгаатай холбогдуулж бид ЭМД-ын Ерөнхий газраас энэ санхүүжилттэй холбоотой сургалтуудыг авч нэгдсэн ойлголт чиглэлд хүрсэн гэж бодож байгаа. Энэ жилийн санхүүгийн тайлангийн аудитаар бол, ноднингийн санхүүгийн тайлангийн аудитаар Завхан аймагт ийм асуудал гарсан. Энэ жил бол бид бас энэ асуудлыг өмнөх ЭМД-ын сангийн үйл ажиллагааны тайлан дээр гишүүдийн ярьж байгаа асуудалд дүн шинжилгээ хийж судалж үзэхэд яг энэ төлбөрийн актыг яг энэ санхүүжилтийн үлдэгдэл дээр тавьсан асуудал бол байхгүй байсан. Зүгээр гүйцэтгэл дээр суурилсан санхүүжилтийн тогтолцоотой холбогдуулаад зарим сумдын эмнэлгийн дарга нарын цалинтай холбоотой асуудал дээр нэг аймаг дээр ийм акт тавьсан асуудал бол байсан. Ер нь бол гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо маань үр дүнтэй болсныг аудит юугаар нотолж байна вэ гэхээр ялангуяа одоо эмнэлгүүдийн төсвийн санхүүжилтийн үлдэгдэл бас нэлээдгүй эмнэлгүүд маань бас үлдэгдэлтэй гарч байгаа. Энэ нь бас гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн

тогтолцооны үр дүн юм байна гэж ингэж үзэж байгаа.

### **Г.Занданшатар:**

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн тодруулж асууна.

**Ж.Чинбүрэн:** тэгэхлээр 2023 оноос ийм асуудал байхгүй гэж ойлголоо. Зөв үү би зөв ойлгосон уу? Баярлалаа.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Энэ 2022 оны төсвийн гүйцэтгэл гарсан байна. Энийгээ танилцуулж байна. Энэ төсвийн гүйцэтгэлдээ та бүхэн маань ямар дүгнэлт хийж байна аа? Ер нь энэ төсөв чинь ДНБ-ий зарлага нь 37 байна уу 36 хувьтай, орлого нь 36 хувьтай, зарлага нь 38 хувьтай байгаа шүү дээ ДНБ. Энэ төрийн өмчтэй компаниудыг ингээд нийлүүлээд үзэхээр дэлхий дээр хаана ч байхгүй ийм улс бий болчихоод байгаа шүү дээ манайх чинь. Энэ татвар төлж байгаа энэ бүх ДНБ-ий энэ байгаа юмны 55 хувийг одоо нь энэ төр мэддэг төр авч хэрэгжүүлдэг ийм л ажил болчихоод байгаа. Энэ дээрээ анхаараач ээ. Энэ аудитын дүгнэлт ч гэсэн аягүй мөлгөр байна. Ийм их мөнгөөр хийж байгаа ажлууд чинь ямар ч үр дүн алга. Би энэ 2022 оныг бас Монгол Улсын сүүлийн 10 жил алдагдсан жилүүдийн ахиад нэг нь болчихлоо л гэж үзэж байна. Цахилгааны эх үүсвэрээ шийдэв үү. Шийдсэнгүй. Нөгөө боомтуудад төмөр замаа тавьсан уу, тавьсангүй. Дарханы замтайгаа ноцолдоод л таарлаа шүү дээ. тэрийгээ ч оруулж чадсан ч юм уу, үгүй ч юм уу. Ер нь олигтой ч зам болоогүй юм шиг байна лээ. Тэгээд одоо энэ дунд шатанд шалгаруулж байгаа энэ тендерүүд чинь замаа алдаж байна. Та нар баахан улсын мөнгийг нь нэгтгэж аваачаад, тэгээд тендер, концесс, янз бүрийн юм зарлаад ингээд тараачихдаг. Тэр нь их үр дүнтэй ажил болохгүй байна.

Эхлүүлсэн ажлаа бид нар дуусгах ёстой. Засгийн газар тийм чиг барьж байгаа юм байна гэж ойлгосон. Тухайлбал би Баянхонгор аймаг дээр явагдаж байгаа ажлуудын ганц нэгийг нь хэлье. Улсын төсвөөр баригдсан тэр сургууль, цэцэрлэгүүд бол үнэхээр чанарын шаардлага хангахгүй байна лээ шүү. Ганц нэг юм гэхээс биш. 2, 3 жилийн өмнө барьсан сургууль, цэцэрлэгүүд түрүүчээсээ нураад эхэлж байгаа. Тэгэхэд бусад улс орны сургууль, цэцэрлэгүүд ямар байдаг вэ. Хамгийн чанартай материалаар хамгийн сайн хүүхдүүддээ зориулж хийдэг шүү дээ. Газар хөдлөх үед л бүгд сургууль, цэцэрлэг рүүгээ гүйдэг. Одоо тийм биш. Хамгийн түрүүнд нурж унах барилгууд тэд нар болсон. Энэ дээрээ дүгнэлт юм тавьдаг юм уу, үгүй юм уу? ХАА-н хүмүүсийг ажилтай орлоготой болгоё гээд ХАА-н кластер, ХАА-н дэд кластер гээд хэд хэдэн төслүүдийг хөөцөлдөж байгаад энд тавиулсан.

Ингээд үйлдвэртэй болъё оо тухайлбал ингэний сүүний үйлдвэртэй болъё. Махны үнэ энд ард түмний төлөө анхаарч барьж байгаа юм алга шүү дээ. Үнэ тогтворжуулах хөтөлбөр гээд батлагдсан тэрний үр дүн ноль. Мах нь өнөөдөр энэ жил хэд хүрэв. 20 мянга Улаанбаатар хотод. Энэ Улаанбаатар хот чинь нэг зөвхий даасан хот л байна шүү дээ. Энд тэндгүй түгжэрээтэй. Энэ их мөнгийг хааш нь яаж хийгээд байдаг юм? Үр дүн нь ямар байдаг юм? тэгээд тэр дунд шатанд шалгаруулж байгаа концесс, энэ тендер энэ юман дээр анхаарал тавьдаг юм уу? Хэдхэн компани шалгардаг юм байна лээ шүү дээ. Тэгээд тэр ажил хийж байгаа юмыг нь хар. Хамгийн муу юмыг авчирч өгсөн байгаа юм. Тэр ХАА-н тоног төхөөрөмж нийлүүлж байгаа тэр 2 трактор нь шахаж байж нэг гайгүй юм ирсэн. Бусад нь өнөөдөр агуулахдаа хэвтэж байна шүү дээ. Хэн ч хэрэглэхгүй. Энэ юман дээрээ явж хяналтаа тавь. Улсын Их Хурлын гишүүн бид нар наад төсвийг чинь

баталж өгөөд хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдгаас биш очоод наад юмыг чинь бид нар хийсэн юм шиг ингээд яваад байж чадахгүй ээ.

Ийм их мөнгийг төвлөрүүлчхээд үр дүн ерөөсөө алга. Энэ дээрээ та бүхэн ямар дүгнэлт хийж байна аа? Нарийн ширийн юмыг яриад байвал дуусахгүй юм болно л доо. Би улс орны хэмжээний асуудлыг ярьж байна. Эндээ дүгнэлт хийж байна уу? Ахиад цаашаа энэ маягаар үргэлжлээд байх уу? Хар л даа одоо.

**Г.Занданшатар:** Ерөнхий аудитор 81.

**Д.Занданбат:** Ганбат гишүүний асуултад хариулъя.

Бид нар өнөөдөр Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан гэсэн ийм 2 аудитын дүнг танилцуулж байгаа. Аудитынхаа дүгнэлтээр жишээлбэл нэгдсэн төсвийн гүйцэтгэл дээр бид нар аудитын тайланг гишүүдэд хүргүүлсэн байгаа. Нийтдээ 27 дүгнэлт өгсөн. Засгийн газрын санхүүгийн тайлангаараа 9 дүгнэлт өгсөн байна.

төсвийн гүйцэтгэлээр 13 зөвлөмж, санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр 38 зөвлөмжийг өгч ажилласан. Таны ярьж байгаа асуудлаас голлож сая би дүгнэлт дээрээ хэлсэн. Төсөв бол бас аудит хийж байгаа явцад ч гэсэн тодорхой хэмжээнд алдаа зөрчил төдийлөн бас санасан хэмжээнд хүрч буурахгүй байна. Үүнийгээ төсвийн ерөнхийлөгчийн захирагчдад байдаг дотоод аудитын дунд шатын тэр хяналтын тогтолцоог хууль эрх зүйн орчныг сайжруулах нэн шаардлагатай байна гэж бид нар дүгнэж байгаа.

Дунд шатын хяналт байхгүйгээсээ хамаарч төсвийн хөрөнгө оруулалт урсгал зардал дээр тавигдаж байгаа хяналт бол

төдийлөн хүрч ажиллаж чадахгүй байгаа ийм нөхцөлүүд байгаад байгаа. Сүүлийн 3, 4 жилд бол энэ дотоод аудитыг хууль эрх зүйн орчинтой болгож өгсөн асуудал бол их чухал байна гэдэг дүгнэлтийг хийж байгаа. Товчхондоо ийм байна.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууна.

**Д.Ганбат:** Ингээд асуулт асуухад олигтой хариултгүй юм. Тэрийг чинь мэддэг л дээ би. Гэхдээ хэлж ярьж л байя Монголын ард түмэн бас сонсож байг. Нөгөө талаар бас хэлээд яриад байхаар бас зарим нэг юмаа засаж сайжруулах юм. Тухайлбал тэр хүүхдийн мөнгийг данс болгонд нь хий гэсэн тэрийг хийж байна энэ зөв өв. Энэ мэтчилэнгээр та нар миний хэлж байгаа ярьж байгаа болгоныг хэрэгжүүлээд яваад байвал улс орон ийм байдалд орохгүй шүү дээ. Бас дээр нь нэмээд хэлэхэд одоо тэр шатахууны үйлдвэр чинь газрын тосны үйлдвэр чинь бас л нохойн замаар орж байна уу? Яаж байна? тэр чинь хэзээ орох юм бэ? Ер нь ганц нэг хэрэгтэй юмаа хэлчих л дээ. Ийм юм хийчихлээ гээд.

Энэ хяналт шалгалт их муу байгаа шүү. Энэ аудит ч гэсэн аягүй мөлийсөн юм байна шүү дээ. Ингээд байхаар энэ улс орны ажил яаж сайжрах юм. Ерөөсөө сөрөг хүчин ч гэж бараг байхгүй болчихсон. Хэдэн дагуул намтай энэ улс орон хаашаа яваад байгаа юм бэ? Энэ маягаараа бол энэ татвар төлөгчдийн мөнгө бол тэгээд.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Асуулт үг 2 хамт явж байгаа учраас.

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууж үг хэлнэ.

**Д.Өнөрболор:** төсвийн гүйцэтгэлд хийсэн энэ аудитын тайлангаас харахад хэд хэдэн дүгнэлт байна. 2022 оны төсвөөр бодлогын 9 багц арга хэмжээнд 5.2 их наяд төгрөгийг төлөвлөөд тэгээд

4.4 орчим их наяд төгрөгийг зарцуулсан боловчиг энэний үр дүнгийн тооцоо үр нөлөөг дүгнээгүй байна. Үндсэндээ бол яах вэ тоогоор бол нэг 80 хувийн гэж харагдаж байна. Гэхдээ яг амьдрал дээр бол энийг бодит дүгнэлт дүн шинжилгээ хийгээгүй байна.

Тэгэхээр бид нар бол яг энэ хийсэн ажлаа, тавьсан зорилтоо ер нь хаана явааг мэдэхгүйгээр энэ асуудлыг хэлэлцэж байгаа нь бас учир дутагдалтай гэж харагдаж байна. Тэгээд энэ аудитын тайлангаас дүгнэсэн байж байгаа энэ дүгнэлтийн дотор анхаарал татахаар нэг асуудал нь бол энэ хязгаарлалттай дүгнэлт энэ санхүүгийн үр дүн, санхүүгийн байдалд тавьсан байгаа юм байна. Тэгээд энэ дүгнэлтийн ингээд үндэслэлийг харах юм бол 4 ийм үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт тавьжээ гэж харагдаж байна.

Засгийн газрын энэ гадаад зээлийн эргэн төлөлт хийгдээгүй 1.1 их наяд төгрөг байгаа юм байна. Тэгээд Засгийн газрын шийдвэрээр Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 44.5 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй асуудал байгаа юм байна.

Дараагийнх нь бол Монгол Улсын Хөгжлийн банкны үнэ цэн чанаргүй зээлийн үлдэгдэл 241.8 тэрбум төгрөг муу зээлийн ангилалд шилжсэн, 1.4 тэрбум төгрөг бол үлдэгдэлтэй байгаа юм байна. Засгийн газрын тусгай сангуудаас 497.1 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй зэрэг ингээд нийлээд 3 их наяд төгрөгийн ийм зөрчил илэрчээ. Энэ зөрчлийг хэзээ ямар нөхцөлөөр яг ямар байдлаар арилгах вэ гэж асууя.

2020 онд бол энэ 13.9 их наядын зарлагатай байсан. Төсөв тайлант онд 18.1 их наяд энэ онд бол 20 их наяд даваад явчихсан ийм байдалтай байна. 2020 онд харах юм бол ам.доллартой харьцах энэ төгрөгийн хани 2020 оноос 20 хувиар суларсан ийм үзүүлэлттэй байгаа.

Тэгэхлээр энэ төсвийн зарлагын яг өсөлтийн хэдэн хувь нь яг инфляц энэ ханшийн сулралтай холбоотой асуудал байна вэ? Энэн дээр дүн шинжилгээ хийсэн байна уу? Энэ талаар бас мэдээлэл авъя. Энэ зардлын өсөлт ханшийн сулралд ер нь бас яг яаж нөлөөлсөн юм. Эсрэгээрээ энэ ханшийн сулрал инфляцын өсөлт нь зардлын хэдэн хувийг эзэлж байгаа вэ гэдгийг бас асууя. Тэгээд ер нь эндээс ингээд үзэхэд энэ мөнгөний бодлого төсвийн бодлого уялдаж чадаж байна уу? Ер нь энэ бодлогууд чинь эдийн засагт дэмжлэгээ үзүүлж чадаж байна уу гэж зарим нэг агуулгаараа эрсдэлтэй байна, эргэлзээтэй байна гэж харагдаж байна.

Дараа нь энэ 203 онд шинээр хөрөнгө оруулалтын ажлуудыг тусгаагүй байж байгаа юм. Тэгээд 2022 оны ажлуудыг хугацаандаа хэрэгжээгүй. Гүйцэтгэл нь бол 62.2 хувьтай гарсан байгаа юм байна. Тэгээд энэ удааширч байгаа, хэрэгжээгүй байгаа арга хэмжээний шалтгаануудыг бас асуумаар байна. Ер нь 2024 он руу шилжих хэмжээний ажил төсөл хөтөлбөрүүд байгаа юм уу?

төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталсан. Энэ хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн байдал ер нь яг ямар түвшинд байгаа вэ? Ер нь хэдий хэмжээний хөрөнгийг хэмнэсэн юм бэ? Энэний дүн шинжилгээг бас асуумаар байна. Энэ хөрөнгө оруулалтын нэг хүнд ноогдох дүнгээр Сэлэнгэ аймгийг харах юм бол ер нь үндсэндээ л нэг сүүлээсээ бараг 4-т байгаад байгаа байх байхгүй юу. Тэгэхээр энэ тэгш хуваарилалт ер нь алдагдаад байна уу гэж харагдахаар. Яагаад тэгж байна гээд тэгэхээр энэ ургадаг баялаг тэнд хөдөлмөрлөж байгаа хүмүүсийн хөдөлмөрийн үнэ цэнэ энэ хүнсний хувьсгал хийх энэ бодлого зорилтын хүрээнд энэ үнэлэмжийг нэмэгдүүлэх баялгийн тэгш хуваарилалтыг хийх шаардлагатай байгаа. Тэгэхэд энэ орон нутгаас жилд 80

орчим хөрөнгө оруулалтын ажлын санал ирдэг байж байгаа. Тэрэн дээр.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Гишүүд асуулт асуухдаа яг хариултын эзнийг цохоод асуугаад байвал сайн байна. Тэр сайдаас, тэр аудитроос яг тийм асуулт асууж байна гээд.

Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Аудитын хязгаарлалттай дүгнэлтүүдийн талаар зөрчлийн талаар.

**Б.Жавхлан:** Би төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуултад хариулъя.

Аудитын дүгнэлтийг аудитынхан өөрсдөө хариулах нь зөв байх.

Төсвийн гүйцэтгэл хөрөнгө оруулалт тэр 68 хувь гээд буруу тоо хэлчих шиг боллоо шүү. Өнгөрсөн оны төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл урьд өмнө нь байгаагүй өндөр хувиар гарсан байгаа. 98 хувьтай гарсан байгаа. 1.5 их наяд төгрөгийн гүйцэтгэл хангалттай хийгдсэн гэсэн үг. Энүүгээр дамжаад бид эдийн засгийн маш олон салбаруудыг дэмжиж өсөлтийг хангасан байдаг. Ингээд төсөв, төсвийн харилцаанд орсон, төсвийн гүйцэтгэлд хамрагдсан нийт ААН-үүдээр дамжаад нийтдээ 37.9 мянган ажлын байрыг амжилттай хадгалжээ. Мөн 2022 онд бид яг ковидын үед 2020, 2021 он дамжаад төсвийн хөрөнгө оруулалт гүйцэтгэлийг цахимжуулах энэ төсөл арга хэмжээнүүд маань амжилттай болж 2022 онд яг хэрэглэх гүйцэтгэлээ гаргаж энүүгээр тайлагнах энэ системүүд маань бол маш амжилттай хэрэгжиж ашиглалтад орсон байгаа. Мөн яг хөрөнгө оруулалтын хувьд төр хувийн хэвшлийн түншлэлийн өнгөрсөн 10 гаруй жил явж ирсэн тогтолцоог халж шинэ хуулиа Улсын Их Хурлаар батлуулж авсан. Энэ хууль маань энэ жилээс хэрэгжээд явах ийм учиртай байгаа. Ерөнхийдөө бол 2022 маань санхүү

төсвийн хувьд маш амжилттай жил болсон. Маш амжилттай жил болсон байгаа. Ялангуяа төсөв мөнгөний бодлого маш сайн нийцтэй ажигласан. Мөнгөний бодлого нэлээн хатуу явж ирсэн. Төсвийн хувьд бид нар бол 1.4 их наяд төгрөгийн давсан орлогыг энэ хэмжээгээр зарлагаа нэмэлгүйгээр үндсэн тэнцлээ тэр хэмжээгээр сайжруулж гаргасан гэсэн үг. Алдагдлаа бууруулсан. Өөрөөр хэлбэл мөнгөний бодлого талдаа хатуу бодлого. Төсөв талдаа бид нар маш сайн зардлаа хэмнэж хэмнэлтийн бодлоготой ингэж явсан. Ийм учраас макро түвшний хувьд бол энэ 2 бодлого яв цав нийцэж мөн зорилтот томоохон макро дүнгүүдээ сайн барьж орсон байгаа. Алдагдлаа бууруулсан, төв банкны маань валютын нөөц нэмэгдсэн, төлбөрийн тэнцэл бид бараг 2 тэрбум долларын алдагдалтай гарах болов уу гэж бодож ингэж хүлээлттэй байсан. 700 сая долларын алдагдалтай гарсан байгаа.

Тооцоолж байснаар ялангуяа ОУВС, Дэлхийн банк гээд томоохон олон улсын санхүүгийн байгууллагууд ийм үзүүлэлттэй гарна гэж тооцоолоогүй байсан. Ингээд Засгийн газраас шат дараатай томоохон арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авсны үр дүнд ийм амжилтад хүрсэн гэж хэлье.

**Г.Занданшатар:** 83 Ерөнхий аудиторын орлогч, тэргүүлэх аудитор Наранчимэг.

**Ц.Наранчимэг:** Өнөрболор гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Монгол Улсын Засгийн газраас 2022 онд төсвийн бодлогын 9 багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ арга хэмжээгээ бас бодитой хэрэгжүүлсэн. Гэхдээ аудит юу гэж үзсэн гэхээр

төсвийн гүйцэтгэл маань үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо явагдаж байгаа учраас энэ дэвшүүлсэн зорилтыгоо зарцуулсан хөрөнгөтэйгөө уялдуулж үр дүнг нь дүгнэж тооцож тайлагнаж байх зайлиггүй шаардлага байна гэж үзэж энэ дүгнэлтийг гаргасан байгаа.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн нь бас тодорхой хэмжээгээр төсөв захирагч нарыг хариуцуул хариуцлагажуулсан бас үр дүнтэй бодитой ажил болсон боловч төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт жигд бус байгаагаас 6517 байгууллагад төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээр аудит хийсэн. 61.6 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлсэн, 20.5 тэрбум төгрөгийн 468 зөвлөмж 39.4 тэрбум төгрөгийн 908 албан шаардлага 15.1 тэрбум төгрөгийн 602 төлбөрийн акт, 0.2 тэрбум төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, 87 албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг томилдог эрх бүхий сайд нарт нь төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн байгаа.

Мөн дүгнэлтийн нэг үндэслэл маань сангуудын үлдэгдэл хөрөнгөөр хязгаарласан байгаа. Энэ санхүүгийн 2022 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Боловсролын зээлийн сан дээр 18.7 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. Боловсролын зээлийн сан Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, ХАА-г дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 381.1 тэрбум төгрөгийн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Ийм арга хэмжээнүүдийг авсан байгаа. Хязгаарлалтын үндэслэл бол санхүүгийн тайланг баталгаажуулж байгаа тоонууд маань оршин байх гэдэг батламж мэдэгдлийг хангасан байгаа.

Тэгэхээр одоо найдваргүй байгаа хэдий тоо нь байгаа ч гэсэн оршин



байхгүй байгаа энэ авлага өглөгүүдээр бол тайланг хязгаарласан байгаа.

**Г.Занданшатар:**

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууя. Нэмж асууя.

**Д.Өнөрболор:** Би энэ хязгаарлалттай дүгнэлтийн талаарх хариултыг нэг л сайн ойлгосонгүй ээ. Өөрөөр хэлэх юм бол энэ зөрчлүүд чинь ер нь арилахгүй, ер нь найдваргүй болчихсон гэж ойлгогдохоор тайлбарлаад байх шиг байх юм. Би буруу ойлгоод байна уу? Энэ дээр би ахиад бас нэлээн нарийвчлаад тайлбар авъя. Тэгээд ер нь энэ аудитын энэ тайланд ер нь хэд хэдэн дүгнэлт байгаа юм байна. Ер нь бол яг энэ төсвөөр энэ нэг жилийн төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байгаа юм байна. Зардлын тэлэлт Засгийн газрын өрийг нэмэгдүүлж байгаа юм байна. Төсвийн алдагдлыг энэ гадаад зээлээр бүрдүүлж байгаа төсөвт ачаалал нэмэгдүүлж байгаа юм байна. Төсвийн алдагдал буурсан хэдий ч гэсэн төсөвт тавих хяналт маш сул байгаа юм байна. Тэгээд энэ төсвийн шинэчлэл ер нь яг ингээд хийх цаг нь болчихсон байна. Ер нь төсөв ер нь тогтвортой байж эдийн засагт үзүүлэх үр нөлөөгөө сайжруулна гэж байгаа юм. Тэгээд сая энэ авлигын эсрэг үндэсний хөтөлбөр баталсан байж байгаа юм. Тэгээд энэ төрийн байгууллагуудын ер нь шударга байдлын үнэлгээн дээр бол илт.

**Г.Занданшатар:** 87.

**Д.Энхболд:** Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын дарга Энхболд. Өнөрболор гишүүний асуултад үргэлжлүүлж хариулъя. Өмнө нь хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан дээр ямар дүгнэлт хийсэн бэ гэдэг асуулт асуусан. хэрэгжилт дутуу болон хэрэгжээгүй нийтдээ 874 арга хэмжээ байгаагаас 56 арга хэмжээ хэрэгжээгүй байна. 818 арга

хэмжээ хэрэгжилт дутуу байгаа. Үүнээс 428 ажил нь гүйцэтгэх гэрээний хугацаа болоогүй. Энэ 390 арга хэмжээнээс хэрэгжилт дутуу арга хэмжээний шалтгаан дээр санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс 17, зураг төсөвт өөрчлөлт орж дахин магадлал хийгдсэнээс 37, Захиалагчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан 47, гэрээний хугацаанд хэрэгжүүлэх боломжгүйгээс 12, гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан 72, гадна инженерийн.

**Г.Занданшатар:** Гонгорын Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Би төсвийн тодотголын үеэр асууж байсан асуултаа өнгөрсөн оны тухайд ямар байсан талаар асууя гэж бодож байна. Бид нар өнгөрсөн жил төсөв хийгээд оруулж ирж байхдаа халамжаас хөдөлмөрт шилжинэ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн ийм төсөв болсон халамжийг бууруулна. Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд бодлого хийсэн төсөв орж ирсэн гэж танилцуулагдаж байсан. Өнгөрсөн энэ төсвийн гүйцэтгэлийн хүрээнд яг хэдэн ажлын байр бий болгохоор зорьсноос хэдэн ажлын байр бодитой бий болчихсон байгаа вэ? Улсын төсвийн зарцуулалт үндсэндээ ядуурлыг бууруулах, нийгмийн асуудлуудыг шийдэх чиглэлд явж байгаа учраас энэ их чухал байгаад байгаа юм. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт бол одоо барилгын ажлын улирал үндсэндээ эхлээд ингээд явж байна. Дарханы замаа л асууна даа ЗТЯ-ныхнаас. Одоо нгээд удахгүй чуулган завсарлаад явна. Бид нар 4, 5 хоноод чуулган завсарлаад явчих байх. Намар орж ирнэ. 10 сард орж ирнэ. Тэр болтол тэгээд энэ ажил амлаж байснаараа энэ ондоо бүрэн дуусах уу? Хэдэн хувьтай байна, Ямар бэрхшээлүүд байна? Энэ дээр нэг хариулт өгөөч. Ийм товч 2 асуулт байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? ЗТХЯ-наас байгаа юм уу? Сайнхүүгийн Ганбаатар гишүүн. Дарханы 2 хүн бие биеэсээ асуухгүй гэсэн шүү дээ.

**С.Ганбаатар:** Сайн юмыг сайнаар нь хэлнэ ээ. Улсын Их Хурлын гишүүдийн нүд чих болсон аудит харин ч уншууртай сайн бодитой материалууд орж ирсэн. Асуух асуулт Аудитын газрын даргаас хязгаарлалттай дүгнэлт гэж би анх удаа л амьдралдаа харж байна. Хязгаарлалттай санал, дүгнэлт гэж зарим материалаа Сангийн яам, Эдийн засгийн яам, Засгийн газар гаргаж өгөөгүй гэж би ойлгож болох уу? Юу юу гаргаж өгөөгүй вэ? Миний ойлгож байгаагаар яагаад хязгаарлалттай байгаа юм бэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт сайн юм байна. 15.4 их наяд төгрөгийг тайлант ондоо татварын орлогын бүрдүүлэлтээр бүрдүүлсэн байна. Энэ урьд хожид байгаагүй бас том амжилт. Энэ дээр яах вэ? Нүүрс зэс нөлөөлөлгүй яах вэ? Хамгийн гол миний асуух гээд байгаа зүйл гэвэл орлогын албан татвар 712 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Энд инфляцын татвар гэж яриад байгаа энэ юмны үнэ хөөрөгдүүлчхээд тэрнийхээ дагуу бид нар чинь нэг баахан татвар нэмж аваад өндөр өсгөөд баясаад байж болохгүй. Инфляцын нөлөө хэдэн хувьд нь байгаа вэ? Гурилан бүтээгдэхүүн бол 47 хувийн инфляцтай. Махны үнэ 22 хувийн инфляцтай гэж байна. Эдийн засгийн байнгын хороон дээр тэр Баттөмөр гуайн асуусан асуултад Монголбанк хариулахдаа 14 их наядыг өрхийн амьжиргаанаасаа ард иргэдээс хумсалсан инфляцаар хумсалсан гэсэн нэг дүгнэлт хэлээдэх нь лээ.

Тэгэхээр энэ татварын орлого ийм их өндөр гарсан нь инфляц энд хэр нөлөөлсөн бэ? Аж ахуйн орлогын албан татвар 581 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Нэмэгдсэн өртгийн албан татвар 449 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Энэ дээр

аж ахуйн орлогын албан татвар нийтдээ 2.5 их наяд. Нэмэгдсэн өртгийн албан татвар 3.9 их наяд, НӨАТ 1.4 их наядад илүү байна. Яг энийг татвар төлөгчөөр нь нэг тайлагнаад өгөөч. ААН-ээс, гаалиар, иргэдээс гээд. Процентоор нь мөнгөөр нь. Миний эхний асуулт.

Гуравдугаар асуулт.

Гадаад худалдааны тэнцэл гайхалтай байна. 3.2 тэрбум долларын ашигтай гарсан байна. Гадаад худалдааны худалдаа эрхлэлт 32.1 хувиар өссөн. Үгүй ээ мөн сайн 21.2 тэрбум долларт хүрлээ шүү дээ. Энэ чинь гайхалтай амжилт байхгүй юу. Экспорт 35.7 хувь өссөн. 12.5 тэрбум доллар. Нүүрсний экспорт 135.5 хувиар өссөн. Манайх бол доллартой болчихлоо шүү дээ. Ямар гоё юм бэ? Эдийн засагт 4.8 хувиар өсчихлөө бөөн баяр. Баярлалаа та нартаа.

Харин яагаад ард иргэдийн инфляц 20 хувь болчихлоо. Яагаад ард иргэдийг торгож байгаа юм бэ? төгрөгийн худалдан авах чадвар 20 хувиар уначихлаа. Яагаад доллар ингэж орж ирээд байхад эрэлт нийлүүлэлтийн хуулиар төгрөг чангарах ёстой, яагаад?

Миний дараагийн асуулт гадаад өр нэг жил 5 их наядад өслөө. Миний ойлгосноор миний авсан мэдээллээр. 2019 онд 24 их наяд байсан, 2022 онд 31.9 их наяд болсон гадаад өр, яагаад? Гадаад өр яагаад өсөв? Нүүрс, зэс, татварын орлого ингэж гоё бүрдэж байхад миний энэ асуултад бас хариулж өгнө гэдэгт би итгэлтэй байна.

Дараагийн асуулт 4 дүгээрт болж байна уу даа. Ирээдүй өв сангийн хууль 2017 оноос хэрэгжсэн 2022 оны жилийн эцсийн байдлаар 20.6 их наяд төгрөг байна. 2017-гоос 2022 онд Ирээдүй өв сан нь орлого зарлага үлдэгдлээр нь өссөн дүнгээр нь бидэнд хэлээд өгөөч. Энэ дээр

би судалгааны материал дээр олж харсангүй.

Засгийн газрын яг Монголбанктай холбоотой асуултыг би дараагийн энэ Их Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байна. Монголбанктай холбоотой юм хэрэгжээгүй байгаа.

**Г.Занданшатар:** Эдийн засаг хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Шадар сайд хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Яагаад инфляц бий болчхов. Яагаад төгрөгийн хани 2900-аас 3560 хүртэл унав. Тэгээд одоо ямар байдалтай байгаа вэ гэсэн ийм асуудлууд дээр хариулт өгье. Ер нь манай экспорт 2022 оны сүүлийн улиралд сайжирсан. Тэгээд нүүрсний салбарт та бүгд бид нар, улсаараа мэдэж байгаа, улсаараа ярьсан, улсаараа хэлэлцээд явж байгаа ийм зүйл бий. Тэгээд нүүрсээ ил тод өрсөлдөөн оруулж зардаг болж байна. Хөрөнгийн нүүрсний бирж дээр 63 удаа үнэ хаялцаж байж үнэ тогтоож байна. Зарласан үнээсээ 41 хувиар үнэ өсөж борлогдож байгаа зэрэг ийм эерэг зүйлүүд байгаа. Тэгэхээр яг энэ сүүлийн улиралтай энэ 2022 оны сүүлийн улиралд валютын нөөц 2.4 тэрбум долларт орчихсон байсан одоо 3.9 болоод 1.5 тэрбум доллароор нэмэгдсэн. Төгрөгийн хани та бүгд санаж байгаа бол 3560 байсан. Өнөөдөр 3432 төгрөг. Тэгэхээр төгрөг 130 орчим төгрөгөөр эргээд чангарчихсан байж байгаа. Тэгээд цаашидаа сая Ерөнхий сайд БНХАУ-д айлчлал хийлээ. Экспортын нүүрснийхээ экспортыг бусад уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ер нь ойлголцолд үр дүнтэй ойлголцолд хүрч үр дүн нь гарна гэдэгт би огтхон эргэлзэхгүй байгаа. Тэгэхээр ингээд экспорт цаашидаа нэмэгдээд явна. Тэгээд бид нар өөрсдөө бодлогоо хийх зөв. Макро эдийн засгийн бодлогоо зөв, төсвийн бодлогоо зөв эргэж буцаад байхгүйхэн

шиг хий дэмий улс төржөөд байхгүйхэн шиг урагшаа энэ дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлээд алхах юм бол Ганбаатар гишүүн ээ таны хүсээд байгаа үр дүн илүү богинохон хугацаанд гарах боломжтой. Тэгээд 3 жилийн ковидын дараа бас энэ дайн майнтай ч холбоотой ийм үед энэ сэргэлт бас үр дүн бол тийм өгсөн хэмжээнд маргааш нь шууд үр дүн нь гараад явахгүй байгаа. Гэхдээ үр дүн бол эерэг үр дүнгүүд гараад явж байгаа. Засгийн газар, Монголбанк. Энэ яамдууд бол хоорондын үйл ажиллагаагаа уялдуулаад хичээж чармайж ажиллаж байгаа. Гаргасан алдаануудад автахгүй байх, олсон ололтуудаа улам бэхжүүлэх чиглэлээр ажиллаж байгаа гэдгийг хэлье ээ.

**Г.Занданшатар:** Ирээдүй өв сан Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Ирээдүй өв сангийн орлого зарлагын зөрөө 2022 оны 12 сарын 31-нээр 2 их наяд 748 тэрбум төгрөг байгаа. Орлого, зарлага ялангуяа орлого дээр ханишийн зөрүү хани болон инфляц хэр нөлөөлсөн бэ гэж асууж байна. Энийг нэлээд олон гишүүд маань ингэж асуугаад байдаг юм. Ер нь энэ дээр нэг ингэж ойлгох хэрэгтэй шүү. Инфляц Монгол Улсын эдийн засагт нөлөөлж байгаа. Зөвхөн орлогод биш, зарлага талдаа ч нөлөөлж байгаа. Аль аль талд нь нөлөөлж байгаа. Тэгэхээр одоо орлого давсан хэсгийг энэ инфляцаас нөлөөлсөн гэж бас шууд үзэж ингэж болохгүй. Энийг нэлээн задалж тоон дээрээ сууж байж ингэж ярих хэрэгтэй. Инфляц мэдээж ингээд 10 бид өндөр түвшинд 16.9 хувьд хүрч байсан. 2, 3 жил ч дамжаад ингэж явлаа. Тэгэхээр энэ бол тодорхой хэмжээнд нөлөөлөлгүй яах вэ.

Харин 2022 оны ялангуяа 3, 4 дүгээр улиралд эдийн засаг маань нэлээн нээлттэй болж ковидоос шалтгаалсан

эдийн засгийн боомлолт бүрэн тавигдсан гэсэн үг. Тэгээд бараа эргэлт гадаад худалдаа эрс сайн сайжирсан. Эндээс аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ, АМНАТ гээд эдийн засгийн бүх ангилал дээрээ орлогууд маань харьцангуй сайн давж биелсэн учраас өнгөрсөн оны эдийн засгийн үзүүлэлтүүд маань тэр хэмжээгээрээ сайжирч гарсан байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**С.Ганбаатар:** Би асуултдаа тайлбар авлаа. Хариултаа аваагүй надад бичгээр өгнө биз дээ. Хувь, процентоор би хэдэн асуулт асуусан. Иргэд компаниудаас татвар авах татварын орлого нэмэгдээд байгаа мөртөө онцгой албан татвар 154 тэрбум төгрөгөөр буурсан байгаа. Энэ архин дээр үү, тамхин дээр үү, нефть дээр үү, тэр монополуудаас яг яагаад буурсан юм бэ гэдгийг бас процентоор надад өгнө биз дээ. Миний хамгийн гол бас нэг тодруулж асуух цаг хүрэхгүй юмаа. Энэ нэг Монголбанктэй холбоотой энэ аудитын тайлан тэр хязгаарлагдмал гэдгийг ерөөсөө надад хариулсангүй.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төрийн нийт хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө орлого, зардал бүрэн илэрхийлэгдэхгүй байна. Энэ дотор Монголбанкны Улсын Их Хуралд толилуулсан Монголбанкны санхүүгийн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэх талаар эрх баригчид минь ээ энэ чинь зөвлөмж гарчихсан шүү дээ. Энийг яагаад хийгээгүй юм оо? Энэ дээр бас тодорхой.

**Г.Занданшатар:** 83 Наранчимэг хариулъя.

**Ц.Наранчимэг:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 6516 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байгаа. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлтийг 4 үндэслэлээр хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн. Төрийн аудитын байгууллага, аудитын дээд байгууллага, олон улсын стандарт болон төрийн аудитын тухай хуульд заасны дагуу өөрчлөлтгүй, хязгаарлалттай, сөрөг татгалзсан гэсэн ийм 4 дүгнэлтийг өгдөг.

Хязгаарлалттай дүгнэлт бол тодорхой хэмжээний эрсдэлтэй төсвийн захиран зарцуулагч нар анхаарал хандуулах зайлишгүй шаардлага бий болсон асуудал буюу тоон үзүүлэлтээр тухайн тоог баталгаажуулахад оршин байх найдвартай байх гэсэн.

**Г.Занданшатар:** Онцгой албан татвар Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. Онцгой албан татвар 154.4 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн орлогоосоо дутуу орсон нь үнэн. Энэ маань юутай холбоотой вэ гэхээр авто бензин, дизелийн түлшийг онцгой албан татварыг 161 дүгээр тогтоолоор өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаар 5 сард батлагдсан хуулийн дагуу тодорхой нэр стратегийн бүтээгдэхүүнүүд дээр үнийг тогтворжуулах арга хэмжээ ав гэсэн. Хуулийн өгсөн үүргийн дагуу хийгдсэн ажил юм байгаа юм. Өөрөөр хэлбэл 154 тэрбум төгрөгөөр энэ хэмжээгээр хэрэглэгчид дээр очих ёстой байсан энэ ачаалал яг төсөв дээр ачаалал авсан л гэсэн үг юм байгаа юм.

Мөн түрүүн гишүүний асуусан тэр Дархан-Улаанбаатарын замыг бас нэмээд хариулчихъя гэж бодож байна. Дархан-Улаанбаатар гээд төгсгөл 2-оор нь нэрлэгдсэн болохоос биш энэ зам маань

Ази Европыг холбосон Монгол Улсын нутаг дэвсгэр дээр өнгөрч байгаа олон улсын ийм магистрал зам юм байгаа юм. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр явж байгаа 1100 км-ийн хамгийн өндөр ачаалалтай 200 км. Тэрнээс энэ Дарханы зам.

**Г.Занданшатар:** 83 Наранчимэг гүйцээгээд хариулчих.

**Ц.Наранчимэг:** Монголбанкны тайланг нэгтгэх талаар аудитын өгсөн зөвлөмжийг танилцуулъя.

Монголбанк нь улсын бүртгэл, төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай. Хөрөнгө нь 100 хувь төрийн өмчтэй. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан төрийн бүх хөрөнгийг нэгтгэж тайлагнадаг учраас Монголбанкны тайланг нэгтгэхгүй байгаа. Тийм учраас одоо төрийн хөрөнгө иж бүрэн илэрхийлэгдэхгүй байна гэж үзсэн. Төсвийн тухай хуулийн 54.1-д Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд улс орон нутгийн төсвийн санхүүгийн тайлан төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бүх хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг хамаарна гэж заасан байгаа.

Ийм учраас төрийн аудитын байгууллагаас өмнөх жилүүдэд толилуулсан Монголбанкны санхүү тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэлийн тайланд нэгтгүүлэн төрийн нийтийн хөрөнгийн дүн мэдээг бүрэн илэрхийлэх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна гэж ингэж үзсэн учраас энэ асуудлыг толилуулсан байгаа.

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** 2022 оны төсвийн гүйцэтгэл яригдаж байна л даа. Эндээс Аудитын газрын даргаас ганц 2 зүйл асууя. Яагаад гэвэл 2022 оны төсвийн гүйцэтгэлийг Засгийн газар талаас онцгой сайн үзүүлэлтүүд байгаа гэдэг ийм тайлангууд удаа дараа бас хэлж байгаа. Тэгэхээр аудитын арай хөндлөнгийн байгууллага Аудитын газрын даргаас бас ганц 2 зүйл тодруулъя. Яг одоо энэ өр төлбөрийг харахаар богино хугацаат өр төлбөр өнгөрсөн зөвхөн 2022 онд 1.7 их наядаар нэмэгдэж, урт хугацаат өр төлбөр нь 6.3 их наядаар нэмэгдэж, нийтдээ зөвхөн 2022 оны эхлэл төгсгөлийн хооронд 8 их наяд 41 тэрбум төгрөгөөр Монгол Улсын нийт өр зээл нэмэгджээ. Энэн дээр Аудитын газраас яг ямар дүгнэлттэй байдаг вэ? Нэг жилийн дотор 8 их наяд төгрөгийн өрийг өрөөр санхүүжүүлсэн бол өр нэмэгдмээргүй юм. Энэний нөгөө талд бүтээн байгуулалтын ажлууд, Дарханы замаас өөр 1 км зам ч тавигдсан юм уу? Өөр яг бодит үзэгдэж харагдаж энэ 8 их наядаар ямар ажил хийгдсэнийг мэдэхгүй. Нөгөө алдарт газрын тосны үйлдвэрийн тухай мэдээ гарч байсан. Тэнд бол дампуурсан байдалтай. Яг өөр бүтээн байгуулалтын ажил нөгөө алдартай төмөр замууд нь хил холболтын цэг болоод олон зүйлүүд бас хийгдээгүй. Яг энэ 8 их наядын чинь нөгөө талд нэг бодит зүйл байх ёстой шүү дээ, ямар нэгэн. Өрийг өрөөр санхүүжүүлж болно. Тэгвэл анхдагч өр нь буурах ёстой. Богино болоод урт хугацаат их өр төлбөр 8 их наяд 41 тэрбумаар нэмэгджээ гэсэн. Энэнд нэг аудитын газрын дарга нэг хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь төрийн өмч болоод төсөвт байгууллагуудын хөрөнгө өнгөрсөн хугацаанд бас нэмэгджээ. Бараг нэлээн олон их наядаар нэмэгдэж. Ер нь энэн дээр аудитын газрын зүгээс ер нь ямар байр суурь дүгнэлт төсөв өөрөө 37, 40 хувь болчихсон. Ингээд төрийн өмч төрийн өмчит ААН-үүд дээр өр зээл нь нэмэгдээд, хөрөнгө нь нэмэгдээд улам л

томроод байдаг. Яг эдийн засаг утгаасаа аудитын газар энэн дээр ер нь ямар дүгнэлттэй байдаг вэ? Энэн дээр нэг тайлбар өгөөч.

Гуравдугаарт нь би Сангийн сайдаас л энийг асуучихмаар байна. Ерөнхий сайд нэг хүнд ноогдох ДНБ 5 мянган доллар болсон гэж удаа дараа бас мэдэгдэж байна лээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр. Энэ яг ямар тооцоо ямар аргачлалаар 5 мянган доллар гарч байгаа вэ? Та энэн дээр нэг тайлбар өгөөч. Зүгээр миний санаж байгаагаар 2019, 2020 онд эдийн засаг 4.8 хувь билүү унасан. Дахиад нэг хувиар өссөн өнгөрсөн жил дөрөв аравны хэдэн хувиар өссөн гэж гэсэн тооцоо гарсан. Энэ ковидын өмнөх жил 4200, 4300 доллартой гэж байсан. Яг л баланс л баймаар юм. Тийм өсөлт өндөр өсөлт энд 5 мянган доллар болчих өсөлт энэний цаана ямар аргачлалаар бодсон юм. Энэ чинь өөрөө тийм нэг голчилсон зүйл энэний цаана байгаад байна уу? Яг хэдийгээр албан ёсны дүн статистикийн дүн мэдээ гараагүй ч гэсэн энэн дээр нэг тооцоо цаана нь байх ёстой байх. Эдгээр дээр нэг тодруулж мэдээлэл өгөөч.

**Г.Занданшатар:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Нэг хүнд ногдох үндэсний орлого инфляц гээд энэ нэгдсэн тоонуудыг Үндэсний статистикийн ерөнхий газраас гаргадаг тоо бид аваад шууд хэрэглэдэг юм байгаа юм. 5 мянган долларт хүрлээ гэдгийг 2022 оны 12 сарын 31-ээр ингэж Статистикийн ерөнхий газраас албан ёсоор зарласан. Энэ тоо нэлээн бодитой тоо болов уу гэж би ингэж бодож байна. Ялангуяа 22 онд эдийн засаг маань харьцангуй тогтворжиж мөн өсөлтийн суурь бий болсон. Ялангуяа сүүлийн хагаст эдийн засаг маань нэлээдгүй тэлсэн. Хэрвээ тэр тэлэлт байгаагүй бол

харин энэ 5 мянган доллар хүрэхгүй 4600, 4700 орчим байх байсан болов уу?

Тийм учраас манайх өөрөө худалдааны эдийн засагтай л ийм улс шүү дээ. Би танд нэг их онцгой нөлөөлсөн байж болзошгүй тоо хэлье. Би яг энэ өөрөө гаргадаггүй учраас шүү. Өөр байгууллага гаргадаг учраас. Гадаад худалдаа анх удаа 2 оронтой тоогоор орж ирсэн. Тэрбум доллароор. Экспорт 12 тэрбум доллар хүрсэн. Өмнө нь 9 тэрбум доллар л 2019 онд дээд хэмжээндээ хүрч байсан. Тэгэхээр энэ гадаад худалдааны энэ огцом өсөлт энэ рүү яах аргагүй нөлөөлсөн. 5 мянган долларын үндэсний орлого гэдэг бол энэ статистик тоо шүү. Тэрнээс энэ яг хувь хүний орлого гэж шууд бас ойлгож болохгүй. Нэг хүнд ноогдож байгаа эдийн засгийн маань өсөлт тэлэлт об'ём маань энэ хэмжээнд ирж байна гэсэн үг. Ингээд шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ойрын хугацааны Засгийн газрын төлөвлөлт зорилгын хүрээнд та бас мэдэж байгаа. Бид 2030 он гэхэд бид нэг хүнд ноогдох үндэсний орлогоо 10 мянган долларт хүргэхээр ингээд зориуд ажиллаж байгаа.

**Г.Занданшатар:** Аудит 81. Доржсүрэнгийн Занданбат дарга.

**Д.Занданбат:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын өр зээл нэмэгдсэн гол нөлөөлөх хүчин зүйл нь болохоороо зэрэг энэ төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 54.1 хувийг гадаад зээлээс бүрдүүлсэн байгаа. Энэ тухай тайлан дээр дурдсан байгаа.

Дээрээс нь 4 их наяд 479.5 тэрбум төгрөгийн ханишийн зөрөөгөөр Засгийн газрын өрийн үлдэгдэл нэмэгдсэн. Тэгэхээрээ зэрэг энэ гол нөлөөлж байгаа энэ том тоо нь бол ийм 2 тоо байгаад байгаа юм. Тэр төрийн өмчит газруудын өр төлбөр нэмэгдэж байна гэсэн асуудлуудыг бас ярьж байна.

Энэ аудитын дүгнэлтийн 1, 6 хоёр дээр бол энэ талаар дүгнэлтэд хэлээд өгсөн байгаа. Би энийг уншаад өгье.

Гадаад өрийг дахин санхүүжүүлэх замаар бүрэн зохицуулалт хийж эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасган төлбөр үүргийг хэсэгчлэн хойшлуулсан боловч урт хугацаат үнэт цаас гадаад зээлийн ханшийн алдагдал тайлант онд 3.3 тэрбум төгрөг болж нийт өр төлбөр 8 тэрбум төгрөг өсөхөд нөлөөлсөн гээд сая дүгнэлт хэлж байна.

6-д нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нийт дүнгээр 2.5 их наяд төгрөгийн цэвэр ашигтай, 78 хуулийн этгээд 897.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нийт дүнгээр 294.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 229 хуулийн этгээд 79.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан гээд ингээд аудитынхаа дүгнэлтэд хийгээд өгсөн. Ер нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ААН-үүдийн өр төлбөр үүсэж байгаа ерөнхий нөхцөл байдлыг бид нар бас төрийн өмчит компаниуд дээр гүйцэтгэлийн аудитыг өнгөрсөн оны сүүлчээр хийсэн. Тэр талаар тайлан гаргаж гишүүдэд хүргүүлсэн байгаа. Үүнээс харж байхад бол ер нь төрийн өмчит компаниудын засаглал бол олон улсын засаглалын зарчмуудыг барьж явахгүй байгаа асуудал бол их тийм засаглал талаасаа анхаарах ёстой зүйлүүд байна гэж үзсэн.

Үндсэн хөрөнгө яагаад нэмэгдсэн бэ гэсэн. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2.6 их наядар нэмэгдсэн юм байна. Тухайлбал их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв 773.5 тэрбум төгрөг, Тавантолгой төмөр зам 750.9 тэрбум төгрөг. Эрдэнэс Тавантолгой компани 407.2 тэрбум төгрөг, цемент шохой 238.3 тэрбум төгрөг. Монгол Улсын Хөгжлийн банк 189.9 тэрбум төгрөг, мэдээлэл

холбооны сүлжээ 162.9 тэрбум төгрөг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр 121 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж энэ төрийн өмчит компаниудын өр төлбөр өссөн байна.

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя. Нэг минут.

**О.Цогтгэрэл:** Тэр саяын 5 мянган доллар гэдэг дээр сая би хувааж үзлээ л дээ. Бодит тооцоо биш. Тэгэхдээ одоо төгрөгийн инфляц орчихсон дүнгээр ДНБ 60 их наяд гэж байгаа юм. 60 их наядыг 3.4 сая хүн хуваагаад үзвэл тэр 5 мянга чинь гарахгүй л байна л даа. Бүр тэр юу инфляц шингэчихсэн. 2015 оны зэрэгцүүлэх дүнгээр наад тоо чинь бүр доошоо л байх. Тэгэхээр энэ тоо бол үнэхээр тийм гажуудалтай тоо л энэний цаана ингээд яваад байна. Яаж бодсон ч энгийнээр бодсон ч 4 хувь буураад нэг хувь өсөөд дахиад 4 хувь өсөхөөр 10 хувь эцсийн дүн нь 10 хувь нэмэгдчихдэг нэг ийм наад захын калкуляц байхгүй л дээ.

Хоёрдугаарт нь тэр өр зээлтэй холбоотой тэр 8 их наядар ингээд өссөн нь бодитой юм байна. Нэгхэн жилийн дотор 8 их наяд буюу хоёр аравны хэдэн тэрбум доллар. Нөгөө алдарт Чингис бондоос илүү дүнгээр зөвхөн энэ дүнг 8 их наядыг бас л бид нарын нөгөө сурсан зангаар хүнд хуваагаад үзвэл нэгхэн жилийн дотор.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** 2022 онд төсвийн хурал 17.1 их наяд төгрөг, зарлага нь 18.1 их наяд төгрөг болж төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан. Эдийн засгийн өсөлт 4.8 хувь, инфляц 13.2 хувь байгаа. Гадаад худалдааны эргэлт 21.5 тэрбум доллар болж худалдааны тэнцэл 3.8 тэрбум долларын ашигтай гарсан боловч төлбөрийн тэнцэл 779 сая

долларын алдагдалтай. Нийт салбаруудаас уул уурхайгаас бусад салбар нь өр үйлдвэрлэж байгаа. Ийм л үнэ дүнтэй байна. Урсгал данс 2.7 их наяд төгрөгийн алдагдалтай, санхүүгийн данс 1.5 их наяд төгрөгийн алдагдалтай, нөөц хөрөнгө 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай. Ийм баланс дүн гарч байгаа юм байна. Монгол Улсын нийт гадаад өр 33.5 тэрбум доллар байгаа. Үүнээс гадаадын тийм шууд хөрөнгө оруулалт зээллэг нь 2022 онд 12.5 тэрбум доллар байснаа 13.4 тэрбум доллар болж 900 сая доллар өссөн байна. Засгийн газрын нийт өр 5.9 их наяд төгрөгөөр өссөн. Ийм л баланс харагдаж байна даа. Энэ жилийн 2022 оны жилийн дүнгээр. Төсвийн орлого бол нүүрсний борлуулалт, нүүрсний хэмжээнээс болж нэмэгдсэн. Эдийн засгийн үзүүлэлтүүд бол ийм хангалтгүй дүнтэй байна. Энэ дотор бас нэг юу гэхээр өрийн үйлчилгээ 808 тэрбум төгрөг байгаа. Эргэж төлөгдөх цэвэр зээл 112 тэрбум төгрөг гээд. Гадаад өрөнд зарцуулагдах энэ төсвөөс зарцуулагдаж байгаа мөнгө асар их хэмжээнд байна. Энэ чиглэлд ямар бодлого барьж байгаа вэ? хамгийн сүүлд босгосон бонд чинь 8 аравны хэдэн хувийн хүүтэй шүү дээ. Энэ эд нарыг солих чиглэлээр юмнууд хийгдэж байгаа юу гэсэн нэг дэх асуулт байна.

Хоёр дахь асуудал энэ зардал 969 тэрбум төгрөгөөр хэтэрчихсэн гээд энэ юун дээр явж байгаа юм. Мэдээж орон нутгийн зардал байж магадгүй байх. Зүгээр энэ дээр нийт зардал өссөн гэж яваад байгаа. Энийг яаж зохицуулах ёстой юм.

Хоёр дахь асуулт байна.

Гуравдугаарт нь энэ ирээдүй өв сангаас 26.4 тэрбум төгрөгийг илүү зарцуулчихсан гэх юм. Тэгээд энэ ямар учиртай юм? Монголын хүүхэд ингээд олон өсөөгүй. Энэ хүүхдийнхээ тоог дутуу тооцчихсон юм уу? Ийм асуулт байна.

Дараагийн асуудал энэ төлөвлөлттэй холбоотой. 2022 онд бол 2021 оны гүйцэтгэлээс 700 тэрбум төгрөгөөс хүлээгдэж байгаа гүйцэтгэлээс 700 тэрбум төгрөгөөр дутуу төлөвлөсөн. 2023 онд мөн үргэлжилж байгаа. 2023 оны эхний 5 сарын байдлаар манай төсвийн орлого бараг 9 их наяд төгрөгт хүрч байгаа.

2023 оны эхний хагаст бол 10.5-аас 11 их наяд төгрөг болно. Ингээд үзэхээр бол хүлээгдэж байгаа гүйцэтгэл 22 орчим их наяд төгрөг болох ийм боломжтой. 2024 онд бид 21.1 гээд төсвийн хүрээний мэдэгдлээ ингээд л явуулсан л даа. Тэгээд энэ яагаад ингэж боломжоосоо дутуу төлүүлээд байдаг юм бэ? Монгол Улс чинь асар их хөгжлийн потенциалтай шүү дээ. Одоо сая гарч байгаа тэр ашигт малтмалын нөөцөөр дэлхийд 9-д орж байгаа гэж байгаа шүү дээ. Мааш их хэмжээний боломж байна шүү дээ. 15-аас 16 тэрбум долларт л эдийн засаг эргээд байдаг. Нэг хүнд ноогдох ДНБ 5 мянган долларт тогтчихсон байгаад байдаг.

**Г.Занданшатар:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Дарханы гишүүд нэгнээсээ асуугаад нэг нь хариулаад байна гэхгүй байлгүй дээ. Түрүүн зам асуусан шүү. Засгийн газрын өрийг төгрөгөөр илэрхийлэх юм бол энэ ханишийн зөрүүнээс тэгж өссөн харагдаж байгаа. Валютаар илэрхийлэх юм бол багассан байгаа. 9000000440 саяас 2021 оны жилийн эцсээс 2022 оны жилийн эцэст 9 тэрбум 280 сая болж ингэж буурсан байгаа. Бид ДНБ-ээ өсгөх эдийн засгаа тэлэх дээр онцгойлон анхаарч байгаа. Тэгэхээр энэ Засгийн газрын энэ өрийн хэмжээнээс илүүтэйгээр бид өрийн ашиглалт өрийн менежмент дээрээ энэ өрөөр эдийн засгийг тэлэх, эдийн засгийн өгөөжтэй төслүүдийг хэрэгжүүлж чадаж байна уу



үгүй юү гэдэг дээрээ л илүү анхаарах хэрэгтэй юм байгаа юм. Өрийн хувьд бол бид маш сайн сахилга баттай явж байгаа.

Засгийн газар маань Улсын Их Хурлаас баталж өгдөг дунд хугацааны 3, 3 жилээр баталж өгдөг гадаад өрийн стратегийнхаа хүрээнд ажиллаад явж байгаа. Өнгөрсөн жил шинэчилсэн. Одоо бид 2025 он хүртэл ажиллах 3 жилийнхээ гэрийн даалгавраа аваад явж байгаа. Энэ дээр бодлогыг маш тодорхой заасан байгаа. Яг энэ бодлогын хүрээнд л явна. Өөрөөр хэлбэл бид нар богино хугацаатай өндөр хүүтэй арилжааны зээл бонд дахиж гаргахгүй ээ. Ийм үнэтэй богино хугацаатай ийм мөнгөөр төсөл хөтөлбөр санхүүжүүлэхгүй ээ. Харин хөгжлийн урт хугацаатай хөнгөлөлттэй ийм зээлээр л урт хугацааны санхүүжилтүүдээ хийнэ. Мөн төр хувийн хэвшлийн түншилэл, гадаадын хөрөнгө оруулалт шууд хөрөнгө оруулалтуудыг дэмжиж ажиллана. Улсын Их Хурал дээрээс батлагдсан шинэ сэргэлтийн бодлогын хүрээн дэх ер гаруй төслийн нийтдээ 100 гаруй их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтууд байгаа. Эндээс дөнгөж бол 10 хувь нь л бид нар төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэнэ. Бусад нь бол нэн хөнгөлөлттэй зээл эсвэл гаднын шууд хөрөнгө оруулалтаар хийгдэх ийм төслүүд байгаа юм.

Өөрөөр хэлбэл тэндээс нь өрийн дарамт нэмэгдэхгүй ээ гэсэн үг. 8.65 хувийн хүүтэй бидний хамгийн сүүлийн сенчери 2 төсөл маань яригдсан. Энэ хүү бол Америкийн федийн хүүтэй харьцуулах юм бол федийн хүү 4.5 байгаа ингэхээр 4-д яг цэвэр зөрөө нь 4 1.5 гэсэн үг. Энэ бол Засгийн газрын өмнөх хүүгийн түвшинүүдээс хамгийн бага түвшинд байгаа гэсэн үг. Өмнө нь гарч байсан 5.75 дээр гарч байсан хүү тэр үед Америкийн федийн хүү нэг хувь байсан зөрөө нь ингээд 4.7 гэсэн үг.

Тэгэхээр сүүлийн үед гарч байгаа Засгийн газрын гадаад менежментийн

өртөг маань ийнхүү амжилттай буурч байгаа. 2024, 2025 онуудад бид тэгээд тулсан гадаад томоохон өрийн эрсдэлүүдээ бүгдийг нь зохицуулалт хийж амжилттай хойшлуулахыг нь хойшлуулсан. Шууд төсвөөс төлөхийг нь төлөөд ингээд явж байгаа. Ирээдүй өв сангийн нэрлэсэн дүнгийн өсөлтийг хэн хариулах вэ? Ганбат Төрийн нарийн бичгийн дарга.

**Г.Занданшатар:** 83. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат хариулна. 82.

**Ж.Ганбат:** Өнгөрсөн 2022 онд бид хүүхдийн мөнгөн тэтгэмжийг төлсөн. Тэтгэмжийг бодохдоо бид нар 2021 оныхоо гүйцэтгэл дээрээ үндэслээд нийт батлагдсан төсөв дээрээ бид нар хүүхдийн тоогоо 1.2 сая хүүхдэд үндэслээд тооцсон байсан. Энэ 2021 оны эцэст хүүхдийн тооны өсөлтөөр 13 мянган нэмэлт хүүхэд гарсан. Энэнтэй холбогдуулаад зардлын нэмэлтүүд ингээд гарсан байгаа. Бид яах вэ төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэл дээр үндэслээд тооцдог байсан тооцоод явж байгаа. Гэхдээ гүйцэтгэл дээрээ бол хүүхдүүд нэмэгдэж гарсан учраас бид энүүнийг хүүхдийн мөнгийг өгөх үгүй байх боломжгүй. Бас энэ хэмжээнд нь тооцоод олгосон ийм асуудлууд байгаа.

**Г.Занданшатар:** 82 гүйцээгээд хариулчих.

**Ж.Ганбат:** Яах вэ хэтэрсэн асуудал өнгөрсөн оны гүйцэтгэлээр уг нь байхгүй. Бид нар зохицуулалт хийгээд яг батлагдсан л үнэндээ хэтрэхгүйгээр гарсан. Ийм байгаа. Би яг таны энд хэтэрсэн 900 хэдэн тэрбум гэдгийг уг нь тийм гүйцэтгэл байхгүй нөгөө аудит нэмж тодотгож хэрвээ хэтэрсэн бол аудитын шалгалтаар гараад л ирнэ л дээ тэр нь. Амгалангийн Адыасүрэн. Баттөмөр гишүүн тодруулж асууя. Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

**Б.Баттөмөр:** 2022 оны зардал 969.3 тэрбум төгрөгөөр хэтэрсэн гээд энд гарчихсан байгаа шүү. Юмаа та нар үзээрэй, 1 дүгээрт.

Хоёрдугаарт юу вэ гэхээр энэ Монгол Улсын ирээдүйг та нар жоохон өөдрөг хараач ээ. Менделеевийн үелэх системийн 111 элементийн 80 нь байж байна. Баялгаараа эхний есөд байж байгаа. Энэ оюуны чадавхтай нэг гурав арваны дөрөвхөн сая хүн байна. Маш их боломж байна шүү дээ. Тэгээд л Азийн хөгжлийн банкны судалгаагаар ядуу орон гээд орчихсон. Тэгээд л нэг ийм тогоон дотроо 15 тэрбум долларын эдийн засагтай ингээд л яваад байдаг. Энэ 2022 оны төсвийн гүйцэтгэлээс та нар ямар сургамж авч байгаа юм бэ? Юун дээрээ алдав ямар ололт байна? Цаашидаа яах юм? Монгол ингээд яваад байх юм уу? Нийт хүн амын 42 хувь нь ядуурчихсан байна шүү дээ.

**Г.Занданшатар:** 82 Ганбат дарга. Жигжидийн Ганбат дарга.

**Ж.Ганбат:** 2022 он бол бидний хувьд ковидын бүрэн дуусаагүй БНХАУ тэг ковидын бодлоготой явсан шүү дээ. Бид 2022 оны эхний 4 сар бол маш хүнд байдалтай экспорт бараг тэг зогсолттой ийм байдал дээр явсан. Бид нар 5 сараас эхлээд экспортоо нэмэгдүүлж чадаад оны сүүлээр төсвийн орлого бол давж биелсэн. Нөгөө талдаа бидний бас тооцоолоогүйгээр нөхцөл байдлууд биднээс хамаарахгүй бас гадна орчны нөлөөллүүд үүсэж байгаа шүү дээ. Бид нар Орос Украины асуудлыг бид тооцох боломж байсан. Бид битгий хэл бусад орнууд ч тооцох боломж байсан. Энэнтэй холбоотой бас нөхцөл байдлууд хүндэрсэн. Гэхдээ бид нөгөө талдаа бол бид эрсдэлийн асуудлуудыг бүх талдаа ингэж байгаа. Сангийн яаман дээр Судалгааны газар бид нар шинээр байгуулсан. Гадна орчны судалгаануудыг бид байнга хийж байна. Бид судалгаа сайн

хийж байж эрсдэлгүй бодлого явуулна, төсөв маань Улсын Их Хурлаас баталсан.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Гишүүний асуултад нэмж хариулъя.

2022 оны төсвийн гүйцэтгэлийн хувьд бид маш амжилттай жил болсон гэж хэлнэ ээ. Бид өнгөрсөн жилийн давсан орлогыг мөнгөний бодлоготойгоо нийцүүлж үндсэн тэнцлээ сайжруулж гаргасан. Ингэснээр бид нар сүүлийн 3 жил хөндөж чадаагүй тэтгэвэр цалингийнхаа өсөлтүүдийг энэ жил хийх боломж суурь нь тэнд тавигдсан гэсэн үг. Өөрөөр хэлбэл төсөв мөнгөний бодлого том макро зургаараа эдийн засгийг тогтворжуулах ийм амжилттай, макро шийдлүүд, зорилтдоо хурч чадсан гэсэн үг. Цаашидаа бид аль болох төсвийн нэг төгрөг бүрийг хөрөнгө оруулалт дээр ч тэр зардал дээр ч тэр гадаад зээл тусламж дээр ч тэр бүтээмжийг нь нэмэгдүүлэх тал дээр өөрөөр хэлбэл аль болох төсвөө тэлэлгүйгээр эдийн засгаа өсгөх.

**Г.Занданшатар:** Амгалангийн Адьяасүрэн гишүүн асуулт асууя.

**А.Адьяасүрэн:** Ингээд Засгийн газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцлаа. Ингээд үндсэн нэг 3 асуудлыг тодруулж асуух гэсэн юм. Аудитын газрын энэ дүгнэлтээс харахад нэг анхаарал татаж байгаа асуудал бол энэ дүгнэлт дээр ингэж бичсэн байна л даа. Засгийн газар нь төрийн өмчийн компаниудад төсвийн бодлого зарчимтай нийцэхээргүй нийгмийн шинж чанартай хөрөнгө оруулалтуудын ажлуудыг санхүүжүүлэхийг шаардсан шийдвэр гаргадаг юм байна. Тэгэхээр энд Засгийн газрын ямар шийдвэрээр төрийн өмчийн ямар ямар компани ийм

санхүүжүүлэлтүүдийг хийснийг нь тодорхой сонсмоор байна.

Хоёр дахь нэг асуудал гэвэл 2022 оны улсын төсвийн алдагдлын 35 орчим хувийг гадаад эх үүсвэрээр хаахаар төлөвлөсөн байгаа. Тэгвэл энэ төлөвлөснөөсөө зөрчөөд бид нар энэ 54 хувь болгон санхүүжүүлсэн нь Засгийн газрын өрийг 4.4 их наядын одоо ханишийн зөрүүгээр нэмэгдүүлсэн байна. Үүний учир шалтгааны тайлбар тодруулгыг өгнө үү? Энэ төсвийн хариуцлагын том асуудал гэж бас миний зүгээс бодож байна.

Ингээд яагаад энэ Сангийн яам ийм мэргэжлийн бус гэмээр үйлдэл гаргасан юм болоо? Хамгийн сүүлд нь бид нар ингээд л жил бүр төсвийн хуулиар 20 гаруй хуудас бүхий нэгэн хавсралтыг бол баталдаг. Энэ дээр гишүүд нэг их анхаарал хандуулдаггүй юм шиг надад бол санагддаг. Энэ хавсралтын нэр болохоор төсвийн ерөнхийлөн захирагч нарын тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт гэсэн нэртэй.

Гэтэл ингээд л баахан ажил хэрэг болгоод л батлуулдаг тэгсэн мөртөөсөө энэ хөтөлбөрүүдийнхээ үр дүн гүйцэлдээд хяналт шинжилгээ үнэлгээ хийдэггүй орхигдуулдаг талаар бас энэ аудитын тайланд бас дурдсан байна. Үүнтэй холбоод асуухад ийм хэрэггүй шахам хавсралт төсвийн хуулиар баталж байх ямар хэрэгтэй юм бол оо? Энэ талаар бас би Сангийн яамнаас асуух гэсэн юм. Тэгээд тодорхой хариулж өгөх байхаа.

**Г.Занданшатар:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Адъяасүрэн гишүүний асуултад сая тоонуудтай холбоотой асуудал байлаа. Тавинжил дарга тоонуудаа харж байгаад хариулаадах уу?

**Г.Занданшатар:** Ханишийн зөрөөгөөр гадаад өр 4.3 их наядаар 4.1 их наядаар өссөн.

**Б.Жавхлан:** Түүрүүн бас гишүүний асуусан асуулттай давхац давхцаж байна л гэж ойлголоо. Ер нь төгрөгөөр илэрхийлж байгаа гадаад зээлийн дүн өссөн байгаа. Ханишийн зөрөөнөөсөө. Тэр нь дөрөв аравны би яг дүнг нь хэлээдэхье.

Засгийн газрын зүгээс 2022 онд нийт 2 их наяд 227 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төлбөрийг өөрийн үйлчилгээнд төлсөн байгаа. Үүнээс 1.4 их наяд нь үндсэн зээл, хүүгийн төлбөрт 808 тэрбум төгрөг. Өөрөөр хэлбэл ингээд ам.доллароор нь харах юм 9.4 тэрбум доллароос 9.2 тэрбум доллар болж буурсан. Ингээж буурсан хэдий ч яг төгрөгөө илэрхийлэх юм бол таны хэлж байгаа яг тэр дүнгээр өсөж ингээж тайлагнагдсан байгаа.

**Г.Занданшатар:** Ганбат дарга хариулах юм уу? 82 Жигжидийн Ганбат.

**Ж.Ганбат:** Төсөв батлагдахдаа бол хүрэх үр дүнгийн үзүүлэлт гээд төсвийн ерөнхийлөн захирагч нар ингээд баталж байгаа. Өөрөөр хэлбэл бодлогын хувьд бол тухайн төсвийн ерөнхийлөн захирагч ийм бодлого хэрэгжүүлэхэд ийм хэмжээний мөнгөн дүн мөнгөн дүнгийн илэрхийлэл нь ингээж батлагдаж байгаа юм гээд хавсралт нэг бүрээр нь батлагдаж байгаа юм. Дараа нь бид гүйцэтгэлийг нь эхэлж авахдаа таны 2022 онд ийм бодлого хэрэгжүүлэхэд ийм мөнгөнд батлагдсан энэний зарцуулалт нь ямар байна, үр дүн нь хэдэн хувийн биелэлттэй байна гээд энэ асуудлыг нь эхэлж байгаад мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөдөлгүүр бас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль энэ тэртэйгээ уялдуулаад бүх юм нь гүйцэтгэлээр нь ингээд нэг бүрчлэн авдаг л даа. Ер нь бол бусад орнуудад ч гэсэн нөгөө Засгийн газрын бодлогын мөнгөн илэрхийлэл нь төсөв учраас бид энийг аль

болох л хавсралттай ингээд деталь уялдуулж ингэж авч л дэлгэрэнгүйгээр тайлагнаж авч ингэж Улсын Их Хуралд тайлагнах ийм байдлаар ажилладаг л даа. 2022 оны хувьд төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтэд төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх 105 хөтөлбөр арга хэмжээнд 388 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг баталсан. Үүнээс 27 хөтөлбөрийн 55 хувь үр дүн нь 60 хувийн гүйцэтгэлтэй 77 хөтөлбөрийн 187 үр дүн нь 60-аас 100 хувийн гүйцэтгэлтэй 67 хөтөлбөрийн 146 үр дүн нь 100-аас дээш гүйцэтгэлтэй байна гэдэг ийм байдлаар тайланг дүгнэсэн байгаа.

**Г.Занданшатар:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Адьясүрэн гишүүн уучлаарай. Түрүүн таны асуултад дутуу хариулсан байна шүү нэмээд мэдээлэл өгье өө. Нийгмийн хариуцлагын хүрээнд төрийн өмчийн үйлдвэрийн газруудаас хийгдсэн энэ 2 л том ажил байгаа юм. Энэ Эрдэнэт үйлдвэрээс 100 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр хөдөөгийн сургууль, цэцэрлэг, дотуур байр нээгээд нийтдээ 819 ариун цэврийн байгууламж гэсэн үг. Тэгээд энийг шинэчлэх ийм хөтөлбөр сүүлийн 2 жил дамнаад явж байгааг та мэдэж байгаа. Ялангуяа эмэгтэй гишүүд маань энэ асуудлыг маш сайн дэмжиж ингэж энэ хөтөлбөр хэрэгжээд явж байгаа. Гүйцэтгэл нь харин нэг тийм ч сайнгүй яваа юм байна лээ.

Одоогоор 819-өөс 307 барилга байгууламжийн ариун цэврийн ашиглалтад явж байна гэдэг чинь 50 хувьдаа ч хүрэхгүй байна л гэсэн үг. 350 нь 35.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй явж байгаа. Мөн ТӨҮГ-аас Эрдэнэтээс, Дарханы арьс ширний үйлдвэрийн энэ арьс ширний цогцолбор дээр мөн 50 тэрбум төгрөг төсөвлөсөн. Энэ төсөвлөснөөс

дөнгөж 1.3 тэрбум төгрөг л гарсан байгаа. Тэгээд өөр бол томоохон төрийн өмчийн үйлдвэрийн газруудаас нийгмийн шинжтэй ийм хөрөнгө оруулалтууд байхгүй.

Аудитын тайланд бас өөр зүйлүүд дурдагдаагүй байна лээ.

**Г.Занданшатар:** 81 аудитын газрын дарга Занданбат дарга.

**Д.Занданбат:** Адьясүрэн гишүүний асуултад хариулъя.

Энэ төсвийн алдагдлыг 2022 онд 2.8 их наядаар баталсан. Үүний 35 хувийг гадаадын зээл тусламжаар санхүүжүүлэх бололцоо олгосон. Тэр тооцооллоор бол 1 их наяд орчим байгаа юм. Гүйцэтгэлээр төсвийн алдагдал 1 их наяд 32 тэрбум гарсан. Үүний 54.4 хувийг нь гадаад санхүүжилттэй, гадаад эх үүсвэрээ санхүүжүүлсэн. Энэ нь дунджаар 0.5 их наядыг 556 тэрбум төгрөг гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ бол төлөвлөснийхөө хэмжээнд байна. Төсвийн хууль зөрчигдөөгүй л гэж ойлгож байгаа юм.

**Г.Занданшатар:** Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн.

**Т.Энхтүвшин:** Үндэсний аудитын газраас асууна. 2022 оны төсвийн гүйцэтгэлд 35 зөвлөмж хүргүүлсэн байна. Тэгээд 2021 онд бас 21 зөвлөмж, 3 албан шаардлага гаргаж байсан. Танай ер нь энэ 2021 оны энэ зөвлөмж албан шаардлагын хэрэгжилт ер нь ямар түвшинд явдаг юм бэ? Хэчнээн хувь нь хэрэгжсэн байгаа юм? Энэ дээр нэг тайлбар хэлж өгөөч.

2022 онд юу гэдэг юм гарсан энэ зөвлөмжтэй чинь 2021 онд гарсан энэ зөрчил дутагдлууд давхцаж байгаа зүйлүүд байна уу? Тэгээд яагаад энэ зөвлөмжүүд хэрэгжихгүй байна гэдэг дээр нэг Үндэсний аудитын газар бас нэг

тайлбар хийгээд өгөөч ээ гэж хүсэж байна.

Дараагийн асуудал энэ Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл өмнөх оноос энэ 378.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Гадаад үнэт цаасны үлдэгдэл 1.2 их наядаар өссөн байж байна. Тэгээд энэ Засгийн газрын дотоод, гадаад өрийн үлдэгдэлд нэмэгдсэн шалтгаан нь ер нь юу байж байгаа юм? Энэ төсвийн алдагдлыг нөхөөд байгаа юм уу, эс үгүй бол өөр зүйлийн хөрөнгө оруулалтад зарцуулаад байгаа юм уу? Энэ дээр бас тодорхой хэмжээний тайлбар хэлж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Эхлээд Аудит хариулъя. 83 Наранчимэг.

**Ц.Наранчимэг:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр Монгол Улсын Ерөнхий сайдад 7 зөвлөмж, Сангийн сайдад 3 зөвлөмж, Эдийн засаг, хөгжлийн сайдад 4 зөвлөмж, Дорноговь аймагт нэг төлбөрийн акт тогтоосон. Зөвлөмжийн хэрэгжилтийг аудитаар Сангийн яам 98.2 хувийн хэрэгжилттэй гэснийг аудитаар хянаж 78.6 хувийн биелэлттэй байна гэж ингэж үзсэн байгаа. Бид зөвлөмжийн хэрэгжилтийг өмнөх оны 14 зөвлөмжөөс 10 зөвлөмжийг хэрэгжих шатандаа байна гэж ингэж дүгнэсэн. Төсөв хөрөнгө оруулалттай холбоотой шаардлага хангаагүй төсөл хөтөлбөрүүдийг төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөвт хөтөлбөрүүд байгаа асуудал ийм зөвлөмжийг хэрэгжихгүй жил болгон давтагдан өгч байна гэж ингэж ойлгож байгаа. Бусад зөвлөмжүүдийг хэрэгжих шатандаа хэрэгжүүлж ажиллаж байна гэсэн ийм байгаа. 2 албан шаардлага бол бүрэн хэрэгжээгүй байна гэж үзсэн.

Аудитаар дотоод үнэт цаастай холбоотой зөвлөмжийг бид бас хэрэгжихгүй байна гэж ингэж үзсэн. Ерөнхийдөө төрийн аудитын байгууллагаас өгч байгаа зөвлөмж хэрэгжихгүй байгаа шалтгаан нь дотоод аудитын эрх зүйн орчинтой төрийн аудитын байгууллага холбож үзэж байгаа. Дотоод аудит төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх дотоод аудит хараат бус аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх түүнд хяналт тавих тэрэн дээр ямар тодорхой ажлуудыг зохион байгуулж энэ алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх чиг үүрэг дотоод аудитад байдаг. Тэгэхээр энэ эрх зүйн орчин байхгүйгээс дотоод аудитыг хангалтгүй орчхож байна гэж үзээд Монгол Улсын Их Хуралд энэ удаа дотоод аудитын эрх зүйн орчинтой болгох асуудлыг бол толилуулсан байгаа. Энд зайлиггүй хууль эрх зүйн орчин бол шаардлагатай байна гэж ингэж үзэж байгаа.

**Г.Занданшатар:** Ер нь аудит ч гэсэн энэ асуултын хариултууд нэг еэвэн тойруулаад л мөлжөөд байгаа юм шиг ерөөсөө гол асуудлуудад хариулахгүй юм. Түрүүн Ганбаатар гишүүний асуусан асуулт Монголбанкны тайланд аудит хийсэн тухай асуулт байна шүү дээ. Төсөв ингээд тэлчихсэн учраас мөнгөний бодлогыг хатууруулах, энэ инфляц, хани валютын нөөцөд учирч болох эрсдэлтэй учруулж бодлогын хүү нэмэгдүүлэхээс авхуулаад мөнгөний бодлогын чиглэлтэй асуудал байхгүй юу энэ чинь. Төсвийн тэлэлт чинь яаж инфляц, хани, төлбөрийн тэнцэлд нөлөөлөх юм тэгээд? Ингээд Монголбанкны тайланд аудит хийгээгүй гээд л орхичхож байгаа юм. Тэрэнтэй танайхтай ч шууд хариулах асуудал биш. Тэгээд сая энэ зөвлөмжүүдийн хэрэгжилтийн асуудал Улсын Их Хурлын тогтоол аудитын энэ зөвлөмжийн хэрэгжилтийг ярихаар ингээд тэд 2 нь хэрэгжээгүй, тэд нь хэрэгжээгүй л гэж байгаа юм. Тэр чинь

дандаа энэ бодлогын асуудалтай холбоотой зөвлөмжүүд байгаа шүү дээ.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууя.

**М.Оюунчимэг:** 2020, 2021 он ковидын үе гээд бид нар амаргүй үеийг туулсан. 2022 оны эхээр ямар ч байсан 3.9 хувийн ажилттай байсан эдийн засаг оны сүүлээр 2022 оны 4.8 хувьд өссөн. Валютын нөөц бас 3.4 тэрбум ам.долларт хүрсэн гээд нааштай үзүүлэлт бол байгаа. Энэ бол Улсын Их Хурал, Засгийн газрын хувьд ямар ч байсан гадааддаа боомт чадавхыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, хил гаалиа нээх, дотооддоо хулгай авлигалтай тэмцэх талаар нэлээд дорвитой арга хэмжээнүүд авч энүүгээр Улсын Их Хурлын тогтоол гаргаж Засгийн газрын зүгээс бас зарим ажилд бас тууштай явсан. Үр дүнг бол энэнээс харж байгаа. Энийг бас бид үгүйсгэх аргагүй. Миний хувьд жишээ нь 2017 оноос хойш нийслэл Улаанбаатар хотын хувьд жишээлбэл хамгийн хүндрэлтэй асуудал 3 ээлжээр хичээллэх сугалаагаар цэцэрлэгт явдаг байдлыг халах энэ дээр ялангуяа 200 гаруй тэрбум төгрөгөөр асуудлыг шийдсэн. Одоо ямар ч байсан сугалаагаар цэцэрлэгт явдаг бол байхгүй болсон гэж байгаа.

Харин 3 ээлжээр хичээллэх нэг ангид олноороо суух энэ асуудал бол бид халж байгаа гэсэн утгатай зүйлийг сая Сангийн сайд мэдээлэлдээ хэлж байна. Энэ яг бодитой юу? Одоо хичээл намар эхлэхэд 3 ээлжээр хичээллэх эсвэл нэг ангид олноороо суух энэ байдал халагдсан гэж ойлгож болох уу? Энэ Боловсролын яамнаас бас хүн байна уу? Энэ дээр нэгд хариулт өгөөч ээ гэж хэлье.

Хоёр хүндрэлтэй асуудал байгаа юм. Энэ бид маш их ярьж байгаа юм. Сая 1.5 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдсэний үр дүнд 1580 ААН нэгжид ажиллаж байгаа 34 мянга орчим хүний

ажлын байрыг хадгалж чадсан гэж байна. Энэ бол бид нар тог цахилгаан нийгмийн даатгал гээд л маш олон төрөөс төлдөг байсан шимтгэл татвар хураамжуудыг бүгдийг нь зогсоосон. Энэ бас ААН-үүдээ тэр ажлын байр хадгалах энийг бол ковидын үед нөгөө Их Хурал Засгийн газраас авч хэрэгжүүлсэн нь энэ ажлын байрыг хадгалах бас нэг суурь болж өгсөн. Харин шинээр ажлын байртай болгох нэг түр болон дунд хугацаанд ажлын байраа хангах гээд тэр 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд бараг 2, 3 их наяд төгрөгөөр шинэ ажлын байр бий болгох хүмүүсийг ажлын байр сургах төслүүд хэрэгжүүлсэн. Гэхдээ яг өнөөдрийн байдлаар ажлын байр дорвитой нэмэгдсэн үзүүлэлт харагдахгүй байгаад байгаа юм. Түрүүний тэр ядуурал бол 40 гаруй хувьтай байна гэдгийг Үндэсний статистикийн газраас ч хэлээд байгаа. Энэ нөгөө мэдээж гадаад хил гааль, хаалттай, мах гурилын үнэ 60, 70 хувиар өссөн зэрэг нь их нөлөөлөд байна л даа. Тэгэхээр энэ 2022 оны гүйцэтгэл дээр жишээ нь үнэ ханшийг тогтвортой барих чиглэл дээр эсвэл үнэ ханшийг илүү нэмэгдүүлэхгүй байх чиглэл дээр авсан арга хэмжээнд дорвитой үр дүн харагдсан байна уу? Энэ дээр би аудитын газраас жишээлбэл яг энэ дээр асуулт асуухыг хүсэж байна. Бид нар бол энэ үнэ тогтворжуулах хөтөлбөр. Сая хэлж байна. одоо хүмүүсийг ядуурлаас аварч аль болохоор ажлын байранд сургахын тулд тэр 10 их наяднаас 3 их наяднаар бараг хүмүүс сургасан гээд байгаа юм. Өнөөдөр яг шинээр энэний үр дүнд ажлын байртай болчихсон энэ дорвитой нөлөөлчихсөн зүйл хэд байна? Яагаад ядуурал буурахгүй өнөөдөр 40 гаруй хувьтай болчихоод байна. Энэ дээр та бүхэн маань бас энэ хязгаарлагдмал дүгнэлт гэдэг дээр нийгмийн чиглэл дээр бас харагдаж байна л нарын маань өгсөн дүгнэлтээс хараад байхад. Тэгээд энэ дээр нэг хариулт өгөөч ээ гэж нэгд асууя.

Хоёрт нь энэ ялангуяа 2020 оноос хойш ганц зогсчихсон салбар энэ

Улаанбаатар хотын гэр хорооллын дэд бүтэцжүүлэх асуудал бүр таг зогсчихсон. Өнөөдөр бараг хариуцах эзэн ч байхгүй болчхоод байх шиг байна л даа. БХБЯ-наас асуухаар нийслэл Улаанбаатар хот хариуцаж байгаад нийслэл Улаанбаатар хот нь болохоор Барилга хот байгуулалтынх гээд. Тэгээд сүүлдээ Ерөнхий сайд Засгийн газрын тэргүүн бүр Барилга хот байгуулалтын сайдаар ахлуулаад гэр хорооллыг хөгжүүлэх энэ асуудлаар ажлын хэсэг энэ 2023 он гаргаад хийж байх шиг байна. Энэ 2022 оны сөрөг санал, дүгнэлт гэдэг дээр аудитын дүгнэлт дээр байна л даа. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл гэрээ сунгаагүй, аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 2022 онд НЗД А1264, А1616 дугаар захирамж гаргасан.

**Г.Занданшатар:** Аудитын газрын дарга Энх-Амгалан сайд эхлээд хариулчихъя. Дараа нь аудитаас асуулт асуулаа.

**Л.Энх-Амгалан:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Оюунчимэг гишүүн 3 ээлжийн сургуулийн асуудлыг хөндөж асууж байна. Энэ бол хамгийн тулгамдсан асуудал байгаа. Тэгэхээр ер нь яагаад ингээд 3 ээлжийн сургуульд орчихсон юм бэ гэдэг бид нар энэ асуудлыг нэлээн тийм цогцоор нь харах ёстой юм билээ Оюунчимэг гишүүн ээ. Энэ бол ганцхан энэ Боловсролын яамны ажил гэхээсээ илүү хоттойгоо бид нар уялдаж ажиллах нэлээн тийм том шаардлага үүсчихсэн байгаа. яг өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд яг 3 ээлжид орж байгаа эрсдэлд орохоор байгаа 47 сургууль байна. 47 сургууль улсын хэмжээнд. Ингээд энэ дээр бол нэгд суралцаж байгаа 33 мянган хүүхэд байна гэсэн тооцоолол урьдчилж гарсан. Тэгээд энэ намар бид нар энэ хичээлийн шинэ жилийг эхлэхээс өмнө ингээд энэ 3 ээлжийн сургуулиуд дээр нь

онцгойлон арга хэмжээ авъя гэж төлөвлөж байгаа. Тэгээд ерөнхийдөө цаашидаа нэг ангид бид нар 45 хүүхдээс дээшээ ерөөсөө бүлэг бүрдүүлэхийг хориглох нь зүйтэй юм байна гэж бодож байгаа. Тэгэхгүй бол нэг ангид бид нар тавиулаа, жаруулаа суучхаад тэгээд ингээд боловсролын чанарын асуудал ярина гэдэг их хүндрэлтэй ийм асуудал байгаад байгаа. Тэгэхээр мэдээж энэ 3 ээлжийн сургуулиудыг бид нар шийдэхэд дунд хугацааны төлөвлөлт болон яг богино хугацааны авч хэрэгжүүлэх асуудлууд гэж бид нар 2 салгаж үзэж байгаа юм. Дунд болон урт хугацаанд бол мэдээж бид нар энэ хөрөнгө оруулалтын асуудлуудаар сургууль барьж шийдвэрлэгдэнэ. Тэгээд сая Улсын Их Хурал дээр 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Эдийн засаг хөгжлийн сайд батлуулахад Эдийн засгийн хөгжлийн сайдад 2024 оны улсын төсөв дээр барих хөрөнгө оруулалтын бодлого бол энэ 3 ээлжид орох эрсдэлтэй сургуулиудынхаа хөрөнгө оруулалтын асуудлуудыг шийднэ ээ гэдэг ийм зарчмыг Улсын Их Хурал дээр бас батлуулсан.

Тийм учраас 2024 оны улсын төсөв дээр бид нар дунд болон урт хугацаанд эрсдэлд орох гэж байгаа сургуулиудынхаа өргөтгөл шинэ сургуулиудын асуудлуудыг бид нар онцгойлон хөрөнгө оруулалтын бодлогоороо барина. Энэ жил яаж ноднингийн нөгөө нэг цэцэрлэгийн хүртээмжийг шийдсэн шиг энэ 3 ээлжид байгаа сургуулиуд дээр яг ямар шийдлүүд байна вэ гэхээр бид нар түрээсийн байруудыг бид нар бас хайж байна. Гэхдээ нэг сургуулийн зориулалтаар бид нар болгож засаж тохижуулна. Тэрнээс биш сургуулийн зориулалтын бус байранд оруулчхаад тэгээд 3 ээлжийн сургууль шийдлээ гэж хэлж болохгүй л дээ, тийм ээ.

Тэгэхээр энийг одоо бид нар бас нэлээн судалгаанууд хийгдэж байна. Тэгээд бас ер нь ерөнхийдөө энэ банкны энэ Хөгжлийн банк гэдэг юм уу, ингээд энэ

арилжааны банкнууд дээр байж байгаа нийгмийн даатгалын сангийн эрсдэлд орох гээд байгаа энэ банкнууд дээр байршуулсан хөрөнгө дээр хураагдсан барилгууд гэдэг юм уу энэний жагсаалтуудыг бас бид нар нэлээн үе шаттай судалж байна. Бид нарын яг ачаалал үүсчихсэн байгаа дүүрэг газрууд дээр яг иймэрхүү хэмжээний барилгууд байх юм бол бид нар тэр сургууль болгож зохион байгуулах хэлбэрээр ашиглах нь зүйтэй юм байна гэж харж байгаа. Тэгээд гол асуудал бол Оюунчимэг гишүүн ээ нөгөө улсын хэмжээнд чинь 70 мянган хүүхэд 1 дүгээр ангид ороход 12 мянган хүүхэд 12 дугаар анги төгсөж байгаа шүү дээ. Тэгээд нэг ийм зөрүү гараад байгаа юм доороосоо. Тэгээд энэ зөрөө бол.

**Г.Занданшатар:** Аудит 83 хариулчих.

**Ц.Наранчимэг:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар Наранчимэг. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд цогц хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу санхүүжүүлсэн санхүүжилтийг бол өмнөх нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар үзсэн байгаа. Энэ аудитаар нийт 4.2 их наяд төгрөгийг 62.7 мянган зээлдэгчид олгоод 144.6 мянган ажлын байрыг бий болгосон эдийн засгийг эргэлтэд оруулсан ийм нөхцөлийг бүрдүүлсэн ажил болжээ гэж ингэж дүгнэсэн. Энэ жилийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайланд хийсэн аудитаар нийт 7 хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 73.9 тэрбум төгрөгийг зарцуулж 34009 ажлын байр бий болгосноос 6124 ажлын байр байнгын 21286 ажлын байр түр, 6599 ажлын байрыг цагийн ажлын байрыг бий болгосон байна гэж ингэж аудитын тайлан дээр дүгнэсэн байгаа. 144.6 мянган ажлын байрыг яг бодитоор бий болсон уу, үгүй юү гэдэг дээр төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэлийн

аудит хийгээгүй учраас бид яг өөрсдийнхөө нотлох баримтын хүрээнд тоон хэмжээнд үзсэн асуудлаа бол эдийн засгийг сэргээсэн ийм ажил чухал нөлөө үзүүлсэн байна гэж ингэж дүгнэсэн. Тэр дэд бүтэцтэй холбоотой асуудлыг манай Гүйцэтгэлийн аудитын газрын дарга хариулна.

**Г.Занданшатар:** 87.

**Д.Энхболд:** Гүйцэтгэлийн аудитын газрын дарга Энхболд.

Оюунчимэг гишүүний асуултад үргэлжлүүлэн хариулъя.

Дэд бүтцийн холбоотой асуудлууд дээр төсвийн ерөнхийлөн захирагчийн бус багад байгаагаас шалтгаалж, удааширалтай чухал ач холбогдол бүхий төслүүдийн санхүүжилт нь шийдвэрлэлт удааширалтай байгаагаас үр өгөөж нь хойшилж эрсдэлд хүргэж болзошгүй байна гэсэн ийм дүгнэлтийг хийсэн. Энэ дээр бол Барилга, хот байгуулалтын сайдын багцын Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 ГД 800-гийн гол шугамыг мянган мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв угсралтын ажил төсөл арга хэмжээ хотын дулаан хангамжийн чухал ажил хэдий ч 2014 онд эхэлсэн ажил. 2014 онд гэрээг нь байгуулж ажил эхлүүлээд хугацаа алдсан. 2017 онд гэрээг нь байгуулж ажлыг эхлүүлсэн энэ дээр бол санхүүжилтийг шийдвэрлэх асуудал хангалтгүй байгаа. Мөн төсөл арга хэмжээ олон жил үргэлжлэх нөхцөл бүрдэж төсөл арга хэмжээний төсөвт өртөг 24.9 тэрбум төгрөг хэдий боловч санхүүжилт одоогийн байдлаар дөнгөж 4.2 тэрбумын санхүүжилттэй явж байгаа. Үүний үр дүнд энэ 3.4 км урт шугамын ажлаас 0.49 км шугамын ажил л хийгдсэн. Энэ маань яагаад ийм чухал ач холбогдолтой байгаа вэ гэхээр Ханын материал, Баянхошуу, Хархорин зах, Эрин, Өнөр хороолол, 1, 3, 4, 10 дугаар хороолол, хотын төвийн хэсэг, Цирк, Баянгол зочид буудал, МУБИС,



Усан бассейн, Сансар, 13 дугаар хорооллын хойд хэсэг 15 дугаар хорооллын орчмын хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангадаг гол магистрал шугам байгаа юм. Энэ асуудлыг яаралтай шийдвэрлэхгүйгээс болоод мөн Эрчим хүчний сайдын багцад бус Барилга, хот байгуулалтын сайдын багцад байлгаад байгаа нь энэ төсөл арга хэмжээний хэрэгжилтэд бас нэлээд сөргөөр нөлөөлөх магадлалтай байна гэж аудитор үзсэн байгаа.

**Г.Занданшатар:** Оюунчимэг гишүүн нэг минут.

**М.Оюунчимэг:** Бид энэ өмнөх оныхоо гүйцэтгэлийн санхүүгийн тайланг хэлэлцэж байгаагийн гол утга агуулга нь аудитын хамгийн гол учир нь Улсын Их Хурал ингээд чуулганаараа хэлэлцэж байгаа нь энэ алдаа дутагдал аудитын энэ сөрөг хязгаарлагдмал гэсэн ямар хариуцлагыг тооцоод дараа нь яах вэ гэдэг өөрөө маш чухал. Манай аудитынхан бас ингээд дүгнэлтээ сүүлийн үед сайн гаргаж байна. Одоо тэгээд тэгээд хэн хариуцах вэ? Саяын хэлсэн Улаанбаатар хотын гэр хороолол гээд тэнд 70 хувь нь амьдарч байгаа иргэд хүлээлттэй байна.

Хөрсний бохирдлоос болоод хавдрын өвчлөлөөр нь дэлхийд бараг нэгд орчмоод байна. Тэгэхээр энэ хариуцлага гэдэг асуудлыг бид яримаар байна. Яг тооцоод дараа жил энэ давтагдахгүй байх нь өөрөө чухал байгаад байна шүү дээ.

Хоёрт нь тэр ажлын байртай холбоотой тэр энэ танай дүгнэлт дээр бас байгаа байхгүй юу. Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг тогтворжуулах, ажлын байр нэмэгдүүлэх, батлан даалтын 7.4 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд шилжсэн байна гээд. Үгүй ээ яагаад энэ нөгөө ажлын байрыг нэмэгдүүлэхэд чинь бараг 8 орчим тэрбум

төгрөг чанаргүй зээлийн анги руу шилжлээ.

**Г.Занданшатар:** Аудитын хуулиа унш. Занданбат дарга хариул 81.

**Д.Занданбат:** Бид нар 2022 оны аудитаар нэлээдгүй газруудыг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн байгаа. Ер нь аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зайлшгүй. Гэхдээ энэ нь бодит байдал дээр хэрэгжилт одоо бас хангалтгүй байдаг. Тэгэхээр энэ дээр бид нар ер нь хууль эрх зүйн орчноо эргээж харъя. Сая одоогийн Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа төсвийн хууль дээр бол зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэх тал дээр процессын үйл ажиллагааг өгсөн санал оруулаад явж байгаа. Өөрөөр хэлбэл шалгагдагч байгууллага зөвлөмжийн хэрэгжилтийг хангахын тулд зөвлөмж өгснөөс 30 хоногийн дотор зөвлөмжийн хэрэгжилтийн талаар төлөвлөгөө гаргаж ирүүлнэ. Төсөл хэлж байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр улсын 2022 оны төсвийн нэгдсэн гүйцэтгэлийг л ярьж байна л даа. Бид төсвийн үндсэн үзүүлэлтүүдээ харахаар төсвийн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр Засгийн газрыг нэлээн гайгүй ажиллачихсан юм уу гэмээр үд үр дүн харагдаад байгаа юм. Төсвийн орлогын хангалт ч тэр, зарлагын асуудал ч тэр. Төсвийн тэнцлийн алдагдлыг бууруулсан байдлыг ч харсан. Гэхдээ дотор нь нарийсгаад үзэхээр бидэнд асуудал байх шиг байна гэж. Бид нэгдсэн төсөвтэй улс. Гэхдээ улсын төвлөрсөн төсөв орон нутгийн төсөв гэж 2 ангилалтай төсөвтэй яваад байгаа улсууд. Нэгтгээд харахаар гайгүй үзүүлэлт харагдаад байгаа хэрнээ төвлөрсөн төсөв, орон нутгийн төсөв, 2-ын хоорондын харьцаан дээр асуудал

үүсээд байх шиг байна. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл төсөөллөө хангаж барихад дам дамаан нэгдсэн төсөвтэй улс орны хувьд энэ 2 шатлалын төсвийг ямархуу байдлаар хариуцлагажуулж хооронд нь уях юм бэ гэдэг асуудал нэлээн чухал байгаад байна уу гэж надад харагдаад байгаа юм.

Тийм учраас энэ тал дээр манай аудитын байгууллагаас ямар бодол чиглэл байна вэ? Энүүнийг нэг сонсмоор байна.

Хоёр дахь зүйл гадаад өрийн асуудал бид яриад байгаа юм. 5 их наядаар өсжээ одоо өмнөх жилээсээ. Тэрний 4.4 их наяд нь ханишийн зөрөөнөөс болжээ. 0.6 орчим их наяд нь бол төсвийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд ашиглажээ. 35 байсан юмыг тавин хэд болгожээ гээд ингээд ярьж болж байна л даа. Тэгэхээр 2.4 их наядын алдагдалтай төсөв баталсан. Түүний 35 гэхээр зэрэг 800 орчим тэрбумыг нь гадаад хөрөнгийн эх үүсвэр дайчлаад нөхөж болохоор ийм л чиглэл өгөгдсөн байна. Юун дээр гүйцэтгэлийг бодитой харахаар зэрэг 570 орчим тэрбумыг нь гадаад хөрөнгийн ашиглалтаар нөхчихсөн юм байна гэж ингэж харагдаад байдаг. Гэтэл бид нарын анх харж байсантай харьцуулахаар зэрэг дотор нь багтчихаад байдаг. Тэгээд энэ мэтчилнээр энэ чинь харсан юмныхаа дотор багтчихаад. Тэгсэн хир нь ээ нийт гаргасан алдагдал дотроо харьцуулахаар зэрэг тоо нь өсчхөөд байгаа энэ тэр гээд ийм зүйлүүд байгаад байгаа юм. Энийгээ ер нь хэдүүлээ яаж зохицуулах юм.

Ер нь энэ гадаад зээлийн асуудлыг нэлээн бодитой харж бууруулах талын арга хэмжээ авахгүй бол хугацаа уртасгаж байгаа өртөг хямдруулж байгаа гээд ярьж болох ч ханишийн зөрүүн дээрээс гэхэд л бид арван хэдэн хувийн өртөгжилт үүсгэхээд байгаа байхгүй юу. Нэг ам.доллар 500 гаруй төгрөгөөр нэмэгдчихээр зэрэг бид нарын авч ашиглаж байгаа зээлийн чинь өртөг арван хэдэн хувиар нэмэгдчихээд байгаа

байхгүй юу. Тэгэхээр энүүнийг бууруулах чиглэлийн арга хэмжээг ер нь бид ямархуу байдлаар барьж явах ёстой юм бэ. Энэ дээр одоо би Сангийн яамыг тодорхой хариулт өгөх болов уу гэж бодож байна.

Гурав дахь нэг гол зүйл байгаад байгаа юм. Үгүй ээ ерөөсөө энэ Монголын эдийн засгийн чинь амьдрал энэ нэг хэдэн заяагдмал баялаг дээр тулгуурлагдчихсан төрийн өмчтэй компаниуд дээр чинь байгаад байгаа юм. Энүүнийхээ сахилга хариуцлагыг сайжруулахгүй бол энэ жилийн үйл явц дахиад давтагдана. Тэр долларын хани 500 хэдэн төгрөгөөр нэмэгдсэн явдал чинь гадагшаа гаргасан бүтээгдэхүүний төлбөр орж ирээгүйтэй холбоотой шүү дээ.

Өмнө нь баахан урьдчилсан төлбөр аваад бүтээгдэхүүн нийлүүлээгүй байж байгаад сая нийлүүлчихсэнтэй холбоотой. Тэгэхээр энийг яаж зохицуулах юм гэдэг асуудал нэг.

Хоёрдугаарт өөрийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй төсөл арга хэмжээ санхүүжүүлээд байгаа энэ төрийн өмчтэй компаниудаа яах юм. Эрдэнэт нийгмийн асуудлыг.

**Г.Занданшатар:** 81. Аудитын газрын дарга Занданбат.

**Д.Занданбат:** Батжаргал гишүүний асуултад хариулья.

Улсын төсөв орон нутгийн төсвийн хооронд нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хянах явцад энэ зөрүү бас их гараад байгаа юм. Тэгээд энэ нь яах вэ зүгээр хууль, эрх зүйн орчин нь бас нэг уялдаа холбоо нь бас төдийлөн уялдаж өгөхгүй байгаа юм байна уу гээд. Жишээлбэл төсвийн тухай хуулийг төсвийнхөө гол салбар хууль нь болж энэ зохицуулагдаж байгаа. Гэтэл аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн бүрэн эрх дээр Засаг захиргааны нэгжийн удирдлагын тухай

хуулиар зохицуулагдаад эд нар нь өнөө төсвөө батална гэдэг ийм ерөнхий зохицуулалттай байгаа учраас энэ 2 дээр бол их зөрөө гарч ирж байгаа юм.

Улсын төсөв батлахдаа тухайн аймаг, нийслэлийнхээ суурь орлого, зарлагыг нь батлаад явчихдаг. Засаг захиргааныхаа нэгжийн тухай хуулиар сум дүүргийн иргэдийн төлөөлөгч нь өөрийнхөө төсвийг батлаад нэмэгдүүлээд ингээд батлаад явчихдаг ийм зохицуулалт байгаа. Тэгэхээрээ энийг бас илүү нарийвчилж зохицуулах шаардлага бас байгаа байх. Энэ дээр бас Сангийн яам хяналт тавьдгийнхаа хувьд тодорхой хариулах ёстой байх.

Ер нь бол нэгдсэн төсөвтэй. Нэгдсэн төсөвтэй байгаа учраас улсын төсөвт орон нутгийн төсөв нь улсын нэгдсэн төсөвтөө захирагдаад явах нь илүү зохимжтой. Төрийн өмчит компаниуд дээр нэн ялангуяа борлуулалтын орлого нь валют нь орж ирэхгүй байх асуудал бол валютын ханшид нөлөөлсөн гэж хэлж байна. Энэ дээр зохицуулалт өөрөө бас нарийвчлан аудит хийгээгүй болохоор бас хэлж мэдэхгүй байна.

Ер нь бол Монголбанкны үйл ажиллагааг тэр валютын хани зохихуулах үйл ажиллагааг бас амьдралд нийцсэн маягаар зохицуулах шаардлага байгаа болов уу л гэж бодож байна. Төрийн өмчит компаниудын төсвөөс гадуур зараад байгаа нийгмийн нэн ялангуяа нийгмийн чанартай дэд бүтцийн шинж чанартай санхүүжилт бол нэлээдгүй Засгийн газрын шийдвэрээр хийж явж байгаа. Тэгэхээрээ энэ Засгийн газар өөрөө ийм шийдвэр гаргахгүй буюу төсвийн хуульдаа нэгдсэн төсвийнхөө бодлогыг барьж түүндээ нийцсэн шийдвэр гаргаж явах нь илүү шаардлагатай байх. Энэ тал дээр аудит сая дүгнэлтдээ хэлж зөвлөмж өгсөн байгаа.

**Г.Занданшатар:** Чинбатын  
Ундрам гишүүн.

**Ч.Ундрам:** Би энэ аудитын тайланг уншаад бас нэлээн харамсалтай тийм дүр зураг дүгнэлтүүдийг олж харж байна л даа. Тэгээд яг ямар хариуцлага тооцогддог юм гэсэн ийм асуулт гарч ирж байна. Жишээлбэл 1 дүгээрт энэ Засгийн газрын 24 тусгай сан байдаг. Тэгээд энэ 24 санд шалгалт хийхэд санхүүгийн тайлангийн түвшинд нийт нэг их наяд 92.6 тэрбум төгрөгийн 250 зөрчил илэрсэн гэж гарч ирж байна. Сөрөг хязгаарлалттай дүгнэлт авсан. Ингээд сангуудаас харахаар жишээлбэл энэ Байгаль орчин уур амьсгалын сан гэж энэ яг юу хийдэг сан бэ? Яагаад энэ хязгаарлалттай дүгнэлт авсан юм бэ? Одоо энэ Монгол орон чинь цөлжилтөд автаад бүүр гамшиг болж байна шүү дээ. Тэгээд энэ хэдэн жил ажиллаад өнөөдөр Монгол орны цөлжилтийн түвшинийг ийм нөхцөл байдалд авчирсан сан юм болоо гээд асуулт гарч байна.

Хоёрдугаарт энэ шинжлэх ухаан технологийн салбар энийг нэлээн олон жил бид нар ярьж байгаа. Боловсрол шинжлэх ухааны сайд ч гэсэн энэ шинжлэх ухаан технологийн салбартай холбоотой асуудлуудыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэлээн ярьж байсан шүүмжлэлтэй хандаж байсан. Энэ дээр ямар арга хэмжээ авсан юм. Яагаад өнөөдөр дахиад л хязгаарлалттай тайлан авчхаад байж байгаа юм бол. ХАА-г дэмжих сан бол бүр сөрөг дүгнэлт авчихсан байна энэ тайлан дээрээс харахаар энэ санд зах зээлд борлогдохгүй хадгалах хугацаа дууссан 0.3 тэрбум төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна гэнэ. Энэ одоо тэгээд яг юу аваад нөгөөдөх нь муудчихаад агуулахдаа ингээд байлгаад сөрөг дүгнэлт авчихсан байгаа юм бол. Энэ сангийн үйл ажиллагааг яаж сайжруулах юм. Ямар арга хэмжээ энэ сангийн удирдлагуудад авч байгаа юм бэ гэсэн ийм асуулт.

Бас энэ маш олон төсөл хөтөлбөрүүд бас зогсчихсон байна л даа. Энэ 5 төслийг бүрэн, 9 төслийг хэсэгчлэн зогсоосноор 2 их наяд 745.2 тэрбум төгрөгийн зээлийг цаашид ашиглахгүй байх ийм байдалтай болчихсон байна гээд. Тэгээд энэ дээр ингээд харахаар маш чухал төслүүд хариуцлагагүй байдлаас болоод зогсчихсон байна. Энд Цахим эрүүл мэнд гэдэг төсөл зогсчихсон байна. Нэлээн асуудал гарсан сураг байгаад байгаа юм. Боловсролын чанарын шинэчлэл төсөл байна. Инженер технологийн дээд боловсрол гээд улсад маш их хэрэгтэй төслүүдийг эхлүүлчхээд нөгөө удирдлагууд нь ямар ч хариуцлагагүй эсвэл ингээд солигдсоноос болоод зогсчихдог. Цаана нь энэ салбарууд дамжаад ард иргэд хохирч байна л даа. Тэгээд энэ дээр ямар хариуцлага тооцох юм бол. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит дээр бас маш олон байгууллагууд хязгаарлалттай болон сөрөг дүгнэлт авчихсан.

Энэ сөрөг дүгнэлт дээр энэ цемент шохой ТӨХК гэж байна. Энэ одоо нөгөө манай Хөтөлийн цемент шохой компани мөн үү биш үү? Хэрвээ мөн бол одоо би сүүлийн үед энэ хэвлэл мэдээллээс авч байгаа мэдээллийг хараад гайхаад байгаа юм. Нэг болохоор ТӨХ-ны дарга маш сайн ажиллаж байгаа гээд л, маргааш нь маш муу ажиллаж байгаа болж хувираад л тэгээд тэнд чинь бүхэл бүтэн нэг сум тэр сумын ард иргэд ажилчдынх нь ар гэрийнхэн. Ингээд бүхэл бүтэн сум энэ компаниас хамаарч амьдрал нь явж байдаг. Гэтэл тэр компани нь сайн яваад байгаа юм уу муу яваад байгаа юм уу гэдгийг нь төрийг төлөөлж хариуцаж байгаа байгууллага нь мэдэхгүй. Өөр ялгаатай байр суурь илэрхийлээд л нэг бол сайлаад л, нэг бол шүүмжлээд ингээд явж байдаг. Цаана нь байгаа ард иргэдийн амьдрал хохироод байна шүү дээ. Тэгэхээр энэ саяын миний асуултууд мөн энэ байгууллагуудын сөрөг дүгнэлт ялангуяа авсан газруудад ямар хариуцлага тооцох вэ?

**Г.Занданшатар:** 83 Наранчимэг аудит, тэргүүлэх аудитор.

**Ц.Наранчимэг:** Ундрам гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд сөрөг дүгнэлт авсан тохиолдолд хариуцлага тооцох албан шаардлагыг томилдог эрх бүхий албан тушаалтанд нь хүргүүлсэн байгаа. ХАА-г дэмжих сангийн санхүүгийн тайлангийн аудитаар сүүлийн 2, энэний өмнөх 2 төсвийн жилд бол аудит хийхээс татгалзсан дүгнэлт өгсөн. Энэ дээр ХААЯ тодорхой ажлыг зохион байгуулж энэ жил бол төрийн аудитын байгууллага ямар ч байсан дүгнэлт гаргах боломжтой болж сөрөг дүгнэлтийг өгсөн байгаа. Тэгэхээр сөрөг дүгнэлтийн үндэслэл нь юу байсан бэ гэхээр тайланд 9888 харилцагчийн 179.2 тэрбум төгрөгийн авлага, 315 харилцагчийн 67.8 тэрбум төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Баталгаажуулах бас боломжгүй байгаад байна. Чанаргүй хугацаа хэтэрсэн зээлийн төлөлт бас хангалтгүй үлдэгдэлтэй байна. Урсгал үйл ажиллагааг санхүүжүүлэх төсөвгүйн улмаас 15.2 тэрбум төгрөгийн зээлийг зээлийн эргэн төлөлтөөс зарцуулсан зэрэг үндэслэлээр сөрөг дүгнэлтийг өгсөн. Хариуцлага тооцох албан шаардлагыг ХАА-н сайдад төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байгаа.

Байгаль орчин уур амьсгалын сан дээр хязгаарлалттай санал дүгнэлтийг өгсөн байгаа. Энэ дээр аудитаар нөхөн сэргээлт болон хөрөнгө орлого ноогдуулсан орлогынхоо бүртгэлийг бүрэн хөтөлдөггүй, үнэт цаасны тооцоот маягтыг авлагаар, бүртгээгүй, тооцоо нийлсэн, актаар баталгаажуулаагүй гээд бүртгэл тайлагналтай холбоотой асуудлаар хязгаарлалттай гэсэн санал, дүгнэлтийг өгсөн. Мөн өмнөх аудитаар

өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар бас өмнө нь хязгаарлалттай санал, дүгнэлтийг өгсөн байгаа. Энэ сангийн дээр байгаа гол асуудал бол төслийг хэрэгжүүлэхдээ хүлээж аваагүй эргэн төлөгдөх нөхцөлтэй болгосон зээлийн авлагыг барагдуулдаггүй нотлох баримтыг дутуу ажлын тайланг бүрэн байгаагүй гэдэг ийм үндэслэлээр сүүлийн 3 жилд төрийн аудитын байгууллагаас хязгаарлалттай санал, дүгнэлт өгч байгаа. Тийм учраас энэ жил Шинжлэх ухаан технологийн сангийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж байна. Удахгүй дүгнэлт гаргаж 9 сард тайланг нь хүргүүлэхээр ингэж төлөвлөж байгаа. Гүйцэтгэлийн аудитаар энэ сангуудын үйл ажиллагаа үр дүн үр нөлөөтэй байсан уу гэсэн асуудлыг бас тодорхой гаргаж өгөхөөр ингэж ажиллаж байна.

Хөтөлийн цемент шохойн үйлдвэрт сөрөг дүгнэлтийг өгсөн байгаа. Бид нар энэ жил Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар аливаа ТӨК-ийг хүлээж авах татан буулгахдаа заавал хаалтын тайлан буюу эхлэлтийн тайлан гаргаж аудит хийлгэж байх энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтаа хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт зөвлөсөн. Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн сөрөг дүгнэлт авсан тайлан маань эхний тайлангийн эхний үлдэгдлийг баталгаажуулаагүй тайлан баланс гаргаад явж байгаа нь бас аудитыг сөрөг дүгнэлт авахад гол нөлөөг үзүүлсэн. Мөн авлага өглөгийг баталгаажуулаагүй ийм тоон том дүнтэй нэлээд олон асуудлууд байгаа учраас сөрөг дүгнэлтийг өгсөн. Мөн холбогдох албан тушаалтанд нь хариуцлага тооцох албан шаардлагыг Монгол Улсын ЗГХЭГ-т хүргүүлсэн байгаа.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн гүйцэтгэл ярьж байна. Төсвийн гүйцэтгэл дээр бол тэгээд нэг тийм алдагдалгүй, бага алдагдалтай гэж яриад байгаа яс юман дээрээ бол Ирээдүйн өв санд байсан 1.5 их наяд төгрөгийн тэр хуримтлал бас 30 он хүртэл хэрэглэхгүй ёстой байсан. Тэр мөнгийг хүүхдийн мөнгөнд тэр чигээр нь зарцуулаад дууссан. Хэрвээ ирээдүйн өв сангийн энэ мөнгийг зарцуулаагүй бол төсвийн алдагдал улам нэмэгдэх байсан гэдгийг хэлье. Тэртээ тэргүй бас юун дээр төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр нэлээн ярих байх. Дарга нар бэлтгэлтэй байгаарай.

Хоёрдугаарт нь тэгээд 5 их наядын өр тавьчихлаа. Яг 2022 оны 1 сарын 1-ээс 2022 оны 1 сарын нэгнээс 12 сарын 31 хүртэл 26 их наяд 923 тэрбум төгрөгийн өртэй байсан бол 31 их наяд 965. Яг 5 их наяд. Тэгээд энэ их мөнгөөр юу хийв ээ? Энэ чинь 2 Чингисийн хөрөнгөтэй нийлэхүйц дүйцэхүйц хөрөнгө шүү дээ. Тэгээд энэ мөнгө ингээд сураггүй алга болчихсон. Бүтээн байгуулалт юу байна? Тэрийгээ нэрлээдэх? Ямар бүтээн байгуулалт байгаа юм тэгээд?

Дээрээс нь 10 их наядын төгрөгийн хөтөлбөр эдийн засгийг эрчимжүүлэх 10 их наяд төгрөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн зах зээл рүү асар их мөнгө оруулсан. Тэгээд үүний үр дүнд нь 2022 оны 1 сарын 1-нд 2830 төгрөг байсан нэг доллар 2830 төгрөг байсан бол 12 сарын 31-нд 3450 болгоод бүүр 20 хувиар унагаагаад хаячихсан. 10 их наяд дээрээс нь одоо ингээд төсвийн үргүй зардлууд мөн түүнчлэн 5 их наядын гадаад өр энэ бүхэн чинь нэмэгдээд ерөөсөө инфляцыг хэт хөөргөсөн. Одоо жишээ нь 2022 оны 7 сард инфляц 16.9 хувьтай байсан байна шүү дээ. Энэ зүгээр статистик тоо шүү. Статистикийн газраас гаргаж байгаа тоо. Энэ эрх баригчдын хяналттай гаргаж байгаа тоо. Яг тэгээд одоо

жишээ нь 2022 оны нэг жоохон гялтайсан юм нь нэг тэтгэвэр нэмсэн байх. 2 сард 50 мянган төгрөгийн үнэтэй байсан уут гурил тэр оны эцэс гэхэд 110 мянган төгрөг болчихсон шүү дээ. 110 хувиар нэмэгдсэн. Тэгтэл энэ дээр хамгийн гол бүтээгдэхүүн 112 хувиар өсчихсөн байж байхад энэ инфляц 16.9 гэж Статистикийн төв газар гаргаад байгаа юм л даа. Худлаа тоо л доо. Тэгээд та нарын хийж байгаа юу энэ эдийн засгийг удирдаж байгаа энэ бүх зүйл чинь ерөөсөө л энэ ард түмнийгээ карманд байгаа тэр мөнгө хөрөнгө мөнгийг инфляцад идүүлээд л хулгайлж авах тухай л тийм зүйлийг хийж байгаа. Тэгээд өнөөдөр нэг сайхан юм болчихсон юм шиг оруулж ирж байгаа юм. Засгийн газрын тайлбараар. Яах вэ аудитын газар нэг жоохон жоохон энэ дүгнэлт энэ тэрээ бас нэг жоохон сүүлийн үед нэг жоохон эвтэйхэн гаргадаг болчихоод байгаа юм. Тэгээд тэрний дагуу арга хэмжээ авч байгаа юм уу? Их Хурал энэ дээр бас шаардлагатай ажиглах ёстой шүү.

Яг тэр аудитын зөрчилтэй дүгнэлтүүд дээр тодорхой шийдлүүдийг гаргах ёстой. Тэгээд хамгийн сүүлд нь бас нэг асуулт байна. Яг цалингийн зардалд хэд гаргаад байгаа юм бэ? Яг цалин. Энэ 2023 оны улсын төсөв чинь нийтдээ 20.5 их наядын зардалтай. Тэрний дөнгөж 1.9 их наяд нь л цалингийн зардал байгаа шүү дээ. Тэр үлдсэн мөнгөөр юу хийгээд байна. Энэ ордон дотор өдөр болгон хурал зохион байгуулах юм, хөдөөгөөс хүн авчраад л хуралдаад байх юм. Хуралдаад ямар ч хийсэн юм байхгүй.

**Г.Занданшатар:** Хэн хариулах юм. Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Манай Зарлагын хяналтын дэд хорооны дарга маань зарим тоонуудаа буруу зөрүү санаатай хэлдэг юм уу, хэлдэггүй юм уу мэдэхгүй зөрүүлж

тайлбарлаад байгаа нь харамсалтай байна. Бүтээн байгуулалт хийгдсэн үү, хийгдээгүй юу гэж та асуух юм. Та 8 жил суухдаа танайд баригддаг сургууль цэцэрлэг нэг ч баригдаагүй юу? Тэгж болохгүй шүү. Дэд бүтэц ялангуяа нийгмийн салбарын сургууль, цэцэрлэг өнөөдөр түрүүн Энх-Амгалан сайд хэллээ. Сургууль цэцэрлэгийн хангамж ямар юутай байгааг. Ховд аймаг бас муугүй байгаа л гэж би ингэж бодож байна. Ховдод ингээд Эрдэнэбүрэнгийн УЦС гээд би танин мэдэхүйн мэдэх ёстойнуудыг чинь л би дөнгөж зүгээр захаас нь дурдаж байна шүү.

Өнөөдөр 2019 онд ДНБ 36 их наяд байсан юм. Энэ жилийн гүйцэтгэлээр 60 их наяд давж гарна. 3 жилийн дотор бол дал гаруй хувиар ингэж өсөж байгаа юм. Энэ бол төсвийн гүйцэтгэл бүтээн байгуулалт эдгээрээр дамжиж хувийн хэвшлийн эдийн засгийн өсөлт гадаадын шууд хөрөнгө оруулалтууд нэмэгдэж байгаа. Гадаад худалдааны эргэлт анх удаа 2 оронтой тоонд орж, 12 тэрбум долларын экспорт бид нар ноднин жил хийсэн байгаа юм.

Ингээд сайн үр дүнгүүд гарсан Пүрэвдорж сайд аа. Пүрэвдорж гишүүн ээ, та тэгээд сайн нүдээ нээгээд харна биз ээ? 10 их наядын хөтөлбөр түүхэн үүргээ гүйцэтгэсэн, түүхэн үүргээ гүйцэтгэсэн. Аудитын тайлан дээр дурдсанаар 144 мянган ажлын байр алдах байсныг бид хамгаалж чадсан байгаа. Энэ түүхэн үүргээ гүйцэтгэж энэ ковидын үеийн энэ хүндрэлийг бид харин ч эрсдэл багатай давахад эдийн засагт маань хүндрэл багатай давахад маш сайн үүрэг гүйцэтгэсэн. Засгийн газрын амжилттай хэрэгжүүлсэн хөтөлбөр байлаа. Цалингийн зардлыг та бас л дутуу хэлж байна. 1.9 биш шүү 4 их наядын. Энэ жил нэмэгдчихээд ингээд цалин сая 1.9-өөс чинь бараг 900 тэрбум дангаараа цалин байгаа юм. Хойтон дабльдаад 1.8 болж орж ирнэ. Хойтон 5.8 их наядын ийм цалингийн төсөв орж ирнэ ээ гэсэн үг.

Нийт төсвийн маань үндсэндээ 5-ны 1 нь ингээд цалингийн зардалд гардаг. Бусад нь хааччихав гэх юм. Бусад нь энэ төрийн байгууллагуудын төрийн үйлчилгээний зардлууд шүү дээ. Энэ төрийн байгууллагуудын бүрэн санхүүжилт өөрөөр хэлбэл ард иргэдэд очиж байгаа төрийн үйлчилгээг санхүүжүүлж байгаа юм. Эндээс нэг 2.8 их наяд нь хөрөнгө оруулалтууд байдаг.

Өнгөрсөн жилүүдийн хөрөнгө оруулалтуудыг гүйцээж байгаа. Шинэ хөрөнгө оруулалтууд гээд жилдээ нэг 10-15 хувь нь нийт төсвийн энэ хөрөнгө оруулалтад зарцуулагдаад явдаг. Бусад нь бол ингээд төрийн байгууллагуудын урсгал зардалд байдаг. Манай нийт урсгал зардал бол 80 хувь байдаг юм шүү дээ. Төсвийн юм байна ийм юм байгаа юм. Ирээдүй өв сан гэж байна. Ирээдүй өв сангийн үлдэгдэл 2.7 их наяд байгаа. Хойтон энэ жилийн гүйцэтгэлээр 3.4 их наяд болох ёстой, жилийн эцсээр. Эдийн засгийн үнэхээр хүнд төсөв мөнгө хүнд байх үед Ирээдүй өв сангаас хүүхдийн мөнгийг тавьж олох бид ийм хууль баталж аваад энэ хуулийн дагуу ингээд болгочихсон зүйл байгаа. Энэ хэмжээгээр өөрөөр хэлбэл ирээдүй өв сан маань энэ хүнд жилүүдийг төсөв дээрээ бид нар ачааллыг арай багасгаж ийм бодлого хэрэгжүүлсэн гэсэн үг. 2024 оны 1 сарын 1-ээс хуучин зохицуулалтаараа ирээдүй өв сангийн орлого маань шууд нэмэгдээд явна. 3.4-өөсөө дээшээ нэмэгдээд явна гэсэн үг.

Аудитаас нэмж хариулах зүйл байвал хариулна биз.

**Г.Занданшатар:** Аудит. Чи надаас асуулт асуухгүй л дээ. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон бүх Байнгын хороонд шилжүүлнэ. Тэгээд тэрэн дээр та хэд наад юмнуудаа нарийвчилсан юмнуудаа. Тэрэн дээр саналуудаа саяын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу ярих юмаа ярина за юу.

**Г.Занданшатар:** Пүрэвдорж гишүүн нэг минут.

**Б.Пүрэвдорж:** Энэ урсгал зардал чинь хэтрээд байна. Тэр нь дандаа дарга нарын зардал болж хувираад байна. Би та нарт ганцхан л юм хэлье. Би 2012-2016 оны хооронд Гадаадын харьяатын даргаар ажиллаж байсан. Тэгэхэд манай нийт зардлын 85 хувь нь цалингийн зардал байсан. Үлдсэн 15 хувь нь урсгал зардал байсан урсгал зардал. Одоо Энэ байгууллагын зардал байна шүү дээ тэ өнөөдрийн байдлаар 76, 77 хувийн зардал юу нь цалингийн зардал байгаа. Нийт зардлынх нь. Тэгээд нэгээ 23, 24 хувь нь л урсгал зардал байгаа. Тэгэхээр нэг байгууллага дээр нь ийм өндөр байдаг. Тэгтэл өнөөдөр нийт зардлын чинь 80 хувь нь урсгал зардал байна гэж та хэлээд байна шүү дээ. Яагаад байгууллагууд ийм зөрөөтэй байгаад байгаа юм. Энэ мөнгө хайчаад байгаа юм.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны гүйцэтгэлд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон асуулт үг хамт яваад дуусчихсан. Тэгээд Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлнэ. Тэгээд Пүрэвдорж гишүүн ээ ер нь энэ жилийн тоонууд бас яриад байгаа юм.

Ер нь хэлэлцүүлэгт анхаарах 2 зүйл байна. Яах вэ 1 дүгээрт 2022 оны төсөв эдийн засгийн өсөлт 2.6 хувиар төлөвлөснөөс 4.8 хувьд хурч өссөнөөр төсвийн орлого нэмэгдэж, төсвийн алдагдал буурч харьцангуй сайн гарсан.

Нийт үзүүлэлт төсөв сайн гарсан шүү 2022 онд. Нийтдээ 2.8 их наяд

төгрөгийн 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай төлөвлөснөөс 1 их наядын 1.1 их наядын алдагдалтай гарсан. 1.8 их наядаар төсвийн алдагдал буурсан. Энд бол инфляц төлөвлөснөөс өндөр 13.2 хувиар өндөр гарсан учраас ер нь төсвийн зарлага 731 тэрбум төгрөг зарцуулагдаагүй. Төсвийн орлого нэмэгдсэн. Энд инфляцын ч нөлөө бий. Нөгөө талдаа энэ гол нүүрсний экспортыг 184 доллароор 1 тонн нүүрсийг тооцсон нь 204 доллар болсон нь гол нөлөөлсөн.

Зэсийн үнэ жоохон бага буурсан ч гэсэн 9 мянгаар төлөвлөсөн нь 8800 байсан ч гэсэн төсвийн биет хэмжээ зэсийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн учраас харьцангуй төсөвт бага нөлөөлсөн. Ингээд нийт дүнгээрээ төсөв харьцангуй сайн гарсан гүйцэтгэл. Гэхдээ сая яригдсан асуудлаар энэ сангуудын асуудал энэ олон асуудал төсвийн зөрчилтэй сөрөг дүгнэлт гарсан тохиолдолд Аудитын тухай хуулийн 42.1-д заасны дагуу нэгийг үндэслээд 42.3-ын дагуу аудитын байгууллага сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага төсвийн ерөнхийлөн захирагчид хүргэх ёстой. Та нар мэдэгдсэн гэж яриад байх юм. Албан шаардлага өгнө. Ажлаас халах шийтгэлийн арга хэмжээ авах үндэслэл болно. Сөрөг дүгнэлт авсан, аудитын дүгнэлтэд мэдээ дутуу ирүүлсэн тайлагнаагүй саад учруулсан бол сөрөг дүгнэлт авсан бол санхүүгийн тайлангийн сөрөг дүгнэлт авсан бол ажлаас халах үндэслэл болж аудитын байгууллага шаардлага хүргүүлэх ёстой. Энийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо үзээд тэр сангууд болон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг үндэслээд тэр арга хэмжээг авах хэрэгтэй. Мөн гэмт хэргийн шинжтэй үйлдэл байх юм бол прокурорын байгууллагад Ерөнхий прокурорт Ерөнхий аудитор албан ёсоор бичгээр хүсэлт тавьж эрүү үүсгэж шалгуулах ёстой. Энэ асуудлуудыг төсвийн зарлагын хэлтсийн дэд хороо энэ зөрчил дутагдалтай холбоотой асуудал, гэмт хэргийн шинж

бүрэлдэхүүнтэй, шинжтэй бол Ерөнхий прокурорт хандаж тэрнээс албан мэдэгдэл хариу авсан байна уу гэдгийг шалга за юу. Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль чинь ингээж хэрэгжинэ.

Аудитын байгууллага үүргээ гүйцэтгэсэн байна уу? Төсвийн ерөнхийлөн захирагч нар үүргээ гүйцэтгэсэн байна уу үгүй юү гэдэг. Ер нь яах вэ зэсийн болон түүхий эдийн үнэ өндөр байснаас болон мэдээж инфляц Ганбаатар гишүүний асуугаад байгаа бол энэ төсвийн зарлага төсвийн тэлэлт одоо мөнгөний бодлогыг хатууруулахаас өөр аргагүйд хүрч байгаа юм. Тэгээд энэ жил төлбөрийн тэнцлийн нөхцөл байдал валютын ханшийн нөхцөл байдал инфляцын ханшийн нөхцөл байдлаа үндэслэж ер нь нөөц нэмэгдэж валютын ханиш 110 төгрөгөөр буурч байсан ийм сайн хандлага байгаа. Тэгээд энэ Монголбанкнаас шалтгаалахгүйгээр төсвийн тэлэлтээс шалтгаалаад ирэх жилүүдэд гарч болох эрсдэлийг сайтар тооцох асуудал дараа жилийн төсвийн чиг хандлага дээр үндсэндээ 10 их наяд төгрөг ирээдүй өв санд тухайн үеийн ханишаар төвлөрүүлсэн бол 4 тэрбум долларыг үржүүлээд явж байх ёстой ийм ирээдүйн өв сангийн корпорац байгуулагдаагүй шалтгааныг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо энэ талаар нь судлах хэрэгтэй.

Ер нь Төмөртогоогийн Энхтүвшин гишүүний хэлсэн тэр зөвлөмжүүд чинь байна шүү дээ Аудитын газар үндэсний үйлдвэрлэлийг сэргээхгүй л бол цаашидаа ханиш өссөөр байх болно. Төгрөг үнэгүйдсээр байх болно. Энэ уул уурхайгаас хамааралтай л зэс, нүүрсний үнэ өсөхөөр экспорт нэмэгдэхээр тэр хэмжээгээр экспорт нэмэгдэхээр л бид нар баярлаад л, зарцуулаад л энэ төсвийн урсгал зардал нэмэгддэг чинь 2024, 2025 онд төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцэл, өрийн үзүүлэлтүүдийг муужруулах маш хүнд нөхцөл болно. Яагаад гэвэл энэ ханиш хөдөлбөл уул



уурхайн бүтээгдэхүүний орлогоос орж ирсэн орлогоороо бид нар урсгал зардал, цалин тэтгэвэр тэтгэмжээ нэмэгдүүлчихлээ. Энэ тогтмол гарна шүү дээ. Тэгэхээр энэ учруулах төсөвт төлбөрийн тэнцэлд учруулах дарамт бол 2024, 2025 онд маш хүнд байгаа учраас энийг 2024 оны төсөв хийхдээ зайлиггүй тооцох шаардлага гарч байгаа юм. Нэлээн хатууруулах юм. Мөнгөний бодлого хатуурахаас өөр аргагүй болсон. Тэгээд энэ бүгдийг Төсвийн зарлагын дэд хороон дээрээ та хэд сайн ярих ёстой шүү бодлогынх нь арга хэмжээ нь.

Ингээд энэ саяын шинэчлэлтүүдээ аваад Төсвийн зарлагын хяналтын дэд хороо бусад Байнгын хороод 2 дахь хэлэлцүүлэг зохион байгуулна. Үүргээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр өг өө. Чуулган дээр өгөхгүй ээ та.

16.44 цагт

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.

**Д.Тогтохсүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн

байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ. Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгээ явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээ явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 8 санал, төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул мөн зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 3 саналыг санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй дэмжлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинэжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно. Хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын

дотоодын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Дашдондогийн Ганбат,  
Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасаллаа.

Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Дараа нь танилцуулчихъя.

**Д.Ганбат:** Улс төрийн намуудын тухай хууль ингээд эцсийн хэлэлцүүлэгтээ орчихсон байна. Нэг их санал асуулт байхгүй гээд ярьж байна. Төрийн байгуулалтын байнгын хороо чинь тийм болчихсон юм уу? Энэ чинь маш чухал хууль шүү дээ. Яагаад асуухгүй байгаа юм бол? Эсвэл та нар одоо бүх юмыг тэр хөшигний цаана хуйвалдах журмаар явуулаад байна уу яаж байна? Тэгээд 1 дүгээрт тэр.

Хоёрдугаарт хамгийн болдоггүй юм сүүлийн үеийн судалгаагаар бол энэ улс төрийн намууд чинь болохгүй байна л гэж гараад байгаа юм. Үндсэндээ өнөөдөр бол яг манай 2 хөри шиг нэг намтай бусад нь дагуул намтай болчихоод байна. Юун ардчилсан улс орон. Ийм юм удахгүй байхгүй болох гэж байна. Энэ Улс төрийн намуудын тухай хуулиа сайн хэлж, сайн ярьж орж ирээрэй гэж хэлсэн. Анх одоо Үндсэн хуулийн өөрчлөлт дээр. Энэ Үндсэн хуулийн үзэл баримтлалд энэ чинь нийцэж байна уу, нийцэхгүй байна уу, ямар байна? Хамгийн авлигалд идэгдсэн байгууллагаар энэ улс төрийн намууд тодорсон. Улс

төрийн намуудын нэр хүнд маш их унасан. Энийг энэ намуудын болон намын санхүүжилтийн хуулиар яаж шийдсэн бэ?

Хоёрдугаарт энэ улс төрийн намын бүртгэлийн асуудал гэж байгаа. Энийг Улсын Дээд шүүх дээр бүртгэдэг ээ. Уул нь ийм юм хаана ч байдаггүй ээ. Бусад улс орнуудад Сонгуулийн ерөнхий хороо л бүртгэдэг. Тэр нь ч зөв. Тэр зүйл заалт орсон уу гэх мэтчилний ийм асуултууд байна. Одоо 30 хэдэн нам байгаа. Энэ бүх намууд зарим нь тамгатай тэмдэгтэй ингээд явж байгаа. Энэ чинь цэгцрэх үү, 2 сонгууль дараалан идэвхгүй байгаа намыг яана гэгчихсэн байсан бэ? Тэрийгээ нэг тодорхой болгож өгөөч ээ.

Нөгөө талаар Монгол Улсын Ерөнхийлөгч гээд субъект байгаа. Ингээд бүх ард түмнээс сонгогддог. Нэр дэвшүүлэхдээ намууд нь дэвшүүлдэг. Энэ хүн маань ингээд зарим нь 8 жил, зарим нь 6 жил, зарим нь 4 жил ингээд ажиллаад ингээд буцаж байгаа. Энэ 8 жил энэ 4 жилд зэвсэгт хүчний ерөнхий командлагч байж байгаа. Эргээд энэ хүн маань одоо энэ намуудын үйл ажиллагаанд оролцох юм уу, оролцохгүй юм уу. Тэрийг нь тодорхой болгосон уу яасан ийм асуудал энэ жижигхэн хүн амтай, цөөхөн хүн амтай энэ улс оронд бас нэлээн тэр хүнд тусгагддаг. Тэр хүмүүсийг ёс суртахуунд нь итгээд ингээд орхичихдог. Тэр болгон амьдрал дээр энэ нь харагддаггүй ээ ийм зүйл байдаг. Энийг Улс төрийн намын тухай хуулиараа цэгцэлж өгсөн үү? Улс төрийн нам авлигаас ангид байх ийм зүйл заалт хэрэгжиж байгаа юу. Нэг нам нь нөгөө намынхаа асуудалд хөндлөнгөөс оролцохгүй байх энэ юм нь ардчиллын тэр суурь баталгаа хангагдаж байгаа юу? Тэгэхгүй бол МАН-ыг гадна, дотноос нь чиглүүлдэг, заадаг, тэгээд үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх ийм юм чинь байхгүй болчихлоо. Ялангуяа би манай намаас үг хэлж байсан Мөнх-Эрдэнийг хэлэх гээд байна. Манай нутгийн хүүхэд. Үгүй ээ энэ асуудлыг чинь шүүмжлээд хэлээд ярихаар

тэр хууль хяналтын байгууллагатай нийлээд шоронд аваачаад хийчихдэг. Ямар ч хулгай хийж байсан яаж байсан ч бусад хүмүүсийг гаргаад тавьчихдаг. Энэ яах юм МАН-д таалагдвал амьдарна, таалагдахгүй амьдрахгүй байх ёстой юм уу? Тэд нарт таалагдсан үгийг бид нар зориуд хэлэх ёстой юм уу? Энэ бүх юмнууд чинь хангагдаж байна уу яаж байна? Энэ АН-ын гишүүн байснаараа ингээд Ардчилсан нам ардчиллын төлөө үг дуугарснаараа энэ хүмүүсийн амыг хааж орон шоронд хаагаад ингэж байж байж юун олон намын систем бэ?

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн ажлын хэсгийн ахлагч, дараа нь та ярьчих.

**Д.Тогтохсүрэн:** Ганбат гишүүний асуултад хариулъя.

Энэ хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгч өргөн барьсан. Бас 2 жил гаруй энэ дээр улс төрийн намууд бас ажилласан гэж ингэж ойлгож байгаа. Хуулийн гол үзэл баримтлал ерөөсөө 2019 онд Үндсэн хуульд орсон өөрчлөлтийг л энэ хуульд тусгаж, биежүүлж, амилуулж өгч байгаа ийм асуудал байгаа. Үзэл баримтлалын хувьд 2 том асуудал байгаа юм нэгдүгээрт нь улс төрийн намыг хариуцлагатай болгож байгаа юм. Улс төрийн нам байгуулагдлаа түүнээс хойш улс төрийн намыг нэгдүгээрт идэвхгүй байдалд оруулж байгаа юм.

Хоёр дахь нь улс төрийн намыг тараах, улс төрийн намын үйл ажиллагааг зогсоох, улс төрийн намыг өөрчлөн байгуулахтай холбоотой асуудлаа зохицуулж байгаа юм. Хариуцлагын хамгийн том нэг хэлбэр нь бол яахын аргагүй идэвхгүй нам болгож байгаа юм. Улсын Их Хурлын сонгууль 2 удаа дараалан оролцоогүй бол сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлангаа аудитын байгууллагаар баталгаажуулж СЕХ-нд өгөөгүй бол 5 жилтийн дотор тухайн нам их хурлаа болон төлөөллийн төв

байгууллагын хурлаа хийгээгүй бол тухайн намыг идэвхгүйд тооцно.

Идэвхгүйд тооцсон намын санхүүжилтийг зогсооно. Дээр нь бүх шатны сонгуульд оролцохгүй ээ. Энэ бол намын хүрээндээ хийж байгаа хариуцлагын асуудал байгаа юм. 2 дахь нь санхүүжилтийн асуудал. Намын санхүүжилтийг ил тод болгож байгаа. Нэг дэх нь бол төрөөс өгч байгаа санхүүжилт дээр төрийн аудитын байгууллага жил бүр аудит хийнэ. Дээр нь тухайн намын санхүүгийн тайлан дээр жил бүр аудит хийнэ. Тухайн намын орлого зарлага, татвар, хандив бүх зүйлийг ишлэн байдлаар хяналтаа тавина. Энэ хяналтыг сонгуулийн байгууллага тавина. Улс төрийн намыг анх үүсгэн байгуулахтай холбоотой асуудлыг Дээд шүүх бүртгэнэ ээ.

Бүртгэгдсэнээс хойших үйл ажиллагааны хяналтыг Сонгуулийн ерөнхий хороо хийнэ. Тухайлбал сая хэллээ. Тэр сонгуульд оролцож байна уу, үгүй юү, санхүүжилтийг нь өгнө гэхэд зөвхөн сонгуулийн хороогоор дамжиж санхүүжилт нь явж байгаа. Тэр нь аудитын байгууллагаар баталгаажуулж өгч байна уу, үгүй юү. Дотоод ардчиллаа өргөжүүлэхийн тулд тэр хурлаа хийж байна уу үгүй юү.

Ингээд бусад бүх үйл ажиллагаанд нь хяналт тавих ажил СЕХ-гоор яв. Тэгээд бид нар бол ойлгохдоо энэ Улс төрийн намын хууль гарснаараа бол энэ Монголд үйл ажиллагаа явуулж байгаа 36 намын үйл ажиллагаа бол хуулийн хүрээнд тодорхой хүрээнд цэгцэрнэ гэж бид нар үзэж байгаа. Бусад нь Энхболд дарга нэмж хариулах байх.

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хариулна.

**Н.Энхболд:** Энэ эцсийн хэлэлцүүлэг хуулийн эцсийн хэлэлцүүлэг

явж байгаа. Ганбат гишүүний сая асуусан нэлээд олон зүйлүүд хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлгийн үеэр бүгдээрээ их дэлгэрэнгүй яригдаад олон асуулт тавиад хариулчихсан учраас энэ удаа Байнгын хороон дээр гишүүдээс асуулт, санал гараагүй. Энэний бас нөгөө тал нь юу вэ гэхээр анхны хэлэлцүүлэг хийж байх явцад илүү боловсронгуй болгох чиглэл зарим асуудлаар дахин санал хураах асуудлууд байсан.

Урьд нь дандаа яригдчихсан зүйлүүд байсан учраас гишүүдийн зүгээс яг ажлын хэсэгт орсон. Байнгын хороонд орсон гишүүдийн зүгээс энийг бие биеэсээ асуухаар тодруулаад байх зүйлүүд нь нэлээн цэгцэрчихсэн байсан. Тийм учраас асуулт хариулт гараагүй байх гэж бодож байна. Хүн болгон дотроо яагаад асуугаагүй, дотроо юу гэж бодоод асуугаагүйг би хэлж мэдэхгүй. Ямар ч байсан Байнгын хорооны хуралдаан дээр асуулт хариулт гараагүй.

Эхний хэлэлцүүлгийн явцад ярьсан зүйлүүдээ тодотгосон ийм зүйлүүд гарсан учраас онцын шаардлага гараагүй болов уу гэж ингэж бодож байна. Ер нь энэ хуулиар бид нар намууд бие биеийнхээ хэрэгт дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцоод байх нь байтугай төрийн зүгээс аль болохоор намуудын ялангуяа зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагаагаа явуулахтай холбоотой асуудлууд нь төрийн зүгээс ч хүртэл оролцохгүй байх ийм зохицуулалтуудыг хийсэн гэж ойлгож болно. Ерөнхий нийтлэг зарчмуудыг нь хуулиар тогтоож өгөөд нам ямар байх ёстой юм, Үндсэн хуульд нийцэж үйл ажиллагаагаа явуулахын тулд ер нь ямархуу хариуцлагатай үүрэгтэй байх вэ гэдэг талаас нь аваад нийтлэг хэдэн зохицуулалт орсон. Бусад нь бол маш олон асуудал намын дотоодын дүрэм журмаараа зохицуулагдахаар ингэж хуульд туссан байгаа.

Хэлэлцүүлгийн явцад ч гэсэн та түрүүн хэлсэн гучаад нам байгаа гэж. Намуудын тоогоор нь аваад үзвэл дийлэнх нь ихэнх асуудлууд намууд дотооддоо шийдэгддэг байх нь зүйтэй. Яагаад гэвэл энэ иргэдийн өөрснөө үзэл баримтлалаараа нэгдээд сайн дурын үндсэн дээр бий болсон байгууллага учраас тэр болгон руу нь бусад нь эс үгүй бол төрийн зүгээс оролцоод байх шаардлага байхгүй гэдэг асуудлууд анхны хэлэлцүүлгийн явцад хэлэлцэх эсэх явцад их гарсан учраас ийм ерөнхий зарчмыг барьж бид нар хуулиа томъёолсон гэж хэлж болох байна.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

**Д.Ганбат:** Ер нь 2 гол юм бол байгаа. Ер нь бол бид хоёр том орны дунд ингээд хавчуулагдсан ийм жижиг улс. Энэ хүртэл бид нар аятайхан яваад ирж чадсан. Цаашдаа энэ Улс төрийн намын тухай хууль энэ бусад хуулиудтай холбогдоод энэ гаднын улс орнууд намаар дамжиж энэ манай улс орны асуудалд хөндлөнгөөс оролцох ийм юмыг бид хааж чадсан уу?

Хоёрт одоо наад намын хууль чинь ингээд хэрэгжээд яваад эхлэхээр одоо ингээд харж байхад бол ганцхан МАН ба дагуул нам гэсэн ийм 2 хөрштэйгөө адилхан ийм намын системтэй бий болох нь ээ. Энэ чиглэл рүүгээ явсан. Энийг нь түлхсэн ийм юм болчхож байх шиг байна тэгээд санхүүжилтийг та нар болохоор татвар төлөгчдийн мөнгөнөөс авдаг. Ингэж санхүүждэг. Бүүр улаан цагаандаа гарсан ийм л юм болж хувирлаа гэж үзэж байна. Тэр санхүүжилтээ яаж хийх юм. Намын санхүүжилтийг Энэ одоо анх удаагаа орж ирж байх шиг байна.

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Ажлын хэсгийн ахлагч асуултад хариулна.

**Д.Тогтохсүрэн:** Санхүүжилтийн хувьд ийм байгаа. Санхүүжилтийг хуулиар тогтоож өгч байгаа, 2 чиглэлийн санхүүжилт байна.

Нэг дэх нь бол сонгуульд оролцсон улс төрийн нам сонгогчдоос авсан саналын тоогоороо санхүүжилт хийнэ. Энэ нь хамгийн доод босго нь сонгогчдын нэг хувь, нийт сонгогчдын нэг хувь буюу өнөөдрийн байдлаар 21 мянган мянган сонгогчдын саналаас дээш санал авсан нам санхүүжилт авах эрх нь нээгдэж байгаа юм. Хоёр санал байна.

Нэг дэх нь авсан саналынхаа тоогоор санхүүжилт авна.

Хоёр дахь нь Улсын Их Хуралд авсан суудлынхаа тоогоор санхүүжилт авна. Ийм 2 чиглэлээр санхүүжилт авна. Санхүүжилт нь СЕХ-гоор дамжина. СЕХ-ны төсөвт тусгагдана. Тавих хяналт нь СЕХ, аудитын байгууллагаас байна. Шинэчилсэн бүртгэл хийгдэхгүй. Улс төрийн нам.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Улс төрийн намууд нэгнийхээ дотоод хэрэгт оролцох явдал хэрээс хэтэрсэн л дээ. Тэгээд сүүлийн 3 жил манай Ардчилсан нам учраа олохгүй маш их будилж байгаа. Тэгээд би энийг бол яах вэ үйлийн үр гэж боддог юм. Манай хэдэн нөхдүүд Ардын намыг хувааж асуудал болгож байсан тэр юм нь л бид нар дээр ирж байгаа. Тэгэхдээ бид нар энэ бүх зүйлийг даван туулах ёстой гэж боддог. Тэгээд ер нь бол ингээд сүүлийн 3 жилийн нөхцөл байдлыг харахад бол тэгээд дэндүү увайгүй байна л даа. Тэгээд Ерөнхийлөгч нь төмөр замаа явуулахын тулд эрх баригчтайгаа нийлж аваад янз янз болцгоосон. Тэгээд ялагдсан намын дарга нь тамга тэмдгээ өгөхгүй тэгээд л хэдэн жил хэрүүл уруултай явлаа. Тэгээд тэр бүх зүйл нь бүгдээрээ Ардын намаас захиалгатай.

Энэ бүгд энэ юуны уршиг нь юу болж хувирч байна вэ гэхээр энэ улс орны нийгэм эдийн засгийн байдал хүндэрсэнтэй л холбоотой.

Өөрөөр хэлбэл өөдтэй сөрөг хүчин байгаагүйгээс шалтгаалаад өнөөдрийн эрх баригч нар дураараа дургих нь хэрээс хэтрээд тэгээд энэ эдийн засгийг буруу удирдаж инфляц бүх зүйл шавартай нь хутгаад л тэгээд ард түмний карманаас хойшлох замаар төсвөө бүрдүүлээд л ийм л байдалтай явж байгаа.

Тийм учраас энэ яах вэ энийг одоо яг энэ улс төрийн намын дотоод асуудалд эрх баригч нар оролцох энэ асуудлыг бас хуульчлах хэцүү л дээ. Яагаад гэвэл нөгөө талд нь нэг тийм арчаагүй нөхөр эрх баригчдын урхинд ороод л янз янз болдогтой л асуудал байгаад байгаа юм. Энэнээс болоод хэн хохирч байгаа юм. Ёстой нэг гутлынхаа улыг зулартал энэ намд зүтгэж явдаг хэдэн намын гишүүд маань л хохироод байгаа юм. Тийм учраас энэ ялангуяа энэ дээр энэ намд Улс төрийн намын тухай хууль дээр бас яг энэ төрөөс оролцох оролцоог нь багасгах тал дээр бас тодорхой заалтууд орсон гэж бас ажлын хэсэг хэлж байна. Тэгээд тэгсэн л гэж найдъя даа.

Хоёр дугаарт нь энэ парламентад суудалгүй улс төрийн намууд бас яг энэ бас Улс төрийн намын тухай хууль дээр нэлээн эсэргүүцэл илэрхийлж бас энэ ордон дотор бас акц явуулсан байгаа. Тэгээд энэ намуудын шаардлага нь юу байсан. Яг тэд, тэд тэр, тэр тэр гээд нэг хэлээд өгөөч. Тэгээд дахиж ярилцсан юм уу? Тэгээд тэр хүмүүсийн шаардлагыг энэ Улс төрийн намын тухай хуульд оруулах талаар ажилласан юм уу? Тэгэхээр бид энэ мэдээж нэг нь зүүний нам, нөгөөдөх нь баруун, төвийн нам ийм 2 нам байна. Тэрэн дотор чинь янз янзын олон ургалч бодолтой тэр хүмүүсийн нэгдэл байгаа. Хэт барууны хүмүүс ч байна, хэт зүүнийх ч байна. Янз янзын одоо энэ 2 том намд хамаарахгүй ч гэсэн өөр өөр бодол

санаатай тэр хүмүүс нэгдчихсэн байж байгаа. Тэр нэгдлийн эрх ашгийг хангах талаар ямар ярилцлага явуулж эндээ тэр тэр хүмүүсийн дургүйцээд байсан асуудлыг яаж тусгасан юм бэ гэдэг ийм асуулт байна.

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, ажлын хэсгийн ахлагч.

**Д.Тогтохсүрэн:** Улс төрийн намууд улс төрийн намуудтай энэ ажлын хэсэг Байнгын хорооны зүгээс 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж уулзалт хийж саналыг нь сонссон.

Эхнийх нь 4 сарын 20-нд, дараагийнх нь 5 сарын 16-нд билүү хэдэнд билээ 6 сарын 19 гэсэн ийм 2 удаа зохион байгуулсан. Улс төрийн намуудын тавьж байсан саналаас 2 саналыг бид нар хүлээж авсан.

Хоёр саналыг хүлээж аваагүй. Ерөнхийд нь яривал. Нэг дэх санал нь юу байна вэ гэхээр улс Сонгуулийн ерөнхий хороогоор дамжиж Улсын Дээд Шүүх бүртгэхээр байсан юм. СЕХ бүх материалд нь хяналт тавьж бүрдүүлбэр хийгээд тэрийг нь Улсын Дээд Шүүх сүүлд нь шийдвэр гаргахаар байсан юм. Тэрийг эсэргүүцсэн юм. Яагаад вэ гэхээр СЕХ гэдэг байгууллага бол парламентаас хамааралтай байгууллага.

Тийм учраас тэрүүгээр дамжуулахгүй бид нар шүүхдээ итгээд байна гэдэг ийм санал явсан учраас Улсын Дээд шүүх дээр бүх бүртгэл өөрчлөлтийг өгсөн. Улсын бүртгэлийн хуульд ч гэсэн өөрчлөлт оруулж улс төрийн нам бүртгэлтэй холбоотой асуудлыг зөвхөн ганцхан Дээд шүүх шийднэ ээ гэж байгаа юм. Тийм учраас энэ хууль дээр Дээд шүүхийн Тамгын газрын бүтэц бүрэлдэхүүнийг өргөхтэй холбоотой асуудлыг хүртэл ингээд хөндөөд ороод ирчихсэн байж байгаа.

Хоёр дахь асуудал нь санхүүжилтийн хувьд их өндөр байна гэдэг юм яриад байгаа юм. Тийм учраас бид нар санхүүжилт олгох босгыг 2 хувийг 1 хувь болгосон байгаа. Аваагүй 2 асуудал байгаа.

Нэг дэх нь тэр нөгөө идэвхгүй намд тооцохтой холбоотой санал дээр нэлээн одоо үгүй гэдэг байр суурь баримталдаг юм. Тэгээд бид нар 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөрөө нэгэнт улс төрийн намаа хариуцлагажуулна чадавхтай болгоно. Олон улсын улс төрийн намуудын хэмжээнд тэр зарчимд нийцүүлнэ гэхихсэн мөртөө улсын хэмжээнд тийм учраас бид нар энэ идэвхгүй нам гэдэг асуудлыг хүлээж авах боломжгүй гэж үзсэн юм.

Хоёр дахь юм нь тэр санхүүжилтийг ил тод байдлыг эсэргүүцээд байгаа юм. Тэрийг нь бид нар хүлээж авах боломжгүй. Нэгэнт л бид нар 2019 оны Үндсэн хуульдаа оруулаад л бүх нам шилэн байна, санхүүг нь ил тод байна гэж үзээд энэ хуульдаа ийм санал ороод ирчихсэн учраас бид нар энүүгээрээ явах ёстой.

Нэгэнт л бид нар улс төрийн намууд шинэчлэл хийе гэвэл энэ 2-ыг хийхгүйгээр шинэчилнэ гэж байхгүй юм гэж үзэж байгаа. Тийм учраас энэ 2 саналыг хүлээж авах боломжгүй гээд нөгөө 2 саналыг нь бид нар харин хүлээж авч ажлын хэсэг дээр ярилцаж байгаад энэ 2 буулт хийгээд явсан байж байгаа.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

Дараа нь зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. 11 санал байгаа.

**Б.Пүрэвдорж:** Санхүүжилтийг нэг хувь болгоно гэдэг бол та нарын хувьд бол алгаа ташаад хүлээгээд авна л даа.

Яагаад гэвэл аль болох олон намыг оролцуулж байгаад АН-ын саналыг хуваах нь та нарын туйлын зорилго байсан байхгүй юу. Үгүй ээ тийм учраас тэрийг чинь хүлээж авалгүй л яах вэ тийм ээ. Тэгээд дээрээс нь Сонгуулийн тухай хууль дээр нам болгон 39-өөс доошгүй хүн нэр дэвшүүлнэ гээд тэрнийгээ тусгаад авчихсан аль болох олон санал хуваагчтай болгохын төлөө л бүх бодлогоо хэрэгжүүлж байгаа шүү дээ. Тэгээд мэдээж энэ дээр бас хариуцлага хүлээх манай намын нөгөө Их Хурлын гишүүд бас байгаа.

Ийм саналыг дэвшүүлчихсэн оролцсон, хохирогчдыг зарчихсан байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн ажлын хэсгийн ахлагч Ардчилсан намаас энэ хуулийн төсөлтэй холбогдуулж маш олон санал өгсөн. Бараг бид 100 хувь бараг авсан. Ажлын хэсэг дээр авсан, Байнгын хороон дээр авсан, дагасан хуулиуд дээр авсан. Энэ хуулийг өргөн барихаас өмнө ч гэсэн Ерөнхийлөгчийн зүгээс улс төрийн намуудын саналыг 2, 3 удаа авч бас хуульдаа тусгаж байсан юм байна лээ. Энэ дотор бас нэг хувийн санал ч гэсэн Ардчилсан намын саналд байсан санал.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 11 санал байгаа.

Нэг.Улс төрийн намын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байгаа.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал байна.

Лхагвын Мөнхбаатар дарга чиглэл өгч өгсөн юм байна.

Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг нэмэх:

“19.4.Нам Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороотой байж болно. Хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ.

19.5.Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгохдоо энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.3-т заасныг баримталж, тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж, холбогдох журмаар тогтоосон бусад шаардлагад үндэслэнэ.

19.6.Энэ хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг намын төлөөллийн төв байгууллага батална.” Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Санал хураалт.

61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг” гэснийг “сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /С1 х Т1/ хэсгийг дараагийн жилд” гэж, 34.5.3 дахь заалтын “өгсөн бол хандивыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн” гэснийг “хүлээн авснаа мэдсэнээс хойш ажлын арван өдрийн” гэж, 34.6.5 дахь заалтын “төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, бусад удирдах албан тушаалтан”

гэснийг “төлөөлөн удирдах зөвлөлийн дарга” гэж тус тус өөрчилж, 34.6.8 дахь заалтын “нь илэрхий” гэснийг болон 34.5.4 дэх заалтыг хасаж, доор дурдсан агуулгатай 34.5.5, 34.12, 34.13 дахь хэсэг нэмэх:

“34.5.5.мөнгөн бус хандив авч байгаа тохиолдолд хандивлагчтай хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

34.12.Хуулийн этгээд намд хандив өгсөн бол хандивын хэмжээ, зориулалтыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайландаа тусгана.

34.13.Намын санхүүгийн тайланд аудит хийхээр гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хандивын талаарх баримт, мэдээллийг хандивлагчаас гаргуулан авна.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “, эсхүл ил болгоогүй” гэснийг болон 42.4 дэх хэсгийг хасаж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Нам энэ хуулийн 34.5.3-т заасны дагуу хандивыг шилжүүлээгүй бол тухайн нам хууль бусаар авсан хандивыг хоёр дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө. Ийнхүү төлөх шийдвэрийг сонгуулийн төв байгууллага гаргана.” Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Санал хураалт.

64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал:

Гуравны хоёроор дэмжигдсэн санал. Гуравны хоёроор дэмжиж Байнгын хороонд гаргасан санал юм уу? 42.2.3 гэхээр.

1.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд” гэсний дараа “зөрчлийг арилгах хүртэл” гэж, 21.4 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний дараа “хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүх” гэж, 21.5 дахь хэсгийн “дуусах хүртэл намыг” гэсний дараа “идэвхтэй, эсхүл” гэж тус тус нэмж, 21.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж өөрчилж, 21.6 дахь хэсгийг хасаж, 21.1, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Улсын дээд шүүх сонгуулийн төв байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэрийг гаргана.

21.3.Энэ хуулийн 21.1.1-д заасан зөрчил гаргасан намын эрх бүхий байгууллага сонгуульд оролцох шийдвэр гаргаж, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлсэн, эсхүл энэ хуулийн 21.1.2, 21.1.3-т заасан зөрчлөө арилгасан талаар холбогдох нотлох баримтыг сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Санал хураалт.

64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.



2.Төслийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“31 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт**

31.1.Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.

31.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

31.4.Намд төрийн санхүүжилт олгох, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг хянах, дүгнэлт гаргах, тайлагнах, нийтэд мэдээлэх, намын баримт бичиг, мэдээллийг цахим хуудаст байршуулах, шинэчлэх, хариуцлага тооцохтой холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн төрийн аудитын байгууллагын саналыг харгалзан сонгуулийн төв байгууллага батална.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Санал хураалт.

64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дэх хэсгийн “4 дүгээр сард” гэснийг “05 дугаар сард” гэж, “зохих тоогоор” гэснийг “тухай бүр эмхэтгэж” гэж, 43.8 дахь хэсгийн “иргэний, овог, нэр, оршин суугаа” гэснийг “иргэний овог, нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр, оршин байгаа” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсвийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол, Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**3 дугаар зүйл.**Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын санхүүгийн тайлан гаргах, тайланг нийтэд мэдээлэх, намыг идэвхгүйд тооцохтой холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн өдрөөс дагаж мөрдөнө.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Санал хураалт.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн талын талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн хөрөнгө авсан бол тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн бус хөрөнгө эсхүл үйлчилгээ авсан бол хууль бусаар авсан хөрөнгө, орлогыг хурааж хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Энийг Мягмар дарга энэ ажлын хэсгийнхэн хараад би бас юун дээр хэлье гэж бодож байсан юм. Торгох шийтгэл оногдуулна гэж Зөрчлийн тухай хууль дээр байгаа юм. Шууд торгоно гэдэг чинь өөрөө процесстой биз дээ. Редакцаар найруулгаар нэг авчихаар юм байна лээ. Тэгэхгүй бол шууд процессгүй явчих гээд байгаа юм, нэгт.

Хоёрт энийг уул нь эрүүлжүүлье л гэж ярьж байсан юм даа. Эрүүгийн ялтай гэж уул нь ярьж байсан. Тэгээд энийг Эрүүгийн хууль дээрээ тусгах асуудлыг бас анхаараарай

3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ер нь гэмт хэргийн шинжгүй

бол Зөрчлийн хууль руу ордог юм байна лээ. Эрүүгийн хуулиар шалгагдахгүй. Сүүлд би тодруулсан чинь. Хуулийн этгээдийн.

Санал хураалт явуулья 64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалтыг явуулна.

Дараагийн санал хураалт.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй.

Саналын томъёолол Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал. Ингээж бичиж байгаа шүү дээ. Бусад Байнгын хороо сайн анхаарч байгаарай.

Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмсүгэй:

“3.2.Улс төрийн намыг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг намын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, намын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг Улс төрийн намын тухай хуулиар зохицуулна.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Санал хураалт 64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан байна.

Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

**“1 дүгээр зүйл.** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 85.6 дахь хэсэг нэмсүгэй:

“85.6. Улсын дээд шүүхийн Тамгын газрын бүтэц, орон тоог ажлын ачаалал, онцлогийг харгалзан тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн батална. Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 25.8.8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.” Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Энэ дээр санал хэрэглэж болно. Дэмжихгүй санал.

Дашдондогийн Ганбат гишүүнээр санал тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

**Д.Ганбат:** Бид нар энэ Улс төрийн намуудын тухай хуулийг ярьж байгаа нь сайн, ингээд өөрсдөө баталж байгаа нь л сайн гэж бодож байна. Гэхдээ энэ хийх ёстой өөрчлөлтөө нэг мөсөн хийж чадахгүй байна. Тухайлбал одоо энэ шүүх засаглал бол шүүх л засаглал. Тэрэн дээрээ намыг аваачиж хутгах хэрэггүй байхгүй юу. Энэ намууд нь улс төрийн сонгуульд ороод төрийн эрхээ бариад явна.

Сонгуулийн ерөнхий хороо энийг дангаараа л хэрэгжүүлэх ёстой.

Зарим эрхийг нь СЕХ-нд өгөөд, заримыг нь Улсын Дээд шүүхэд бүртгэлийг нь тэр янз бүрийн юмыг нь өгөөд ингээд хоёрдуулаад байх юм. Ингээд энэнтэй холбогдоод Улсын Дээд шүүхийн нэр хүнд маш их унаж байгаа шүү дээ. Улсын дээд шүүхээс аягүй л бол та нар саналыг нь аваагүй байгаа даа? Аваагүй байгаа шүү дээ. Авсан юм уу? Тэгээд одоо энэ эрх баригчид юм уу эрх баригч намын дохио зангаагаар хөдөлдөг олон байгууллагатай болчихож байгаа байхгүй юу. Тэрний нэг нь Улсын дээд шүүх. Энэ юмнаасаа сургамж авдаггүй юм уу? Энийг одоо яагаад ингэж хийгээд байгаа юм бэ.

Нөгөө талаар одоо Улс төрийн намуудын тухай хууль батлагдаад, санхүүжилтийн хууль батлагдаад ингэснийхээ дараа улс төрийн намуудыг шинэчлэн бүртгэх ёстой шүү дээ. Ийм юм байхгүй болчихож байна. Тэгэхээр энэнээс өмнөх урагшаа гэсэн ийм зааг ялгаа алга болчихож байна.

Энэ юмнууд чинь одоо нэр төдий үйлчлэхгүй. Нөгөө нэг болохгүй бүтэхгүй юмтайгаа нөгөө хэл аманд өртөгдөөд байгаа нөгөө шүүмжлэгдээд байгаа намууд чинь энэ хуулийн дараа тэр юмтайгаа л буцаад л ингээд явах нь байна шүү дээ инерцээрээ. Тэр юман дээр нь цэг тавиад энэ бүх юмыг цэгцэлж өгөх ийм боломж байлаа. Энэ юмыг энэ нөхдүүд хийсэнгүй. Тэр тусмаа энэ МАН олонх байхдаа дараалаад 62, 65 суудал авчихсан байгаа үедээ нэг нүглийн нүдийг гурилаар хуурч байгаа маягтай. Өнөөдөр та нар яах вэ олонх болоод, ахиад олонх болох энэ юмны төлөө явах чинь хамаагүй ээ. Энэ чинь их сонин биш байхгүй юу.

Дараа дараагийн энэ Монгол Улсын тусгаар тогтнолын асуудал байгаа байхгүй юу. Энэ манай улсын онцлог байна шүү дээ бас. Арай гэж

ардчилалтайгаа олон намын системтэйгээ ингэж яваад 30 жил болчихсон. Одоо байхгүй болчихож байгаа байхгүй юу. Нэг намын системтэй, дагуул намтай, тавиул дарга нартай ингэж явж байгаа. Одоо энэ дээр нь нэмээд санхүүжилт өгнө гэж байгаа. Энэ юмыг буруу хийгээд ирэхээрээ бүүр байхгүй болж байгаа байхгүй юу. Тэгээд тэрний бүртгэлд энэ санхүүжилт юмыг нэг хэсгийг нь Сонгуулийн ерөнхий хороон дээр, нэг хэсгийг нь бол Улсын Дээд Шүүх дээр аваачаад өгчихөөр энэ бүх юм чинь хоёрдож байгаа юм. Энийг яг хариуцах нэг л эзэн байх ёстой байхгүй юу. Бусад улс орнуудад ийм байдаггүй байх. Энэ ямар нэгэн гаднын захиалгаар энэ юмыг гүйцэтгэдэг улсууд энэ Улсын Их Хурал дотор энэ дагуул намын тавиул дарга нартайгаа нийлээд ийм л явчихлаа шүү. Энийг би зориуд анхааруулж хэлж байна. Бодвол энэ протокол юм хумд нь бүртгэгдэх байх. Тэр байтугай эцсийн хэлэлцүүлэг дээр нь хэн ч юу ч асуудаггүй гэж байна шүү дээ. Хэн ч юу ч ярьдаггүй гээд. Ийм Улсын Их Хурал байж болдог юм уу? Энэ Улсын Их Хурал чинь мэтгэлцээний талбар юм байгаа биз дээ. Энэ чинь. Буруу зөвөө ярьж байх ёстой юм байгаа биз дээ.

Энэ улс төрийн намаар дамжуулаад энэ төрийн эрхийг чинь барьдаг биз дээ. Энэ улс төрийн намууд чинь нэр төдий юм болох нь байна энэ чинь ү үнэт зүйл үзэл санаан дээрээ байх юм уу? Тэрийг нь ялгаж салгаж өгөх юм уу? Тэрийг нь Дээд шүүх яаж мэддэг юм гэх мэтчилэнгийн ийм олон асуудлууд байна. Тэгээд одоо Улсын дээд шүүх нь ямар санал санаачилга гаргасан юм бол. Тэрийг нь мэдэхгүй юм байна. Тэгээд энэ заварсан олон намтай орооцолдоод байдаг Улсын дээд шүүхийг яаж энэ нөгөө Үндсэн хуульд заасан хараат бус бие даасан ийм шүүх ажиллаж байна гэж ард түмэн яаж итгэх юм. Тэнд чинь Эрүүгийн танхим, Иргэний танхим, Захиргааны танхим гээд тэр чиглэлээр мэргэшсэн хүмүүс байж байгаа шүү дээ.

Тэрнээс биш энэ намын ажлын талаар мэргэшсэн хүн тэнд ганц ч байхгүй шүү дээ. Ийм зүйлүүд дээрээ анхаармаар байна. Ерөөсөө энэ чинь нэг болохгүй тийшээ явчихсан байна шүү. Яах вэ ер нь хууль нь яваг батлагдаг, арай дээр болох юм болов уу гэсэн чинь нуухыг нь авах гээд нүдийг нь сохолчихсон. Ийм л ажил болсон байна. Яах вэ 2, 3 жилдээ 2024 оны сонгуулиа хараад ингээд явчихдаг. Цаана нь Монголын ард түмний эрх ашиг энэ улс орны эрх ашиг гэж байгаа юм. Энэ дээр нөхдүүд муу анхаарсан байна шүү. Энэ намын ажлын хэсгийн ажилласан энд оролцсон энэ хүмүүс дараа нь тэгээд зохих асуудлыг зохих хүмүүс яриад эхэлнэ шүү. Жоохон харалган л юм болсон байна даа. Тэгээд ер нь шинэчилж бүртгэх энэ тэр юм байхгүй юм уу, байхгүй юм байна шүү дээ та нар. Улс төрийн намуудыг шинэчилж бүртгэх хэрэгтэй шүү дээ. Үгүй ээ нэг хууль баталдаг хууль батлаад тэрнийхээ дагуу ажлаа хийдэг байх ёстой биз дээ.

**Г.Занданшатар:** Дэмжээгүй үг хэллээ.

Санал хураалт явуулъя.

66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улс төрийн намын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс хойш энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах, төсвийг шийдвэрлэх,

холбогдох журмыг батлахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо /П.Дэлгэрнаран/-нд тус тус даалгасугай.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ редакцын хувьд баталсантай холбогдуулан уг хууль хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн өдрөөс хойш үг хэн гэх ёстой Улс төрийн намын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс хойш мэдээж батлагдаж байж хүчин төгөлдөр мөрдөгдөнө шүү дээ. Тэгээд энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг шийдвэрлэх, арга хэмжээг авах. Ямар арга хэмжээ авах гээд байгаа юм.

Энийг сайн хэрэг редакц хийгээрэй энэ бас тэгэхгүй бол. Арга хэмжээ гэдэг чинь 2 л утгатай. Сахилгагүй хүнд нэг арга хэмжээ авдаг юм. Нэг бол намыг дахиж бүртгэх гээд байгаа бол тэрэндээ тодорхой заах хэрэгтэй.

Арга хэмжээ авахыг ойлгохгүй байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Саяын санал дэмжигдсэн.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

17.29 цагт

Дараагийн асуудалд оръё.

Жендерийн эрх тэгш байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Сууцгаагаарай Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна.

**М.Оюунчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулсан анхны хэлэлцүүлгийг 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа хийлээ.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсэг өмнөх хуультай нэр, овог, ажил, албан тушаал мөн адил. Дахиж танилцуулах шаардлагагүй. Дахиад танилцуулчихъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Алтангэрэлийн Бямбажаргал, ажлын хэсэг, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал тэргүүлэх аудитор Буянтогтохын Бундхорол, СЕХ-ны ажлын албаны дарга Дугардоржийн Баяндүүрэн, СЕХ-ны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал Хууль зүйн

сургуулийн профессор, Хууль зүйн доктор Одонгийн Мөнхсайхан, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн профессор Улс төр судлалын доктор Дагва-Очирын Бумдарь, судлаач доктор Эрдэнэбилигийн Гэрэлт-Од, судлаач Дагвын Энхцэцэг. Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор. Байнгын хорооноос гаргасан горимын саналуудаар санал хураалт явуулна.

Жендерийн эрх тэгш байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 53.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 59.1 хувийн саналаар санал дэмжигдсэн.

Байнгын хорооноос гаргасан горимын саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байгууллагад шилжүүлж байгаа. Ажлын хэсэгт баярлалаа.

Бямбажаргал зөвлөх ер нь Улс төрийн намын тухай хууль гайгүй гарсан биз та баталгааг нь, өргөн барьснаас чинь нэг их юм зөрөөгүй биз? Жоохон

жоохон будилаан хутгасан байна лээ шүү та нар, хариуцлагыг нь өөрсдөө л хүлээгээрэй. Мөнхсайхан уг нь гайгүй байсан юм. Үндсэн хуульд их үнэнч байсан юм. Одоо жоохон сүүлийн үед улс төрч болоод ерөөсөө ингээд улс төрийн шийдвэрийг гаргаад байдаг болчихсон байна лээ шүү дээ.

*Дараагийн асуудалд орёё. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.*

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

**А.Адьяасүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжсэн билээ.

Тус Байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал,

дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ж.Сүхбаатар нар Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 2, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар нэг зарчмын зөрөөтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Байнгын хороо Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж санал хураалт явуулж, олонхын санал авсан зарчмын зөрөөтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналыг томъёолон хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийг танилцуулъя Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн

бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Нармандахын Жамъянхүү, Монголын Үндэсний бөхийн холбооны тэргүүн Цэрэндашдоржийн Магалжав, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Дэлэгнямдоржийн Мөнхболд.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

**Б.Пүрэвдорж:** Энэ аймаг сумын баяр наадамд барилдаж байгаа бөхчүүдтэй холбоотой асуудал дээр бас нэг тийм эргэлзээтэй зүйлүүд байгаад байна. Өөрөөр хэлбэл одоо ингээд сүүлийн үед ер нь аль нэгэн аймгийнхан бусад аймгийнхаа бөхийг ерөөсөө оруулахаа больсон барилдаандаа сумынхан ч тэр. Тэгээд яаж байна гэхээр нэг ийм 2 жагсаалт гаргаж байгаа юм. Нөгөө барилдах гээд ирсэн бусад аймгийн хүмүүст болох дээр манай жагсаалт дүүрчихсэн, тэр харж байна уу? Энэ дүүрчихсэн байгаа биз гээд ингээд буцаачихдаг. Тэгээд оруулдаггүй. Тэгсэн мөртөө энэ дээр ингээд өөрийнхөө аймгийн бөхчүүдийг болохлоор ингээд оруулчихдаг. Тэгээд энэний ард яаж байна вэ гэхлээр тэр бөх нь яг барилдаж байна уу эсэх нь бас тодорхой биш. Жишээ нь Дорнод аймаг дээр өнгөрсөн жилийн наадмаар аймгийн наадамд огт энэ Улаанбаатар хотод байсан 2 хүний нэрийг 1-ийн даваанд хоёуланг нь тааруулж бүртгэгчхээд, дараагийн 2-ын даваан дээр болохоор нэг тийм хөгишин арслан тэрнийг нь нөгөө бөх нь гарч ирсэнгүй гээд шууд даваад явчихдаг.

Ингээд хэд хэдэн даваа ингээд л аваад явчихдаг. Энэнээсээ болоод тэр баахан залуучууд хохирдог. Танай дэвжээ цэг мн дээр чинь байж байгаа шүү дээ. Би нэр усаар нь гаргаад өгч болно. Тэгээд ийм юман дээрээ яаж хяналт тавих юм. Энэ одоо нөгөө нэг яах вэ нэг гарын нар бас нэг

жсоохон будилуулдаг юм байдаг л даа. Тэгэхдээ одоо сүүлийн үед нөгөө дэвжээ цэг мн-ээр гайгүй болчихсон. Одоо энэ улсын барилдаан энэ тэр чинь гайгүй болчихсон. Тэгээд аймгийн барилдаан энэ тэр чинь бүүр ингээд завхарсан юм болж байна шүү дээ. Энэ дээрээ нэг жсоохон юу яахгүй бол одоо энэ чинь тэр хүмүүс чинь өөрсдийн цаг спорт чинь цаг хугацаатай. Тэр цаг хугацаандаа энэ Монголын энэ бөхийн уламжлалт дэг жаягийн дагуу хаана ч очоод барилдах ийм боломжтой тийм л спорт. Тэгээд энэ юман дээр ингээд тэр залуу үедээ амжилтад гараад л энд тэндхийн өөрийнхөө аймаг дээр энэ нэг хэдэн бөхчүүдийг би давахгүй юм байна. Эдний наадам дээр очоод барилдчихвал нэг цол аваад тэрнийхээ дагуу жсоохон эрэмбэтэй барилдчихвал би амжилтад хүрнэ гэсэн тэр залуучуудыг бүгдийг нь байхгүй, хойш нь татчихна шүү дээ. Тэгээд би нөгөө бөх сайн мэддэг болохоор хар багаасаа.

Дээрээс нь 12 жилийн турш Ховд аймгийн бөхийн дэвжээг бас ахалсан хүний хувьд энэ бүх хүмүүс надад бас зовлонгоо яриад байна л даа. Тэгээд ингээд залуучуудыг ингээд ид насан дээр нь хохироодог. Тэгээд тэр чинь энэ сайхан уламжлал бидний энэ соёл тээгч хүмүүс байхгүй юу даа. Тэр хүмүүсийг тэгээд 1 гарыг нь даах хэдэн нөхдүүд нэг жалганы үзэл гаргаад ингээд хааж боогоод байдаг нь бол арай дэндүү л байгаад байгаа байхгүй юу даа. Тэгээд энэ дээрээ ямар арга хэмжээ авч байгаа юм? Энэ хуулиар зохицуулалт орж байгаа юу?

**Г.Занданшатар:** 80 Магалжав.

**Г.Магалжав:** Таны асуултад хариулъя.

Энэ хууль дээр 9.7 буюу Үндэсний их баяр наадмын бөхийн барилдаанд барилдах бөхийг үндэс угсаа, төрсөн газар, оршин суугаа засаг захиргааны нэгж, цол чимгээр нь ялгаварлан барилдах эрхийг хязгаарлахыг хориглоно оо гээд.



Ингээд заалт нь байгаа. Гэсэн хэдий ч орон нутагт бүртгэл хүний оролцоотой байдаг учраас таны хэлдэг саяын дутагдлууд ерөөсөө тасарч өгөхгүй байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл ҮБХ-нд аймаг орон нутаг бүртгэлээ барилдааныхаа наадмын барилдааныхаа нэг өдрийн өмнө явуулдаг. 128 юм уу, одоо өмнө нь бол 256 бөхийнхөө нэрсийг ингээд явуулчихдаг. Тэнд бүртгэж байгаа хүмүүс нь бүртгэлд хүрчихсэн, гаднын бөх барилдах боломжгүй ээ гэдэг нэг ийм зүйлүүдийг хэлээд энэ одоо чамгүй олон жил болсон юм байгаад байгаа юм. Үүнийг таслан зогсоох ганц арга нь бол манай үндэсний бөхийн салбар хороо бөхийн холбооныхон маань хамтран хэрэгжүүлж байгаа. Цахимаар одоо бүртгэл хийгдэх бүх тухайн жилийнхээ улсын наадам юм уу эсвэл аймгийн наадмынхаа нэгийг сонгож орох бусад өөр аймгуудыг хэсэж явдаг энэ хүндрэлүүд нь бас нэг ийм бүртгэлийн асуудлын хүндрэлийг үүсгэдэг учраас нэг барилдаанд сонгоод өөрөө оролцоно гэдгээр ийм цахим бүртгэлийн системийг ирэх оноос ингээд нэвтрүүлнэ гэж ингэж ажиллаж байгаа.

Ингээд хүний оролцоо багасах тусам энэ бүртгэлтэй холбоотой бөхийг нуудаг, бөхийг илүү бүртгэдэг тэгээд эндээсээ хэлмэгдэл үүсгэдэг гэдэг асуудлууд нь арилна гэж бид нар ингээд ажиллаж байгаа.

Хойтон жил энэ цахим нээлттэй бүртгэл хийдэг программ хангамжийг ажиллуулчихна гэж хэлье.

**Г.Занданшатар:** Пүрэвдорж гишүүн нэг минут.

**Б.Пүрэвдорж:** Тэгээд юм хумаа сайжруулж байвал сайн биз. Тэгэхдээ нэг зүйлийг өөрөөр хэлбэл нэгийн даваан дээр бүх гол асуудлууд байгаа шүү дээ. Ирээд бүртгүүлээгүй бөхчүүдийг бүртгэж авч байгаад ямарваа нэгэн тийм Улаанбаатар хотод байгаа хүмүүсийг нь

тэгээд л тэр орон нутагт байж байгаа мэтээр бүртгээд л тэгээд 2-ын даваанд нэгийг нь гаргаж ирэнгүүтээ гарч ирсэнгүй гээд аваад л ингээд явчхаж байна шүү дээ. Тэгээд тэр бүртгэл хийсэн тэр нөгөө нэг гарын даа нарыг дахиж оруулахгүй байх, тэнд нь суулгахгүй байх, дээрээс нь нэг жоохон хариуцлага тооцох энэ энэ чинь бидний өв соёлыг устгаад байгаа нөхдүүд байна шүү дээ. Тэр өв соёлыг устгах гээд устгахын төлөө явж байгаа тэр нөхдүүд дээр нэг жоохон хариуцлага тооцох тийм арга хэмжээ авах тэгээд тийм хуурамч юунд бүртгэлд орж өөрийгөө бүртгүүлээд барилдаагүй тэр нөхдүүд дээр барилдаанаас хасах янз янзын.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Адьшаа гишүүн 3 минут.

**Ш.Адьяа:** Энэ Үндэсний баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай асуудлыг ингээд оруулж ирж байна. Бид үндэсний бөхийн асуудлаар Үндэсний баяр наадмын хуульд бас тодорхой заалтуудыг ҮБХ-той хамтарч шийдсэн. Энэ нэг байж байгаад л ийм юм оруулаад ирж болдог юм уу Магажсаваа. Би бол одоо ингээд энэ үндэсний бөхийн талаар энэ үндэсний бөх өв соёл бол Монголчуудын бас бахархал юм гэдэг дээр их дэмжиж олон жил энд би бас өөрөө идэвх зүтгэлтэй оролцож ирж явсан хүний нэг ээ. Гэтэл энэ ҮБХ өнөөдөр өөр арга барилаар ажиллаад байгаа гэж үзэж байгаа.

Би хөдөө орон нутагт үндэсний бөхийг сурталчлах залуу бөхчүүдийг энэ бөхийг хичээллэх боломж үндэсний бөхийн ёс суртахуун дэг журмын тухай хамт явж хоёулаа ажил зохион байгуулъя гэдгийг би санал тавихад ҮБХ-ны тэргүүний хувьд та бол энд бас үл тоосон байдал гаргасан.

Дээр нь бол өнөөдөр энэ хэн нэгэн хүнд зориулсан хууль гаргаад байна. Бид нар энэ Өсөхбаяр аварга, Сүхбат аварга

гээд л зүүний, барууны манлай гэдэг ийм юмыг өчнөөн жил хэрүүлийн алим болгосон. Энд нэг талыг барьсан шийдвэр гаргадаг. Бөхчүүдийнхээ энэ талаар цаашидаа ямар дүгнэлт хийх юм? Өнөөдөр Монголын үндэсний бөхийн ёс зүйн асуудал, ёс суртахууны асуудал, түүнчлэн манлайллын асуудал. Энэ допингтой холбоотой асуудал дээр бол олон янзын ийм үйлдлүүд гарч байхад зөвхөн цолтой бөхөө хамгаалдаг. Тэр нь өнөөдөр даяаршиж байгаа нийгмийн үед олимпизмын үзэл санааны доор ҮБХ хөгжих ёстой. Бид нарын үнэт зүйл өв соёл. Гэтэл энэ дээр ямар асуудал гаргаж байна гэдгийг хэлье ээ.

Нөгөө талаасаа бас нэг зүйлийг ярьчихъя гэж бодож байна. Би Үндэсний баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын 3 гишүүнтэй хамт хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн барьсан. Энэ асуудлыг бас хэлэлцүүлж өгөөч ээ. Баяр наадам болж байна. Бид нар Үндэсний баяр наадмын тухай хуульд жороо морь уралдуулж болно гэдэг ийм хуулийг баталсан. Гэтэл урьд жилийн баяр наадамд уралдуулаагүй. Зохион байгуулаагүй. Энд энэ баяр наадмын хүмүүс энэ хуулийг баталж энэ хуулийнхаа хэрэгжилтэд хуулиа дээдлэх, ард түмнийхээ өв соёлыг дээдлэх, энэ морины соёлын талаар энэ асуудлыг би бас шийдэж өгөхийг би энэ Их Хурлын удирдлагууд, энэ бүлгийн дарга нар, Төрийн байгуулалтын байнгын хорооноос хүсэж байна. Энэ асуудал дээр Магалжав тэргүүнээс хариулт авъя.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Магалжав 80. ҮБХ-ны тэргүүн.

**Г.Магалжав:** Таны асуултад хариулъя. МҮБХ-ны үндсэн эрх үүрэг нь таны яг хэлж байгаа Монгол бөхийг сурталчлах, залуу хойч үедээ цэвэр тунгалгаар өвлүүлэх гээд энэ зүйл заалтууд байгаа. Залуу бөхчүүдийг дэмжих, залуу бөхчүүдийн барилдаан

зохион байгуулах зэрэг бүх л үйл ажиллагаанд ҮБХ Монгол бөхийн өргөөндөө зохион байгуулж ажиллаж байгаа.

Допингийн асуудал бол ганцхан үндэсний бөх гэхгүй бусад манай спортын холбоодод гарч байгаа хүндрэлтэй асуудал юм байгаа юм. Үндэсний бөхийн тамирчид допингийн асуудалд холбогдохлоор энэ асуудал их олон нийтэд их гарч ирээд байгаа юм. Бодибилдингийн холбоо, Чөлөөт бөхийн холбоо, Штангийн холбоо гээд энэ асуудал үүсдэг холбоодууд байдаг. Бөхчүүд нь зөрчлөө хүлээгээд хариуцлагаа хүлээгээд ингээд явдаг. Манайх бол шүүхддэг. Асуудлыг үүсгээд ингээд яваад байдаг юм.

Хоёр Дархан аваргын эрэмбэ бол 2014 онд Ерөнхийлөгчийн зарлигаар Даян 2 даян аваргад дархан аварга цол өгснөөс ингээд үүдэлтэй зүйл болоод явсан. Энэ дээр бол одоо мөрдөгдөж байгаа Засгийн газраас баталсан үндэсний бөхийн барилдааны дүрэм Үндэсний их баяр наадмын тухай хууль бүх зүйлд зааснаар МҮБХ эрэмбэлсэн. Энэ дээр маргах мэтгэх ямар нэгэн зүйл байхгүй ээ.

Хэрвээ энэ 2 дархан аваргын эрэмбэ өөр өөр байна гэнэ ээ гэвэл та тэр үндэслэлийг хууль зүйн хүрээнд гаргаад өгч болно оо. Тэрийг ингээд хүлээн авч ажиллаж болно. Тэр үндэслэлийг та тэгвэл гаргаж өгөх бүрэн эрх байгаа байх гэж хариулъя.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ховдынхон ч юу байх вэ Монголын их баяр наадам.

Гишүүд санал хураалт явна. Сайнзориг оо та 3-аас 3 асуулт байна. Би бас нэг гишүүний бүрэн эрхээ л эдэлж асуулт асууж үзэж байна.

Нэгдүгээрт байна шүү дээ Сайнзориг оо тулгар төрийн 2200 жилийн ой гэж ярьж болохгүй ээ. Үндэсний их баяр наадам бол тулгар төр бол тэрнээс өмнө байгуулагдсаныг ингээд түүхчид нотолчихсон, 2500, 3000 ч гээд ингээд янз янз ярьж байгаа. Энэ чинь Хүннү гүрэн байгуулагдсаны, их гүрэн байгуулагдсаны л 2200 гэж ярих нь зүйтэй. Тэгээд энийг юундаа анхаараарай.

Тэгээд Магалжав тэргүүнээс нэгдэх асуудал Монгол бөх найраагүй энэ наадамчин олноо баясгаж үнэн хүчийг үзэж барилдахад найраагүй болох талаар ямар хуулийн зохицуулалт ямар арга хэмжээ авч ажиллах вэ?

Хоёрдугаарт нь энэ 20 минут барилдаад 20 минут идэвх гараад үгүй ээ Магалжав аа чамаас юм асуугаад байна шүү дээ би. Адьшаа суу. Энэ 20 минут барилдаад 20 минут энэ Монгол бөхийн холбоо энэ найраагаа хэзээ болих юм бэ? Монгол наадмыг хэзээ гутаахаа болих юм. Ар өврийн хаалгагүй, ар өврийн хаалгагүйгээр энэ наадмыг яаж зохион байгуулах гэдэг дээр ямар бодлого байна. 20 минут барилдаад Монгол бөх нэг нь давж байх ёстой. 20 минут барилдаад 20 минут барьц сонгоод 20 минут тэгш барьц сонгоод ингээд тэгээд хэн ч ялахгүй бол идэвхээр нь ялуулна гэж байгаа юм. Энэ дээр ар, өврийн хаалга гарахгүй үзэмжээр харахгүй байх ямар баталгаа байгаа юм. Энийг одоо дүрэм журмаараа яаж зохицуулах юм. Хэн нь дээр доороо орохгүй тэгээд наадам дээр бөөн будилаан булхай үүсгэхгүй байх энэ ямар баталгаа байна. Энийг арилгах.

Гуравдугаарт нь энэ допингийн маргаан жил болгоны наадмыг гутаадаг. Допингийн эсрэг үндэсний төв энэ дээр арын хаалгагүй байх сүүлд нь янз янзын хов жив сонсогддог. Бараг л бүгдээрээ хэрэглэж байхад нэг хэсэг нь илэрчхээд нэг хэсгийг нь гүтгэчихлээ. Нэг хэсгийг нь яачихлаа гээд. Энэнийхээ баталгааг Их Хурал дээр та өгнө өв. Яаж зохицуулах

юм. Монгол төрийн их баяр наадам ёслол цэнгүүнийг нэг наадамчин олныг баясгаж, үнэн сайхан, тэгш сайхан наадам болохоос чинь энэ бас төрийн өнгө ч, наадмын өнгө ч, ард түмний өнгө ч гэсэн хамаардаг. Ард түмнийг бухимдуулахгүй наадам яаж хийх юм. Ялангуяа жилээс жилд энэ бөх дээр бол маргаан тэмцэл их байдаг байсан. Харьцангуй зохицуулагдаж байгаа, цэгцэлж байгаа юмнууд байна. Гэхдээ л хэл ам тасрахгүй байна. Энэ асуултуудад хариулж баталгаа баримтаа өгнө өв.

Ер нь тэр улсын наадмыг хүрч битгий хэл, аймаг, сумын наадмаар ард түмнийг баярлуулахгүй байгаа юм байгаа юм шүү дээ. Тийм учраас л арга ядаад л аймаг орон нутаг чинь тэгж орон нутгийн бөхөө барилдуулдаг юм гарч байгаа юм. Цолны найраа гэдэг юм бол хавтгайрсан байсан. Нэгтээ хууль батлуулж байгаа юм бол, баталж байгаа юм бол энийгээ бид нар шаардах эрхтэй.

Магалжав тэргүүн хариулна. 80. Ард түмэндээ хэлнэ ээ.

**Г.Магалжав:** Үндэсний их баяр наадмын бөхийн барилдаануудын даваа даваа болгон өөр цагтай байсан.

Энэ бол зөвхөн улсын баяр наадам гэхгүй сум аймгийн баяр наадамд хэрэгжих учраас ҮБХ-ноос таны хэлсэнчлэн даваа бүр, бөх барилдаан бүр адил цагтай байна гэдгээр ингэж оруулж ирсэн үндэсний бөхийн салбар хороо, ҮБХ-ны удирдах зөвлөл энэ олон удаа бас хуралдсан. Таны хэлж байгаа саналуудыг бид нар бас тусган үзэж байгаа. Монгол наадам бол мэдээж жилд нэг удаа зохион байгуулагддаг төрт ёсны их баяр наадам. Үүнийг бол одоо хуулиар зохицуулж байгаа. Эхлэх болон дуусах цаг байгаа. Үүнийг Бөхийн холбоо ч тэр бөхийн салбар хороо ч тэр харгалзан үзэхээс бас аргагүй зүйлүүд байгаа. Зөвхөн Монголын ард түмэн энийг үзэж байгаа биш дэлхий дээр тархан суусан 200 гаруй Монгол хүмүүс

мөн Монгол туургатнууд энийг үздэг. Цагийн зөрүүтэй газар ч байдаг. Гадаад дотоодоос ирсэн жуулчид байдаг. Тэгэхлээр бид нар энийг аль болох л бүх талын эрх ашгийг хөндөхгүйгээр баяр наадмаа хэл амгүйгээр зохион байгуулахаар ҮБХ-ны 3 сарын 18-ны өдөр баталсан бөхийн барилдааны дүрэмд оруулсан зүйл заалтыг оруулаад ингээд Засгийн газраар батлах бөхийн барилдааны дүрмийн төсөлдөө өгсөн ажиллаж байгаа.

Допингийн асуудал бол түрүүн хэлсэн. Ганцхан ҮБХ-ны асуудал биш ээ. Энэ бусад бөх спортын холбоодод хүнд байгаа асуудал. Энэ асуудал бол манай төрийн байгууллагууд ч гэсэн Төрийн бус байгууллагатайгаа хамтран ажилласны дүнд өнгөрсөн жилийн баяр наадмын 4 давсан 64 бөхөөс шинжилгээ авахад нэг бөх зөрчил гаргасан. Үүнийг ҮБХ-ны зүгээс бол их нааштай ажил явагдаж болж байна гэж ингэж үзэж байгаа. Цагаан сарын бөхийн барилдааны 16 бөхөөс бас нэг бөх допингийн шинжилгээнд бүдэрсэн асуудал үүссэн. Бусад 2 бөхийн асуудал бол бөхчүүд бөхийн дэвжээнд бөх сонирхогчдоос түүврийн аргаар буюу хамгийн их сэжиглэж байгаа гэж үзэж болох бөхчүүдийн нэрс гэдгийг ингэж аваад хамгийн их санал авсан 11 бөхөөс аваад 2 бөх ингээд гарсан ийм зүйл байгаад байгаа. Бид нар энийг багасгахын тулд энэ шинжилгээг авах давтамжийг ойртуулах, шинжилгээнд орох бөхчүүдийн тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд ч байгаа, Үндэсний их баяр наадмын Засгийн газрын батлах дүрэмд ч байгаа. Бөхийн ёс зүй гэдэг зүйл заалтууд байгаа. Энэ ёс зүй гэдэг зүйл заалтуудыг хэрэгжүүлж ажиллана. Таны түрүүн хэлсэн даваа наймаалалцах найраа гэдэг асуудлуудыг хууль хүчний байгууллагуудтай хамтраад бид нар багасгахаар таслан зогсоохоор бүх л боломжийг эрэлхийлж ажиллаж байна.

Мөн спортын авлига гэдэг зүйл заалтаар авлигатай тэмцэх хөтөлбөрт бүрэн орсон байгаа.

**Г.Занданшатар:** 82 допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Мөнхболд амлалтаа өгнө өө.

**Д.Мөнхболд:** Сайн байна уу? Үндэсний их баяр наадмын үеэр допингийн хяналтын шинжилгээг хийж байх хүмүүсийг болохлоор хөндлөнгийн хяналтын хүмүүс хянаж байгаа. Хууль хүчний байгууллагынхан болон спорттой холбоотой болсон төлөөллүүд орж ажиллаж байгаа. Мөн үүн дээр болохлоор манай байгууллагаас болохлоор камерын хяналтыг камер тавьж бичлэгжүүлж ажиллаж байгаа.

**Г.Занданшатар:** Бүрэн камержуулах хэрэгтэй. Орчин үеийн технологи ашиглах хэрэгтэй. Цагтай нартай байж болно. Тэгэхдээ камерын бичлэг үздэг дэлгэцээр харуулдаг орчин үеийн технологи, дэвшил ашигласан Монгол наадмаа нэг булхай будилаангүй сайхан тэмдэглэмээр байна шүү дээ. Та 3 наадмын комиссын гол хүн. Сайнзориг дарга хууль хяналтын байгууллагууд анхаарч энэ наадмыг хууль баталж байгаа. Наадмын өмнө хууль баталж байгаатай холбогдуулаад хэлэхэд хуультай төр засаг юм бол төрт ёсны наадмаа ном журмаар нь хийнэ шүү. Наадамчин олныг нэг үнэнхүү баярлуулж нэг цаг өөрчлөгдөж байгааг харуулах хэрэгтэй шүү дээ.

Би үг хэлж байна. Та нар ингээд л дандаа ярьж байдаг. Би бас асуулт асууж болохгүй юу. Ер нь жоохон аятайхан байхгүй бол би зүгээр хатуу шаардлага тавина шүү зүгээр. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 3 санал байгаа.

Ер нь миний үгийг хорих гээд байгаа хүн байна уу үгүй юу. Энэ

найраатай наадам найраа хийдэг улсууд ер нь хориглох гээд байна уу үгүй юу үг хэрэгцээнд байгаа улсууд.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “даян аварга;” гэсний дараа “даян аварга цолтой бөх ес даван түрүүлбэл дархан аварга;” гэж нэмэх.

Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Жамьянхорлоогийн Сүхбаатар.

Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхийн” гэснийг “Бөхийн цолны” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Жамьянхорлоогийн Сүхбаатар.

Санал хураалт. 53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна.

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Төслийн гарчгийн “өөрчлөлт” гэснийг “нэмэлт” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн ““11,” гэснийг “10,11,” гэж өөрчилсүгэй.” гэснийг ““11” гэсний өмнө “10,” гэж нэмсүгэй.” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Жамьянхорлоогийн Сүхбаатар.

Санал хураалт 62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

18.00 цагт

Дараагийн асуудалд оръё. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг танилцуулна. Индэрт урьж байна.

Энэ асуудлыг хэлэлцэж дуустал чуулганы хуралдаанаа сунгаж хуралдах саналтай байна. Дэмжиж байна уу? Гишүүдийн олонх дэмжсэн тул сунгаж хуралдъя.

**С.Чинзориг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсныг та бүхэнд танилцуулж

байна. Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйл төсвийн жил дамжин хэрэгжих арга хэмжээний зохицуулалт хэсэгт тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулж болохоор тусгасан бөгөөд мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ гэж заасан байдаг. Мөн төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт энэ хуулийн 7.7 дахь хэсэгт төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагчид хамаарахгүй гэсэн заалтыг төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан хэрэгжүүлж байна. Энэ заалтад сумын эрүүл мэндийн байгууллага болоод тосгоны эрүүл мэндийн байгууллагууд хамрагдахгүй байгаа учраас сумын эрүүл мэндийн байгууллага тосгоны эрүүл мэндийн байгууллага санхүүжилтийнхээ үлдэгдэл хөрөнгийг бие даан захиран зарцуулах эрхгүй байгаа юм.

Тийм учраас Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж сумын эрүүл мэндийн байгууллага, тосгоны эрүүл мэндийн байгууллага, аймгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн эмнэлгүүдтэй нэгэн адил төсвийнхөө үлдэгдлийг захиран зарцуулах эрх олгох гээд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулсан болно.

Та бүхнийг төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжихийг хүсэж байна.

Баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч анхан шатын тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болох сум тосгоны эрүүл мэндийн төвийн төсөв санхүүгийн үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг боловсронгуй болгох, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тоног төхөөрөмжөө шинэчлэх боломж бүрдүүлэх болон Төсвийн тухай хуулийн хүрээнд үүсээд байгаа зөрчлийг арилгах дансны үлдэгдлийг төвлөрүүлэхтэй холбогдсон зарим зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал өргөн мэдүүлсэн хуулийн өөрчлөлт нь орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үлдэгдэл хөрөнгийг захиран зарцуулах хүсэлттэй нийцэх эсэх, нийт салбарын түвшинд хэрхэн оновчтой зохицуулах талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир тус хуулийн төсөл нь сум тосгоны Эрүүл мэндийн төвүүдэд дансны үлдэгдлийг захиран зарцуулах эрхийг бүрэн нээж өгч байгаа эсэх төсвийн хэмнэлтэд хамаарах эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь

дэмжиж чуулган нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

**Г.Занданшатар:** Ирэх оны төсөв дээрээ анхаарахгүй бол болохгүй.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, ЭМЯ-ны Санхүү, эдийн Засгийн газрын газрын дарга Лхагважавын Лувсан.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Чинбүрэн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Бадарчийн Жаргалмаа гишүүн, Дамбын Батлут гишүүнээр тасаллаа. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

**Ж.Чинбүрэн:** Би дэмжиж үг хэлэх гэж байгаа юм. Энэ их чухал асуудал байгаа. Тэгэхээр энэ их чухал асуудал байгаа. Тэгээд энэ гүйцэтгэлээр санхүүждэг болсон анхан шатны тусламж үйлчилгээ ялангуяа сум тосгоны эрүүл мэндийн төвүүд бас энэ даатгалаас нэмэлт санхүүжилт авдаг. Нэлээн ажлаа бас идэвх чармайлттай хийх дээр нь бас хол газар дуудлагаар явах гэх мэтчилнээр санхүүгийн нэлээн бэрхшээлтэй байдаг бол энэ боломжууд нь сайжирч анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилт 2 дахин нэмэгдээд нэмэлт орлого олох боломж нь бас нэмэгдэж байгаа.

Үүнтэй холбоотой энэ үлдэгдлийг өөрснөө захиран зарцуулах энэ тогтолцоог хийж өгч байгаа нь маш зөв байна. Тэгээд энэ дээр дэмжиж байгаа. Би харин Чинзориг сайдаас бид 2017 онд хэрэгжих ёстой эмнэлгийн тусламжийн тухай хуулийн ТУЗ-ийн тогтолцоог улам хурдтай хэрэгжүүлэх тал дээр та энэ дээр бас анхаарах юм бол яг л адилхан энэ бие даасан тогтолцооны энэ үйл ажиллагаа улам эрчтэй болох юм. Энэ дээр та бодол саналаа хэлэхгүй юу?

**Г.Занданшатар:** Санал хэллээ, дэмжсэн үг хэллээ.

Бадарчийн Жаргалмаа гишүүн. Асуулт асуусан уу? Төсвийн Байнгын хороон даргаас уу? Уучлаарай Жаргалмаа гишүүн дараа нь. Хууль санаачлагчаас асууна л даа. Содномын Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** Чинбүрэн гишүүн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм байна. Яах вэ асуултын тухайд бол бид нар өнгөрсөн онд 3 эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалт явагдчихсан байдаг. Одоогоор бол энэ нь төлөөлөн удирдах зөвлөлийг нь баталгаажуулаагүй байгаа. Тэгээд энийг бид нар ойрын хугацаанд судалж үзэж байгаад нэгэнт сонгон шалгаруулалт явуулчихсан учраас хүчингүй болгох тийм хууль, эрх зүйн үндэс бол бага юм байна гэж үзэж байгаа. Тэгээд энэ хүрээндээ хуульд нийцүүлээд удирдах зөвлөлийг нь шинээр байгуулах асуудлыг бас шийдэх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Энэ хуулийн заалтыг бас сумын эрүүл мэндийн төвүүдээ дэмжсэн ийм боломж гэж харж байна. Өөрөөр хэлэх юм бол сумын эрүүл мэндийн төвүүд нөгөө нэг хүнд

тооцох хувьсах зардлаараа норматив зардлаараа зардал авч байгаа. Энэ санхүүжилтээ өөрсдөдөө зарцуулах тэр боломжийг бас нээж өгөх болов уу гэж бодож байна. Ер нь яг өнөөдрийн байдлаар сум дундын эмнэлгүүд болон сумын эмнэлгүүд маань ажиллах боломж бололцоо нь хэр байгаа юм.

Яагаад би ингэж асууж байна вэ гэвэл яг өнөөдрийн байдлаар нөгөө гүйцэтгэлээрээ санхүүжиж байгаа энэ тохиолдолд гүйцэтгэлээ нөгөөдөх сүлжээндээ оруулах программ хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд хүндхэн байна гэдэг зүйлийг Төв аймгийн сумын эмч нартай уулзахад бас ярьж байсан. Энэ асуудлыг нь шийдвэрлэх тал дээр ер нь хөрөнгө оруулалтын асуудлыг нь хэрхэн яаж шийдэж байгаа юм бэ? Ер нь яг нэг хүнд тооцох норматив зардал нь орон нутгийн нөхцөл байдлаасаа шалтгаалаад зөрөөтэй байгаа энэ байдал дээр бид ер нь хангалттай төсвийг тавьж өгч чадаж байгаа юу үгүй юу? Ер нь сумын бол сумын эрүүл мэндийн төв дээр нөгөө норматив зардлаараа хувьсах зардлаар авсан төсөв дээр ямар нэгэн үлдэгдэл бол бараг үлддэггүй гэдэг зүйлийг эмч нар ярьдаг. Тэгвэл яг энэ ажиллах боломжийг нь нээж өгөх гүйцэтгэлээ санхүүжүүлэх энэ боломж нь эргээд өөрсдөө үйл ажиллагаагаа идэвхжүүлэх гэдэг юм уу нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд боломж олгох тэр боломжийг нь нээж өгөхийн тулд ер нь юу хийх ёстой юм бэ? Энэ тал дээр нэг тайлбар өгөөч ээ.

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** Яах вэ эрүүл мэндийн салбарын цахимжилтын асуудал жаахан хүндхэн байгаа. Дэлхийн банкнаас төсөл хэрэгжүүлж байсан 2022 онд Дэлхийн банкны төслийн хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэлт гаргаад төслийнхөө санхүүжилтийг татчихсан. Одоо бид Хүүхдийн сангаас санхүүгийн дэмжлэг

аваад 2 сая орчим долларын санхүүгийн дэмжлэг аваад программаа бас хөгжүүлэлт хийх техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ийм арга хэмжээ авч байгаа. Дэлхийн банкны төслийн хүрээнд туришлтаар хэрэгжиж байсан анхан шатны эрүүл мэндийн байгууллага дээр ашиглагдаж байсан и госпитал программыг ашиглах боломжгүй боллоо гээд ЭМД-ын ерөнхий газар дээр ашиглагдаж байгаа программдаа хөгжүүлэлт хийх замаар сумын эрүүл мэндийн байгууллагууд өрхийн эрүүл мэндийн байгууллагууд энэ даатгалын ерөнхий газрын программыг ашигладаг болгож байгаа. Ингэснээрээ бас нэг үеэ бодвол бас нэг арай нөхцөл байдал дээрдэж байгаа гэж бол бодож байна.

Хоёр дахь асуудлын тухайд бол ер нь сумын эрүүл мэндийн байгууллагуудад бас хүндрэлтэй асуудлууд гарч байгаа юмнууд байна. Хүн ам цөөтэй аймгийн төвөөсөө Улаанбаатар хотоос нэлээн алслагдсан ийм сумуудад бас жаахан хүндрэлтэй байгаа. Бид нар ЭМД-ын үндэсний зөвлөл 01 тогтоол, 05, 12, 13 гэсэн тогтоолууддаа өөрчлөлт оруулаад газар зүйн коэффициент эд нарыг нэлээн бас боловсронгуй болгож өгөөд хүн ам цөөтэй төвөөс алслагдсан жижиг сумдын эрүүл мэндийн байгууллагуудын олгох санхүүжилтийн хэмжээг бас нэмэгдүүлэх ийм шийдвэр гаргасан.

Ингээд бас асуудал жаахан дээрдэх болов уу гэж бодож байна.

Хоёр дахь асуудал нь анхан шатын эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилт олгохдоо ажлыг нь дүгнэдэг гэрээг нь дүгнэдэг шалгуур үзүүлэлт гээд 14 шалгуур үзүүлэлтээр дүгнэж байгаа. Энэ шалгуур үзүүлэлтүүд бас нэг тийм төгс төгөлдөр болж чадаагүй байна гээ асар их санал шүүмжлэл гардаг. Энэтэй холбоотойгоор бид үндэсний зөвлөлийн шийдвэр гаргаад анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудын гэрээний



дүгнэдэг шалгуур үзүүлэлтээ боловсронгуй болгож, 14 шалгуур үзүүлэлтийг нь 9 болгож нэлээн өөрчилсөн. Нэлээн бас боловсронгуй болгож өгсөн. Ингэснээрээ сумын эрүүл мэндийн байгууллагууд, өрхийн эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтээ бас хүндрэл бэрхшээл бас багатайгаараа гүйцэтгэлийнхээ санхүүжилтийг авах ийм нөхцөл боломжийг нь бүрдүүлж өгч байна. Одоогийн Төсвийн тухай хуулиар бол төрөлжсөн эмнэлгүүд, нэгдсэн эмнэлгүүд, аймгийн нэгдсэн эмнэлгүүд, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд Төсвийн тухай хуулийн 7.9-өөр бол үлдэгдэл санхүүжилтээ захиран зарцуулах эрхтэй байгаа юм. Сумын эрүүл мэндийн байгууллагууд, өрхийн эрүүл мэндийн байгууллагууд үлдэгдэл хөрөнгөө захиран зарцуулах эрхгүй. Хаагдмал хязгаарлагдмал байдалтай байгаа учраас энийг нь нэгдсэн эмнэлгүүдтэй нь адилтган төсвийнхөө санхүүжилтийн үлдэгдлээ захиран зарцуулах эрхийг нь нээж өгч байгаа. Ингэхгүй бол аудит акт тавьдаг.

Зөрчил гэж үзэж бас зөвлөмж бас өгдөг. Ийм асуудлууд байгаад байгаа юм. Бэрхшээлтэй асуудлууд байгаад байгаа юм. Тийм учраас энэ бас бэрхшээл хүндрэлүүд бас арилах болов уу. Энэ хууль батлагдсанаар гэж. Зүгээр нэгдсэн эмнэлгүүд төрөлжсөн эмнэлгүүд бол бас хөөрхөн гүйцэтгэлийн санхүүжилтийн аргаар санхүүжилт аваад бас үлдэх санхүүжилттэй гарсан. Гэхдээ бас сумын эрүүл мэндийн байгууллагууд бас гүйцэтгэлийн санхүүжилт дээр үлдэгдэлтэй гарах нь бас хязгаарлагдмал байгаа. Гэхдээ 2022 онд бол сумын эрүүл мэндийн байгууллагуудын 70 хувь нь бас тодорхой хэмжээний санхүүжилтийн үлдэгдэлтэй гарсан байна лээ. Бас энэ бол бас нэг дэвшил гэж үзэж байгаа. Тэгээд тийм учраас бол энэ хууль батлагдсанаар сумын эрүүл мэндийн байгууллага, тосгоны эрүүл мэндийн байгууллага санхүүжүүлэх үлдэгдлийг өөрсдөө

захиран зарцуулах бас эрх боломж нь нэмэгдэх юм гэж үзэж байгаа.

**Г.Занданшатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууна. Нэг минут.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Яг энэ зүйл заалтыг энэ Төсвийн тухай хуулийн хэрэгжилт дээр сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо бол сум тосгоны өрхийн эмч нар маань эмч нар маань бас хүлээлттэй байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Нөгөө талаар эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэлт үйлчилгээ үзүүлж байгаа өрхийн эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдээ бид нар бас чадавхжуулах тал дээр бас ямар боломж байгаа оо? Өнөөдөр зөвхөн бас яг л нэг хувьсах зардлаараа үйл ажиллагаа явуулж байгаа хэдэн хүмүүс бид нар өмнө нь ярьж байсан нөгөө нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах тэр боломжийг нь бас нээх үүднээс тодорхой хэмжээний санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж өгөөч ээ гэдэг хүсэлтийг маш ихээр тавьдаг. Тэгэхээр энэ тал дээр ер нь яг ЭМЯ-ны зүгээс ямар боломж байгаа бол оо?

Та түрүүн ярьж байсан Эрүүл мэндийн тухай хууль орж ирэх гэж байгаа нийгмийн эрүүл мэндийн тухай хуулиа бид нар хэлэлцэнэ гэж. Энэ дээрээ бид нар өрийн эрүүл мэндийн төвөө дэмжсэн тэнд ажиллаж байгаа эмч мэргэжилтнүүдээ чадавхжуулсан. Өрхөд хүргэх үйлчилгээгээ чанаржуулах тэр боломж нь ер нь хэр байгаа вэ гэдэг дээр хариулт авъя. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** Яах вэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль Засгийн газар Их Хуралд өргөн барьсан. Тэгээд энэ 7 хоногийн чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд

орсон байна лээ. Маргааш Байнгын хороогоор орох юм байна гэж бодсон. Ер нь бол цаашдаа бид нар энэ өрхийн эмнэлэг гэхгүйгээр ер нь анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжих, боловсон хүчнийг нь чадавхжуулах тодорхой арга хэмжээ авна. Энэ оноос эхлээд бид нар энэ сувилагчдыг, эмч нарыг эрүүл мэндийн өрхийн эмнэлэгт ажиллаж байгаа эмч нар, сувилагч нар, сумын эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмч нар сувилагчдыг ч гэсэн гадна дотнын сургалтуудад хамруулах чадавх бэхжүүлэх ийм бас чиглэлийн тодорхой арга хэмжээнүүд авна.

Ингээд 8 сараас байх миний санаж байгаагаар анхны гадаад сургалтууд эхлэхээр төлөвлөж байгаа юм. Энэ жил ямар ч гэсэн 2-оос 3 удаагийн гадаад сургалтад өрх сумын эрүүл мэндийн эмч нар, сувилагч нарыг хамруулахаар бол төлөвлөж байгаа асуудлууд байгаа.

**Г.Занданшатар:** Дамбын Батлут гишүүн асуулт асууя.

**Д.Батлут:** Баярлалаа. 2, 3 асуулт байна. Эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилт орж ажилласнаас хойш бас нэг цөөхөн хэдэн жилийн хугацааг авч байна. Тэгээд энэ хугацаанд бас олон асуудлууд дээр Улсын Их Хурал, Засгийн газраас тодорхой алхмуудыг хийж тодорхой үр дүнгүүд бас гаргаж ажиллаж байгааг энд тэмдэглэж хэлэх нь зүйтэй байх. Сайдаас нэг асуулт байна. Энэ бүрэн гүйцэтгэлийн санхүүжилтэд ороод ажиллаж байгаа. Тэгээд анхан шатын эмнэлгүүд маань 4 төрлийн тусламж үйлчилгээгээ бүрэн гүйцэд санхүүжилтээр авах ёстой гэж зохицуулж өгсөн. Тэгээд энэ санхүүжилтийг яг бүрэн гүйцэд ЭМД-аас Даатгалын ерөнхий газраас олгож байгаа юу? Зүгээр надад ирж байгаа мэдээллүүдээр бол бас л хуучнаараа тодорхой хэмжээний квот тогтоодог, лимит тогтоодог ийм асуудлууд тасраагүй, байгаа, арилаагүй байгаа гэж

байгаа. Тэгээд ингээд ирэхээр нөгөө нэг бид нарын гаргасан шийдэл маань амьдрал дээр хэрэгжихгүй тийм үр дүнгүүд гарахгүй байгаа л зүйл шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгөөч. Та бүхэн хянаж шалгасан зүйл байдаг юм уу үгүй юу гэж?

Хоёрдугаарт нь сумын төв тосгодын анхан шатны эмнэлгүүдтэй холбоотой энэ нэг хүнд оногдох хувьсах зардалтай холбоотой асуудал дээр жоохон асуудал бий. Хүн ам цөөтэй сум тосгодын анхан шатны эмнэлгүүд бол үйл ажиллагаа явуулахад санхүүжилтийн хувьд нэлээн хүндрэлтэй нөхцөл байдлууд үүссэн гэсэн ийм зүйлүүд яригддаг. Тэгэхээр энийг бас тэнцвэржүүлэх тодорхой коэффициентыг нь өөрчилж нэмэгдүүлэх ийм асуудал ЭМЯ-ан дээр яригдаж байгаа юм аа. Яригдаж байгаа ямар байдлаар зохицуулалт хийх гэж байгаа вэ? Ямар үр дүнг хүлээж байгаа юм. Энэ сум дүүргийн, сумын, тосгодын, эрүүл мэндийн байгууллага энэ дээр нэлээн хүлээлттэй байгаа. Тэгэхээр сайдын хувьд энэ тал дээр ямар байр суурь барьж яаж ажиллаж байгаа юм бэ гэж.

Гуравдугаарт нь энэ эрүүл мэндийн системийн цахимжуулалттай холбоотой асуудлыг ярьсан. Тэр Дэлхийн банкнаас хэрэгжүүлэх төсөл ч ер нь лөөлөө болох шиг боллоо. Гэхдээ одоо хэрэгжиж байгаа нөхцөл байдал 2, 3 программ ашиглаад байх шиг байгаа юм. Тэгээд энэ 2, 3 программ нь тэгээд төдийлөн сайжруулалт хийгддэггүй, хөгжүүлэлт хийгддэггүй яг л бахь байдгаараа байдаг. Энэ өөрөө нөгөө ЭМД-ын ерөнхий газар бусад эмнэлгүүд хоорондын харилцаа холбоо хамтын ажиллагааг маш том харилцаа хамтын ажиллагаан дээр нэлээн хүндрэлүүд үүсгээд байгаа асуудлууд байна.

Заавал тэр компаниар дамждаг ч юм уу ямар нэгэн алдаа гаргавал засаж залруулахдаа хүртэл дамждаг байдлууд үүсчээд байгаа. Тэгээд 2, 3 өөр төрлийн

программ ашиглаад явж байгаа болохлоор аль нэг газраа алдаа гардаг. Давхардлууд гардаг гээд маш олон алдаа завхралууд энэ дотор байна. Энийг бид бүхэн цаашидаа яаж өөрчлөх юм бэ? Энийг нэг тийм платформд оруулаад хөгжүүлэх тал дээр яам өөрөө ямар бодлого барьж байгаа юм. Ингээд л яваад байх юм. Бид нар 3, 4 жил энэ тухайн асуудлыг ярилаа. Яриад яриад байдаг үр дүн гардаггүй.

Ингэхээр чинь цаана нь нөгөө эрүүл мэндийн байгууллагууд үндсэндээ санхүүжилттэй холбоотой асуудал нь мөн үүнээс шалтгаалаад асуудлууд үүсэх гээд байгаа шүү. Энэ программ хөгжүүлэлттэй холбоотой асуудлууд, хүндрэлтэй байгаа асуудлууд тэр тухайн толгой компаниудын бас хүнд суртал үүсгэдэг асуудлуудаас болоод нөгөө санхүүжилтээ бүрэн дүүрэн авч чадахгүй тухайн сардаа үлдэгдэлтэй хоцордог ийм асуудлууд бас үүсэж байгаа. Тэгэхээр энийг бид нар нэг мөр шийдэхийн тулд ямар зохицуулалтууд хийхээр төлөвлөж байгаа юм. Эсвэл хийж байгаа юм уу? Энэ талаараа бас мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** Бид нар гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжээд 2 жил болж байгаа. Гэхдээ би яг энэ гүйцэтгэлийн санхүүжилт эрүүл мэндийн салбарт хэр бас оновчтой үр дүнтэй хэрэгжиж байгаа юм бэ гэдгийг харуулах жил энэ 2023 он гэж л бодоод байгаа юм. 2021, 2022 онд яах вэ гүйцэтгэлийн санхүүжилт хэрэгжиж энэ аргаар санхүүжилтээ авсан. Гэхдээ нөгөө ковидын нөхцөл байдалтай байсан учраас ковидын санхүүжилт гээд улсын төсвөөс бас асар их хэмжээний мөнгө өгч байсан. Тийм учраас яг 2021, 2022 онд энэ гүйцэтгэлийн санхүүжилт хэрэгжээд яг бодитойгоор хэрэгжээд үр дүнд хүрчихлээ. Энэ нь болж байна болохгүй байна гэдэг асуудал хэлэхэд, бас жаахан

дүгнэлт хийхэд бол жаахан өрөөсгөл юм. Яг 2023 онд яг энэ гүйцэтгэлийн санхүүжилтийн арга эрүүл мэндийн салбарт хэр оновчтой яг тохиромжтой байна уу? Үгүй юү гэдгээ бас харуулах гэж байна л гэж хараад байгаа юм.

Бид нар саяхан ЭМД-ын Үндэсний зөвлөл хуралдаад хэд хэдэн шийдвэрүүд гаргасан. Ялангуяа нөгөө 01 тоот тогтоол, 05 дугаар тогтоол, 12, 13 дугаар тогтоолтой холбоотой асуудлыг нэлээн шийдсэн. Ялангуяа энэ анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилт олоход хүндрэлтэй гарч байгаа асуудал, гол нь нөгөө гэрээний биелэлтийг дүгнэхэд дүгнэдэг 14 шалгуур үзүүлэлт бас их оновчтой бус байна гэдэг асуудал маш их яригддаг. Энэ 14 шалгуур үзүүлэлтийг нь 9 шалгуур үзүүлэлт болгож нэлээн илүү тодорхой биелэлт нь гардаг, гүйцэтгэлийг нь тооцоход илүү тийм оновчтой хялбар байхаар бас нэлээн зохицуулж өгсөн.

Хоёр дахь асуудал нь энэ газар зүйн коэффициентыг нь нэлээн бас боловсронгуй болгож өгч ялангуяа хүн ам цөөтэй алслагдсан сумдууд бас санхүүжилт авах үйл ажиллагаа маш хүндрэлтэй байна. Цаашидаа бид нар энэ бус нутгийн коэффициент бас бий болгохоор шийдвэр гаргасан. Ингэж байж энэ алслагдсан хүн ам цөөтэй жижиг сумдуудын эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтээ би оновчтой авах үйл ажиллагаа хэвийн явах нөхцөл боломжийг нь бүрдүүлэх зайлиггүй шаардлагатай байна гэж үзсэн. Энэний дагуу сайдын 11 тушаалд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Ингэх юм бол бас манай салбарт энэ гүйцэтгэлийн санхүүжилтээ бас нэлээн боловсронгуй болгох ийм иж бүрэн бас шийдвэр болох болов уу гэж бодож байна.

Шулуухан хэлэхэд энэ цахим эрүүл мэндийн асуудал маш хүнд байгаа. Мөнгө байхгүй таг зогссон. 2022 онд Дэлхийн банк хэрэгжүүлж байсан төслөө

мониторинг хийгээд шинжээчийн баг ирж мониторинг хийгээд үр дүнгүй хэрэгжиж байгаа юм гээд ингээд санхүүжилтээ төслөө зогсоочихсон. Одоо тэр гүйцэтгэгч байгууллагад олгосон урьдчилсан байдлаар олгосон 1.6 сая доллароо намайг буцааж олж авч Дэлхийн банканд буцаан байршуул гэдэг ийм шаардлага тавьдаг. Би тэр гүйцэтгэгч байгууллагын шүүх цагдаад өгчихсөн. Ийм байдалтай ингээд мөнгөгүй таг зогсчихсон учраас ингээд мөнгөгүй гээд ингээд зүгээр ингээд хараад суугаад байлтай нь ч энэ санхүүжилтийн үйл ажиллагаа таг зогсох ийм нөхцөл боломж бүрдсэн учраас арга ядахдаа хүүхдийн сангаас санхүүгийн дэмжлэг бас хүссэн. Ингээд Хүүхдийн сан 2 сая долларын эх үүсвэр шийдэж өгсөн. Энэ 2 сая доллароор бид нар шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийг бас нэмэгдүүлэх серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ЭМД-ын ерөнхий газрын программ хангамжид бас хөгжүүлэлт хийх замаар өрхийн эрүүл мэндийн байгууллага, сумын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа и госпитал программыг ашиглахгүйгээр Даатгалын ерөнхий газрын программыг хөгжүүлэлт хийж тэдний программыг ашиглуулж байгаа. Ний нуугүй хэлэхэд тэр и госпитал гэдэг бол ажил хөнгөвчилсөн шуурхайлсан биш ажил маш их нэмэгдүүлсэн ачаалал нэмэгдүүлсэн.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Дэмжсэн дэмжээгүй үг хэлэх хүн байна уу? Алга байна. Салдангийн Одонтуяа гишүүн үг хэлнэ.

Тэгэхээр Чинзориг сайдад бас баяр хүргэе ээ. Ийм чухал санхүүгийн шинэчлэлийн хуулийг оруулж ирж байгаад. Ер нь бид нар энэ тэнд ажилладаг хүмүүсээ л аль болохоор энэ нэг төвлөрсөн бүх юмыг төвөөс хамаардаг бүх юмыг нь төв рүү татдаг энэ байдал чинь л хүний ажиллах

эрмэлзлийг ерөөсөө унагадаг. Тэгэхээр би бас энэ хүнд салбарын сайдын зөвлөхөөр бас ажиллаж байсан. Тэгээд энд бол нэг хэд хэдэн чухал шинэчлэл байгаа юм л даа. Эрх зүйн шинэчлэл, санхүүгийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын шинэчлэл, хүний нөөцийн шинэчлэл. Тэгээд мэдээж сэтгэхүйн шинэчлэл. Тэгэхээр бид нар энэ санхүүгийн шинэчлэлийг хийхэд энэ маш чухал хөшүүрэг болно гэж харж байгаа юм.

Яагаад гэхлээр эмнэлэг дээр ингээд хамаг л ингээд л ажилласан илүү гарсан бүх мөнгийг нь төв рүү татдаг. Тэгээд 1 цонх хагарахад л энэний мөнгийг хаана яаж шийдүүлэх вэ гэдэг л асуудлууд бодоод л байхаас биш яаж бид нар энэ сумынхаа аймгийнхаа эмнэлгийг брэнд болгож хөгжүүлэх вэ явал энэ хүмүүсээ гадагшаа алдахгүй байх вэ гэдгийг л бодоход энэ өөрөө их чухал хөшүүрэг болохоор хууль байгаа юм. Сумын эмнэлгүүд ч гэсэн зөвлөх эмч нарыг сардаа нэг удаа нэг жоохон урамшуулал өгөөд уриад ажиллуулчихдаг, эсвэл одоо энэ гадагшаа явах гэж байгаа хүмүүстээ бас нэг тодорхой асуудлуудыг нь шийдчихдэг. Ийм байвал энэ манай аймаг, сум, ялангуяа орон нутгийн энэ юу бол сайжрах юм байгаа юм. Тэгээд тэр та нар мэдэж байгаа байх гадагшаа ерөөсөө 60 сая доллар одоо энэ чинь 3 жилийн өмнөх мэдээж 60 сая доллар урсдаг байсан бол одоо бол бид нар энэ мөнгийнхөө тодорхой хэсгийг энэ дотоодынхоо өрхийн эмнэлэг, сумын эмнэлгээс бол харамлахгүй байх ёстой юм л даа. Үгүй ээ нөгөө Монгол хүнээсээ харамлаад байдаг, бүгдийг нь хурааж аваад байдаг, гэтэл гадагшаа хамаг доллар чинь урсаад байгаа. Тэгэхээр энэ бол бас энэ гадагшаа мөнгө урсахгүй байх энэ шинэчлэлийн эхлэл болж байгаа байх. Тэгээд би бас Чинзориг сайдад баяр хүргэе.

Хамгийн гол нь энэ тэр юуны асуудал байгаа юм. Энэ гүйцэтгэлээр санхүүжнэ гэхээр бүх юмыг нь төвд бол

хүн хянахад маш хэцүү. Одоо эмч нар яаж гомдоллож байна гэхээр ерөөсөө ажил хөнгөвчлөх биш ерөөсөө л тэр нэг юмыг бөглөдөг, бичдэг энэ дээр маш их цаг гарч байгаа юм. Тэгэхээр одоо юм хөгжчихсөн юм чинь зүгээр гар утсан дээр тийм аппликэйшн энэ тэр нээж болдоггүй юм уу? Одоо тэр чинь бол бараг хамаагүй хямд тусна шүү дээ. Тэгэхгүй 1 баахан программ мөнгө төлөөд л яадаг тэр нь эргээд л хуучирчихдаг, эргээд л ажилладаггүй, эсвэл хоорондоо нийлдэггүй нэг ийм байгаад байгаа юм. Тэгэхээр ялангуяа энэ манай энэ сумын төв аймаг манай дүүргийнхэн ч адилхан. Ерөөсөө эмч сувилагч нь тогтохоо байчихсан. Энэ дээр бол энэ төсвийн шинэчлэлийн энэ хууль бас чухал үүрэг гүйцэтгэх байх гэж найдаж байна. Тэгээд энэ дээр энэ хуулийг дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт. 56.8 хувийн саналаар гишүүдийн олонх төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул төслийг үзэл баримтлалыг хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон.

Анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

Маргааш өглөө 9 цагаас байнгын хороод эхэлж хуралдана.

*18.28 цагт*

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА